



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ПРОТОКОЛ

1991 оны II дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Ардын Их Хурлын хуралдааны танхимд депутатууд суудлаа эзэлсэн байв. 9.08 цагт Ардын Их Хурлын дарга, орлогчид, БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат, Дэд ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдорж нар хуралдааны танхимд орж ирэв. Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан АИХ-ын 21-р тойргийн депутат П.Мөнхдорж албан үүргээ гүйцэтгэж байгаад зуурдаар нас барсныг мэдэгдэж эмгэнэл илэрхийлэв. Ардын Их Хурлын депутатууд суудлаасаа босч талийгаачийн дурсгалыг хүндэтгэв. АИХ-ын даргын захирамжаар АИХ-ын орлогч дарга Д.Моондойгоор даргалуулсан талийгаачийг оршуулах ажил эрхлэх комисс байгуулж ажиллуулах болсныг мэдэгдэв.

Ардын Их Хурлын II хуралдааны 10 дахь өдрийн ажиллагаа өглөөний 9.14 цагт Ардын Их Хурлын танхимд эхлэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан хуралдаанд ирвэл зохих 426 депутатаас 399 нь хүрэлцэн ирсэн, ирц 93 хувьтай байгааг мэдэгдээд хуралдааны ажиллагааг эхлүүлэв.

Ж.Уртнасан бид олон хоног хуралдсан боловч тодорхой тохиолцоонд хүрч чадалгүй нэлээд хугацаа алдлаа. Цаашид та бүхэн анхаарна биз дээ. Шалгаруулах санал хураалтыг горимын хувьд цаашид мөрдөхгүй орхиод, хажуугийн саналыг үндсэн саналтай зэрэгцүүлж үзээд дийлэнх олонхиор шийдэж байвал ямар вэ? гэсэн горимын чанартай өөрчлөлтийг хийж хуралдаанд мөрдөх санал хэлэв.

Энэ журмын талаар Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдорж дэлгэрэнгүй тайлбар хэлэв.

II-р тойргийн депутат Ж.Бямбаа, 40-р тойргийн депутат Б.Дагвадорж, 63-р тойргийн депутат Х.Пүрэвдагва, 420-р тойргийн депутат Д.Гомбожав, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 39-р тойргийн депутат Д.Ламжав, 47-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 165-р тойргийн депутат Ч.Гомбосүрэн, 132-р тойргийн депутат

С.Чулуунбаатар, 215-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн горимын санал хэлэв. 56-р тойргийн депутат Р.Гончигдорж депутатуудын гаргасан горимын саналуудтай холбогдуулан тайлбар хэлэв.

Ж.Уртнасан ойлгоц төвлөрөх шиг боллоо, дэгэнд нэмэлт тайлбар оруулъя.

зөвшөөрсөн	276	77%
татгалзсан	52	14%
түдгэлзсэн	32	9%
бүгд	360	84%

Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдоржийн оруулсан томъёоллоор Дэгийн 12-р зүйлийн "Г"-гийн "тайлбар" гэсэн хэсэгт өөрчлөлт оруулж санал хураая.

зөвшөөрсөн	128	64%
татгалзсан	43	22%
түдгэлзсэн	28	14%
бүгд	199	47%

Санал хураалтанд депутатуудын 47 хувь нь оролцсон тул хүчингүйд тооцож дахин санал хураалт явуулъя. Энэ талаар тайлбарлаж Ардын Их Хурлын орлогч дарга Н.Батбаяр үг хэлэв.

зөвшөөрсөн	314	91%
татгалзсан	20	6%
түдгэлзсэн	12	3%
бүгд	346	81%

Энэ саналыг батлах санал хураалт явуулъя.

зөвшөөрсөн	345	93%
татгалзсан	17	5%
түдгэлзсэн	10	2%
бүгд	312	97%

Дэгийн талаар тохиролцоонд хүрлээ гэж үзээд ерөнхий асуудалдаа эргэн орж Улсын нэрийн талаар санал хураалт явуулав.

3.

Улсын нэр "БНМУ" гэсэн томъёоллоор санал хураав.

зөвшөөрсөн	144	43%
татгалзсан	146	43%
түдгэлзсэн	47	14%
бүгд	337	79%

Олон депутат санал хураалтад оролцоогүй тул дахин санал хураав.

зөвшөөрсөн	155	39%
татгалзсан	191	48%
түдгэлзсэн	55	13%
бүгд	401	94%

Улсын нэр "Монгол Улс" гэсэн томъёоллоор санал хураав.

зөвшөөрсөн	145	37%
татгалзсан	103	51%
түдгэлзсэн	47	12%
бүгд	395	93%

39-р тойргийн депутат Д.Ламжав юрмын санал хэлэхэд 56-р тойргийн депутат Р.Гончигдорж бидний томъёолол арай өөр юмаа гээд ойлгоцоо тодруулж ярих.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан хуралдааныг түр завсарлуулж ярилцлага хийе гэсэн хүсэлт улс төрийн хүчнүүдээс ирснийг мэдэгдэж 10.25 цагт хуралдааныг завсарлуулав.11.50 цагт Ардын Их Хурлын дарга, орлогчид хуралдааны танхимд хүрэлцэн ирж хуралдааны ажиллагааг 17.00 хүртэл хойшлуулахаар улс төрийн хүчнүүдтэй тохиролцсон болохыг мэдэгдэв.

Оройн хуралдааны ажиллагаа 17.21 цагт эхлэв.339-р тойргийн депутат Г.Чингэл хуралдаанд ирсэн байв.

Ж.Уртнасан хурлыг товч үг хэлж нээсний дараа нам,эвслийн бүлгийн зөвлөлгөөний дүнгийн талаар, тэдгээрийн удирдлагын саналыг сонсоё гэв.МАХН-ын бүлгийн ахлагч, 42-р тойргийн депутат Б.Даш-Ёндок бүлгийн гишүүдийн "БНМАУ" гэсэн нэрээр санал хураал-

гах тухай, "Ардчилсан эвсэл" бүлгийн ахлагч, 3-р тойргийн депутат Р.Барсболд хурлаа үргэлжлүүлэх, зарчмын хувьд тохиролцоогүй асуудлыг түр үлдээх, депутатуудын 4 бүлэг байгуулж төслийг шүүн хэлэлцэх, МСДН-ын бүлгийн ахлагч, 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар энэ хурал зөвшилд хүрэхгүй бол Ерөнхийлөгчийн удирдлагын дор улс төрийн бүх хүч, намуудын дугуй ширээний яриа, хэлэлцээр хийхээс өөр замгүй болоод байгааг дурдаад, үүнд хүрэхгүйн тулд зөвшилд хүрцгээх, парламентын хүрээнд асуудлыг шийдэх тухай, 9-р тойргийн депутат С.Зориг БНН, ЧХН-ын хамтарсан мэдэгдлийн тухай /уншиж сонсгов/, 10-р тойргийн депутат О.Дашбалбар Депутатуудын бие даасан бүлэг "БНМАУ" гэсэн нэрийн төлөө байгаа тухай, 22-р тойргийн депутат Л.Дашням МҮДН-ын өмнөөс үг хэлж, бүлгүүд дотроо үг хэлээ ололцох, тэдгээрийг зөвшилцөд хүргэх ажилд ахиц гаргах, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл МАХН-ын болон Депутатуудын бие даасан бүлгийн мэдэгдсэн байр суурьтай холбогдуулж МоАН-ын бүлэгт 15 минутын зөвшилцөх хугацаа олгох тухай, 288-р тойргийн депутат С.Баярцогт "Залуучууд ардчиллын төлөө" бүлгийн өмнөөс үг хэлж нам, бүлгүүд өөр хоорондоо зөвшилцөлд эаавал хүрэх, хүрсэн байх ёстойг депутатуудад ээвлэмж болгож тус тус үг хэлэв. 17.40 цагт хурлын дарга Э.Бат-Үүлийн хүсэлтийг ёсоор болгож 15 минутын завсарлага зарлав.

Хуралдаан 18.30 цагаас үргэлжлэв. Хурлын дарга МоАН-ын бүлгийн ахлагч, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүлийн саналыг сонсоё гэв.

Э.Бат-Үүл II хуралдаан шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх чадваргүй мухардалд орлоо гэж МоАН-ын бүлэг үзэж байна гээд энэ асуудлыг шинээр сонгогдох Ардын Их Хуралд нээлттэй үлдээх, үүний тулд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг өөрчилж Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийг хэлэлцэх, II хуралдааныг түр завсарлуулж намуудын бүлгийн төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсгийг Ерөнхийлөгчийн удирдлага дор байгуулах, 288-р тойргийн депутат С.Баярцогт "Залуучууд ардчиллын төлөө" бүлэг болон МСДН-ын бүлэгт 21 цаг хүртэл завсарлага өгөх, 326-р тойргийн депутат Ж.Гомбожав БНМАУ, Монгол улс гэсэн 2 нэрийг өчигдөр санал болгосон !

тухайгаа болон улсын нэр дээр санал нийлээгүй байгаа нам, эвсэл, бүлгүүдийн төлөөлөгчдөөс бүрдсэн зөвлөлдөх бүлгийг АИХ-ын нэг орлогч даргаар толгойлуулан байгуулаад уг асуудлыг нээлттэй орхиж цааш явах, 415-р тойргийн депутат Н.Ганбямба "БНМУ" гэсэн томъёоллоор дахин санал хураалгаж өгөх, 303-р тойргийн депутат Ж.Норовсамбуу "БНМАУ", "БНМУ" гэсэн 2 томъёоллоор санал хурааж аль их санал авсныг нь нээлттэй үлдээж төслөө үргэлжлэн хэлэлцэх, 234-р тойргийн депутат Д.Дэмбэрэл Ж.Норовсамбууг дэмжиж, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж С.Зоригийн хэлснээр улсын нэрийг нээлттэй орхиж цаашид төслөө хэлэлцэх, "Монгол улсын Үндсэн хууль" гэдэг хүчинтэй болох тухай болон төслийн үндсэн нэр болох "Монгол улс" гэдэг томъёоллыг БНМАУ, БНМУ гэдэгтэй хамтатган санал хураах, 327-р тойргийн депутат П.Энхсайхан "БНМУ" гэснээр санал дахин хураах, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл МоАН-ын бүлгийн саяын оруулсан саналыг хэлэлцүүлэх, 375-р тойргийн депутат Л.Баяндалай зөвшилд хүрч хуралдаанаа цаашид үргэлжлүүлэх, 40-р тойргийн депутат Б.Дагвадорж "БНМУ" гэсэн томъёоллоор дахин санал хураах, 287-р тойргийн депутат Ч.Хурц хуралдаан мухардалд ороогүй, "БНМУ" гэснээр санал хураалгаж өгөх, хуульд "Тусгаар тогтносон, бүрэн эрхт БНМАУ гэсэн" томъёолол оруулж өгөх, үүгээр санал хураалгах, 247-р тойргийн депутат Ж.Шоовдор Улсын Бага Хурал тодорхой хугацаанд /2-3 цаг/ хуралдаж төслийн юг хөндөж болох, юг болохгүй гэдгээр асуудлыг тайлбарлаж өгөх, 94-р тойргийн депутат Б.Сандуйжав депутат Ганбямбын "БНМУ" гэсэн томъёоллоор санал хураахыг дэмжиж, 50-р тойргийн депутат А.Далхжав хурлаа цаашид үргэлжлүүлэх, 9-р тойргийн депутат С.Зориг ардчилсан хүчинд 21 цаг хүртэл завсарлага хүсэх тухай тус тус үг хэлсний дараа Ж.Уртнасан товч үг хэлж хэд хэдэн санал хураалгах гэсэн боловч завсарлуулахыг депутатууд шаардсанаар санал хураалтыг хойшлуулж 21.00 цаг хүртэл завсарлага зарлав.

Хуралдаан 21.00 цагаас үргэлжилж хурлын дарга Ж.Уртнасан нам, эвслийн бүлгийн ахлагч нарын саналыг эхэлж сонсоё гэв.

3-р тойргийн депутат, "Ардчилсан эвсэл" бүлгийн ахлагч Р.Барсболд "БНМУ" гэсэн томъёоллоор санал хураалгах, 52-р тойргийн депутат, МоАН-ын бүлгийн ахлагч Э.Бат-Үүл Р.Барсболдын саналыг дэмжиж, 42-р тойргийн депутат, МАХН-ын бүлгийн ахлагч Б.Даш-Ёндон мөн саналыг дэмжиж, 22-р тойргийн депутат, МҮДН-ын бүлгийн ахлагч

Л.Дашням мөн саналыг дэмжиж, 10-р тойргийн депутат О.Дашбалбар Депутатуудын бие даасан бүлгийн өмнөөс "БНМАУ" гэсэн нэрээс буцахгүй гэдгээ мэдэгдэж энэ нэрээр санал хураалгахын төлөө байгаагаар, 24-р тойргийн депутат, МСДН-ын бүлгийн ахлагч Р.Хатанбаатар "Монгол улс" гэдгийн төлөө байгаа боловч санал хураалтад оролцоход бэлэн байгаагаар, "Залуучууд ардчиллын төлөө" бүлгийн өмнөөс 18-р тойргийн депутат Г.Ганболд "Монгол улс" гэдгийн төлөө боловч "БНМУ" гэдгээр тус бүлэг санал хураалтад оролцоход бэлэн байгааг тус тус илэрхийлж үг хэлэв.

Ирц 92 /392/ хувь байв.

Ингээд АИХ-ын дарга Ж.Уртнасан "БНМУ" гэсэн томъёоллоор санал хураав.

зөвшөөрсөн	249	64%
татгалзсан	93	24%
түдгэлзсэн	48	12%
бүгд	390	91%

Депутатууд нэмж орж ирсэн тул "БНМУ" гэснээр дахин санал хураав.

зөвшөөрсөн	268	67%
татгалзсан	87	22%
түдгэлзсэн	47	11%
бүгд	402	94%

21.08 цагт "БНМУ" гэдгээр тогтов.

О.Дашбалбар "БНМАУ" гэдгээр санал хураалгахыг хүсэв. Хурлын дарга энэ томъёоллоор санал хураахад:

зөвшөөрсөн	136	35%
татгалзсан	177	46%
түдгэлзсэн	71	19%
бүгд	384	90% болов.

О.Дашбалбар энэ санал хураалтын дүнг депутатуудын нэрээр нь гаргахыг хүсэв. Хурлын дарга үүнийг зөвшөөрөв.

21.10 цагаас төслийн удиртгал хэсгийг хэлэлцэж эхлэв.

II-р тойргийн депутат Ж.Бямба удиртгал хэсгээс "даяар олноо" гэснийг хасах, 59-р тойргийн депутат Ч.Пүрэвдорж мөн хэсэгт "энхийг эрхэмлэн" гэж оруулах, 293-р тойргийн депутат И.Бадарч "хүнлэг ардчилсан нийгэм" гэж оруулах, 246-р тойргийн депутат Н.Дашдондог ерөнхий санал, шүүмжлэл, 413-р тойргийн депутат Н.Насан-Очир нам, эвслээс бүрдсэн ажлын хэсэг байгуулаад завсарлах, 405-р тойргийн депутат Б.Лигдэн "зарлан тунхаглах ану" гэдгийг уг хэсгийн урьд нь хийж өгөх, 380-р тойргийн депутат Л.Батчулуун "нүүдлийн соёл, иргэншлийг хадгалах" гэсэн нэмэлт оруулах, 287-р тойргийн депутат Ч.Хурц "монгол улсын ард түмэн" болон "хүнлэг ардчилсан нийгэм" гэж нэмэх, 12-р тойргийн депутат Г.Очирбат "БНМУ-ын Ардын Их Хурал зарлан тунхаглаж байна" гэх, 62-р тойргийн депутат Д.Гантөмөр, "эх орноо дээдлэн хүндэлж" гэдгийг нэмэх, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж горимын санал, 151-р тойргийн депутат Б.Алгаа "хүнлэг энэрэнгүй" гэж нэмэх, 360-р тойргийн депутат Д.Найдан "эан заншил" гэж оруулах, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр "манай ард түмэн, түүний хойч үеийн сайн сайхныг ханган," гэдэг II хэсгийг шинээр нэмэх мөн "энх тайвныг эрхэмлэн" гэж оруулах, 317-р тойргийн депутат Д.Мандах депутатууд суудлаас хурлыг удирдахгүй байх, урьд гарсан саналыг давтахгүй байх тухай хэлээд Ардын Их Хурал монголын ард түмэнг бүрэн төлөөлөх эрхтэйг, 228-р тойргийн депутат Н.Адъяажав "үндэсний эв нэгдлийг дээдлэн, шударга ёсыг эрхэмлэн" гэж оруулах, 22-р тойргийн депутат Л.Дашням "улсынхаа өөрөө эрхшээн тогтох дархан эрхээ бататган" дэлхий дахинаа гэх, 84-р тойргийн депутат Н.Самат горимын санал, 296-р тойргийн депутат Л.Батжаргал "БНМУ-ын иргэн бид" гэх, 415-р тойргийн депутат Н.Ганбямба "иргэний" гэдгийг хасахгүй байх, 107-р тойргийн депутат Л.Баяндалай удиртгал хэсгийг авах, 35-р тойргийн депутат В.Бямба "бид" гэдгийг хасах, 26-р тойргийн депутат Д.Сүрэнхорлоо "энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулж" гэсэн шинэ II хэсгийг нэмэх, 32-р тойргийн депутат Д.Мандах горимын санал тус тус хэлэв.

Санал таслахаар санал хураалт явуулав.

зөвшөөрсөн	371	98%
татгалзсан	7	2%
түдгэлзсэн	1	0%
бүгд	379	89%

Удиртгал хэсгээр санал шүүмжлэлээ таслав. I бүлгийг 21.44 цагаас хэлэлцэж эхлэв.

I32-р тойргийн депутат С.Чулуунбаатар удиртгал хэсгийг хасах гэсэн депутат Л.Баяндалайн зарчмын саналаар санал хураалт явуулах, 396-р тойргийн депутат Б.Чимид горимын санал, 326-р тойргийн депутат Ж.Гомбожав түрүүн гарсан зарчмын саналуудыг шийдэж өгөх, 428-р тойргийн депутат Д.Ганболд зарчмын саналыг хэрхэн шийдэх тухай горимын санал тус тус хэлэв.

"Удиртгал хэсгийг найруулга хийж зарчмын хувьд зөвшөөрнө" гэдгээр санал хураав.

зөвшөөрсөн	366	95%
татгалзсан	14	4%
түдгэлзсэн	5	1%
бүгд	385	90%

Удиртгал хэсгийг зарчмын хувьд зөвшөөрөв.

I бүлэг "Монгол улсын бүрэн эрхт байдал" гэдгээр 21.54 цагаас санал, шүүмжлэл эхлэв.

Нэгдүгээр зүйл дээр I38-р тойргийн депутат Ц.Болдбаатар, I4-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 89-р тойргийн депутат Л.Пүрэвгял, 351-р тойргийн депутат Б.Мөнгөн, 264-р тойргийн депутат Б.Баньди, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 320-р тойргийн депутат Ч.Хишигдалай, 34-р тойргийн депутат Р.Раш, I49-р тойргийн депутат Т.Анигар нар үг хэлсний дараа санал таслахаар санал хураав.

зөвшөөрсөн	353	97%
татгалзсан	9	2%
түдгэлзсэн	2	1%
бүгд	364	85%

I-р зүйлийн 2-р хэсгээс "тэгш байдал" гэдгийг хасахаар санал хураалгах болов.

Гэвч 396-р тойргийн депутат Б.Чимид, 428-р тойргийн депутат Д.Ганболд, I53-р тойргийн депутат Д.Чойжамц, 261-р тойргийн депутат Д.Пүрэв, I42-р тойргийн депутат Л.Пүрэвдорж, 291-р

тойргийн депутат Ж.Гомбожав, 396-р тойргийн депутат Б.Чимид, 326-р тойргийн депутат Ж.Гомбожав нар горимын санал, зарим тайлбар хэлэв.

280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 59-р тойргийн депутат Ч.Пүрэвдорж нарын гаргасан "Энхийг эрхэмлэсэн гадаад бодлого" гэдгээр санал хураалт явуулав.

зөвшөөрсөн	145	43%
татгалзсан	164	49%
түдгэлзсэн	26	8%
бүгд	335	78%

Олонхийн санал авч чадсангүй.

190-р тойргийн депутат С.Пүрэвжавын "дарлал мөлжлөгөгүй, хүмүүнлэг" гэдгээр,

зөвшөөрсөн	144	42%
татгалзсан	181	53%
түдгэлзсэн	16	5%
бүгд	341	80%

Олонхийн санал авч чадсангүй.

12-р тойргийн депутат Г.Очирбатын удиртгалын эхэнд "БНМУ-ын Ардын Их Хурал зарлан тунхаглаж байна" гэдгээр санал хураахад,

зөвшөөрсөн	117	32%
татгалзсан	227	63%
түдгэлзсэн	17	5%
бүгд	361	85%

Олонхийн санал авч чадсангүй.

2-р тойргийн депутат С.Батмөнхийн "эх орондоо хүмүүнлэг, ардчилсан нийгмийг" гэдгээр,

зөвшөөрсөн	197	55%
татгалзсан	146	41%
түдгэлзсэн	12	4%
бүгд	355	83%

Олонхийн санал авав.

Үүнийг төсөлд тусгах талаар санал хураахад,

зөвшөөрсөн	183	57%	
таггалзсан	122	38%	
түдгэлзсэн	18	5%	
бүгд	323	76%	болж дийлэнх олонхийн

санал авч чадсангүй.

215-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн удиртгалын "иргэний" гэдэг үгийг удиртгалаас авахгүй байх тухай саналаа хэлэв.

Хурлын дарга хасаагүй байгаа гэдгийг анхааруулав.

296-р тойргийн депутат Л.Батжаргал, 177-р тойргийн депутат Б.Буянмөнх, 95-р тойргийн депутат Т.Төмөрбаатар, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл нарын удиртгал хэсэг болон иргэний нийгмийн тухай тодотгож асуусан асуултад Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдорж хариулав.

Удиртгал хэсгийг үндсэнд нь зөвшөөрөх тухай санал хураалтыг 22.36 цагт явуулав.

зөвшөөрсөн	379	98%
таггалзсан	3	1%
түдгэлзсэн	3	1%
бүгд	385	90%

Удиртгал хэсгийг зөвшөөрөв.

I-р зүйлийн найруулгыг хэлэлцүүлэв.

"Тэгш байдал" гэдгийг хасах гэдгээр санал хураалт явуулав.
/Зарчмын асуудал мөн эсэх/

зөвшөөрсөн	120	43%
таггалзсан	155	55%
түдгэлзсэн	5	2%
бүгд	280	66%

Дахин санал хураав /Депутатууд цөөн сролцсон учир/.

II.

зөвшөөрсөн	140	42%
татгалзсан	181	55%
түдгэлзсэн	9	3%
бүгд	330	77%

Олонхийн саналыг авч чадсангүй.

Сүлдэн дээр ажлын хэсэг томилох талаар санал хураах гэсэн боловч 39-р тойргийн депутат Д.Ламжав I-р зүйлээ хэлэлцээд бусад асуудалдаа орёё гэв. Ингээд уг асуудлыг орхиж "Их засаг хууль бол монголын Үндсэн хууль" мөн гэдгээр санал хураав.

зөвшөөрсөн	192	52%
татгалзсан	162	44%
түдгэлзсэн	14	4%

болж олонхийн санал авч чадсангүй.

"Үндэстэн ард, ястан" гэсэн томбёоллоор санал хураахад,

зөвшөөрсөн	136	36%
татгалзсан	233	61%
түдгэлзсэн	11	3%

бүгд 380 89% болсон боловч нэгд: олонхийн санал авч чадаагүй, хоёрт: депутатууд зарчмын гэж үзээгүй тул орхив.

I2-р тойргийн депутат Г.Очирбат удиртгалын эхэнд "монголын ард түмний эрх ангийг эрхэмлэн" гэж оруулах, 96-р тойргийн депутат С.Харжаубай I-р зүйлийн 2"т "үндэстний" гэх зэрэг санал хэлснийг найруулгын гэж депутатууд үзэв.

I-р зүйлийг үндсэнд нь зарчмын хувьд зөвшөөрөхөөр санал хураав.

зөвшөөрсөн	327	97%
татгалзсан	9	3%
түдгэлзсэн	0	0%
бүгд	335	78%

Нэгдүгээр зүйлийг зөвшөөрөв.

Ингээд 22.58 цагт байгууллага, хамт олон, иргэдээс хуралдааны нэр дээр ирсэн захидал, утас, цахилгааны тоймыг Ардын Их Хурлын орлогч дарга Н.Батбаяр уншиж танилцуулав.

Дараа нь Д.Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарласан Ч.Авирмэд, Б.Буджав, Батцэнгэл нарын 3 хүний тавьж байгаа шаардлагын тухай товч танилцуулаад "Ардын Их Хурлын хуралдаанд ирүүлсэн шаардах бичиг"-ийг болон Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга Б.Чимидийн тухай бичсэн 3 хуудас гомдлыг тус тус уншиж сонгов.

23.15 цагаас Ерөнхий прокурор Г.Бахдал, I орлогч Ш.Одонхүү, орлогч Ц.Алтанхуяг нараас БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат, Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан нарын нэр дээр II дүгээр сарын 20-нд ирүүлсэн бичгийг уншив.

Ж.Уртнасан энэ асуудлаар депутатын комисс байгуулж шалгуулах тухай саналтай байгаагаа мэдэгдэв.

396-р тойргийн депутат Б.Чимид чухам ямар комисс байгуулагдах гэж байгаа, хэний хүсэлтээр, хэний тавьсан асуудлыг шалгах гэж байгаа талаар тодотгож асуугаад хэрвээ өөртэй нь холбогдсон асуудлыг шалгана гэвэл хэлэх зүйл байгаа, эрүүгийн том том хэрэгтэй холбогдолтой асуудал, шалгалтын эцэст энэ хүмүүсийн үйлдэл гэмт хэрэг болж хувирвал тэд өөрсдөө хэрэгт уначих бий, үүнтэй холбогдоод би тэднийг унагаасан гэдэгт орооцолдох болно. Үүнийг би хүсэхгүй байна.Тэд энд бичсэнээ хариуцах юм уу гэдгийг тодотгох нь чухал.Энд депутатын бүрэн эрхийн асуудал ч гарч ирэх тул нарийн бодох ёстой гэв.

Ж.Уртнасан Ерөнхий прокурор, түүний орлогч нарын тэдний эсрэг явуулга, гүтгэлгийг шалган барагдуулж төрийн албан тушаалтны нэр хүндийг сэргээж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу уг асуудлаар шалгалт хийх комисс байгуулах тухай яригдсаныг хэлэв.

Үүгээр хуралдаан 23.29 цагт дуусав.

Депутатуудын ирц, соронзон бичлэгийг хавсаргав.

АРДЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ж. Уртнасан Ж. УРТНАСАН

ОРЛОГЧ ДАРГА

Н. Батбаяр Н. БАТБАЯР

Т. Жагай Т. ЖАГАЙ

Ц. Лоохууз Ц. ЛООХУУЗ

Д. Моондой Д. МООНДОЙ

ТЭМДЭГЛЭСЭН

А. Юндэндорж
Г. Хурэлбаатар

А. ЮНДЭНДОРЖ

Г. ХҮРЭЛБААТАР

II-Р САРЫН 2I-НИЙ ИРЦ

Ирвэл зохих 426

Өвчтэй: Ц.Охинтогтох /254/, Н.Сампилноров /199/,
Н.Пүрэвдорж /41/, Н.Дэлгэрмөрөн /306/, Д.Чулуун /286/,
Х.Хүзкей /83/ Т.Батмөнх /376/

Депутат Ч.Бямбаа /270/ гачигдлаар хөдөө явсан.

1991-XI-21
9.11-9.24
Кассет IY-32

Ж.Уртнасан -Депутат нөхөдөө.БНМАУ-ын Ардын Их Хурлын 21 дүгээр тойргийн депутат Пүрэв овогтой Мөнхдорж 1991 оны II дүгээр сарын 20-ны өдөр Ардын Их Хурлын хуралдааны 9 дэх өдрийн хуралдааны оройн хуралдааны үеэр үүргээ гүйцэтгэж байгаад зуурдаар нас нөгчсөн явдалд гүн эмгэнэл илэрхийлж байна.

И.Мөнхдорж 1947 онд Төв аймгийн Баян-Өнжүүл сумын нутагт малчин ардын гэр бүлд төрж, 1955-1965 онд бүрэн дунд сургууль, 1971 онд ЗХУ-ын ар талын тээврийн академи, 1984 онд зэвсэгт хүчний жанжин штабын академийг төгсчээ.Мөнхдорж 1971-1982 онд БНМАУ-ын Батлан хамгаалах яаманд офицер, албаны дарга, хэлтсийн орлогч, ерөнхий инженер, газрын орлогч дарга, газрын дарга, 1984-1985 онд БНМАУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын нэгдүгээр орлогч, газрын дарга, 1985 оноос БНМАУ-ын Батлан хамгаалах яамны орлогч сайдаар ажиллаж байлаа.

Талийгаачийн ажлын үр бүтээлийг төр засаг үнэлж, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон, Байлдааны болон ойн медалиудаар шагнажээ.

Мөнхдорж аливаа асуудалд буурь суурьтай, шударга зарчмаар ханддаг, зохион байгуулах ур дүйтэй, ард түмний үйл хэрэгт үнэнч, өөрчлөлт шинэчлэлтийн үзэл бодолтой манай зэвсэгт хүчний удирдах ажилтны нэг байсан юм.

Талийгаачийн гэгээн дурсгалыг БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдаанд оролцогсод босож хүндэтгэе.

За Ардын Их Хурлын даргын захирамжийг уншиж сонсоё.Комисс томилох тухай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, Батлан хамгаалахын дэд сайд талийгаач Мөнхдоржийг оршуулах ажлыг зохион байгуу-

лах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга Моондой, Ардын Их Хурлын орлогч дарга.

Гишүүд: Мандах БНМАУ-ын Ардын Их Хурлын ЗГҮ дугаар тойргийн депутат, Гаваа Батлан хамгаалахын тэргүүн дэд сайд, БНМАУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал, Дашзэвэг Батлан хамгаалахын дэд сайд, хошууч генерал, Ганбаатар Ардын Их Хурлын ажлын хэсгийн ахлагч, Нацагдорж БНМАУ-ын Засгийн газрын референт. Ийм захирамж гаргаж байна.

Депутат та бүгдийн өглөөний амгаланг айлтгая. Өглөөнийхөө хуралдааныг эхэлье. Уламжлал ёсоор ирцээ бүртгэе. Ирц бүртгэхэд бэлтгэнэ үү. За ирц бүртгэж байна.

Уучлаарай энэ суудлыг харах юм бол бид арай олуулаа байх шиг байх юм. Техникийн саатал болж мэдэх юм. Ирцийг дахин бүртгэе. Анхаараарай, ирц бүртгэж байна.

За баярлалаа. Нийт ирвэл зохих 427 депутатаас 399 буюу 93 хувийн ирцтэй байна. Хуралдаан хийхэд хүчин төгөлдөр байна. Ийм учраас өглөөнийхөө хуралдааны ажиллагааг нэе. Тэгэхээр хуралдааны өмнө та бүгдэд сонордуулах нэг зүйл байна. Бид нэг л зүйлийн төлөө, эх орон, ард түмнийхээ сайн сайхан ашиг тусын тулд бид энд бие сэтгэлээ зориулж байгаа. Тийм учраас бие биеэ хардаж сэрдэх, хоёр тийшээ туйлшрах, хэд хэдээрээ санал бодол дээрээ хэн хэндээ харилцан ойлголцож, харилцан зөвшилцөх, тохиролцоонд хүрэх энэ явдлыг эрхэмлэхгүй бол бид хэдэн өдрийн хуралдаан маань ямар ч үр дүнгүй талаар өнгөрч байгааг та бид эрхбиш тунгааж бодмоор байна. Ийм учраас бид бас хуралдааныг арай уян хатан, арай ухаалаг ийм байдлаар зохион байгуулмаар байна. Харилцан тохиролцоо, зөвшилцөөнд хүрч, жаахан үр дүнтэй, хууль хэлэлцэх асуудлаа жаахан үр дүнд хүргэхгүй бол бид үнэхээр гадна дотно байдал хүндэрч байгаа энэ шөнө мэдэрлээ. Ер нь өнөө шөнийн турш миний утас ажиллаж хонолоо. Ийм учраас бидэнд цаг хугацаа их шахуу, дайчин ажил-

лахыг шаардаж байна. Улс эх орныхоо сайн сайхны төлөө гэсэн нэгэн сэтгэлээр тохиролцоонд хүрмээр байна. Үзэл суртлын зарчмын саналууд дээр бид хэт туйлширч баймааргүй байна. За ингээд бид өнөөдрийн хуралдаан дээр бид нэрээ дахин хэлэлцмээр байна. Тэгэхээр шалгаруулах гэдэг асуудлыг бүр орхих нь зүйтэй. Энэ горимонд байхгүй байна гэсэн ийм асуудал гарч байгаа.

Дэгийн асуудал дээр бид бас сая ярьж тохиролцлоо. Энэн дээр санал хураах хэрэгтэй болох нь шиг байна. Зарим депутатууд ер нь одоо дийлэнх олонхийн саналаар яваад эцсийн хэлэлцүүлэгт орохдоо гуравны хоёрын саналаар баталъя гэж байна. Ердийн олонхийн саналаар яваад. Энэ ийм санал ирсэн. Гэхдээ үүнийг манай төсөл оруулж байгаа субъект хүлээж авахгүй байгаа юм.

Одоо бидний хэлэлцэх ёстой юм бол дэгд өөрчлөлт оруулах асуудлаар биш, харин нэмэлт оруулах талаар асуудлыг шийдье гэсэн ийм хувилбар байна. Зарчмын саналууд гэж гаргасан. Хажуугийн саналыг тухайн зарчмын гэж үзэх асуудлыг ердийн олонхиор л шийдээд, зарчмын болон үндсэн асуудлуудыг зэрэгцүүлэн хэлэлцэж дийлэнх олонхиор шийднэ гэсэн ийм томъёолол зөвлөж байна. Энийг дахин хэлье. Сайн яахгүй байж магадгүй юм.

Зарчмын саналууд гэж гаргасан хажуугийн саналын тухай, зарчмын гэж үзэх асуудлыг ердийн олонхиор шийдье. Өөрөөр хэлбэл асуудлыг санаачилж оруулж байгаа хажуугийн саналыг үзэх асуудлыг ердийн олонхиор шийдье.

Хоёрдугаарт зарчмын болон үндсэн саналыг зэрэгцүүлэн хэлэлцээд дийлэнх олонхийнхоор шийдье. Ойлгогдож байгаа биз дээ. Өөрөөр хэлбэл хажуугийн саналуудыг бид шүүж шүүж хэлэлцэж байгаад хамгийн олон хувь авсан нэг хажуугийн санал үлдэнэ. Үүнийг үндсэн саналтайгаа зэрэгцүүлж үзээд дийлэнх олонхийн саналаар шийднэ гэж.

Бид Дэд ерөнхийлөгчийн тайлбарыг нэг сонсьё. Тэгээд

бид хэлэлцэж тохиролцоонд хүрэх нь зүйтэй байх.

Р.Гончигдорж /БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч, 56 дугаар тойргийн депутат/ -Эрхэм депутатуудаа.Бид нар өчигдөр үнэхээр манай депутатуудын санаа нь зовж энэ дэгийнхээ асуудлаар гомдол гаргасныг хүндэтгэж үзэх ёстой байх гэж бодож байна.Тэр тусмаа манай депутатууд хууль санаачлах эрхтэй улсуудынхаа хувьд зарчмын асуудал санаачлах эрхийг нь хүндэтгэх ёстой гэж ойлгож байна. Энэ утгаар нь аливаа нэг асуудлыг хэлэлцэхээр зарлахад тэр бүлэг, зүйл, эсвэл саяын улсын нэр.Депутат өөрийнхөө саналыг гаргаад,энийг би зарчмын санал гэж үзэхийг хүсч байна гээд, энэ саналаа тавьж байгаагийн талаар тайлбар сонссоны дараачаар энэ саналыг зарчмын санал гэж үзэх үү үгүй юу гэдгийг дийлэнх олонхиор шийдвэрлэж, хэрэв дийлэнх олонхиор зарчмын санал гэж үзвэл энийг, энэ ердийн олонхиор. Ингээд ердийн олонхиор энийг зарчмын санал гэж үзвэл энэ санал маань үндсэн төсөлд оруулж ирсэн саналтай зэрэгцсэн та бүхний оюун ухаанд уралдах адил эрх олж авах юмаа гэсэн ийм байдлаар.

Тэгээд дараа нь нэг асуудал дээр олон зарчмын асуудал гарч ирж магадгүй.Тэгвэл энэ олон зарчмын асуудлуудаа авч үзэж байгаа шийдвэрлэхийн тулд зарчмын асуудлуудыг зохих ёсоор бүлэглэх учиртай болно.Тэгээд энд гол ямар хоёр зүйл дээр ялгарч байгаагийн нь олоод, тэгээд тэр асуудал дээрээ шийдвэрлэж, асуудлыг хоёр дахин цөөрүүлэх арга хэмжээ авах.Дараа нь үлдэж байгаа асуудал дээрээ хоёр дахин цөөрөх замаар, тэрнээс энэ шалгаруулалт биш, асуудлыг санал хураах болгонд зөвхөн хоёр альтернатив байхаар шийдэхгүй бол ерөөсөө болохгүй гэдэг нь харагдаж байна.

Ингээд эцэстээ шийдэхдээ бол дийлэнх олонхийнхоор шийдэх нь зүйтэй юм гэсэн ийм саналыг оруулж байгаа юм.Энэний учир шалтгаан нь бол бид энэ Үндсэн хуулиа хэлэлцэхдээ эцэстээ гуравны хоёроор шийднэ.Одоо бид нар ердийн олонхиор шийдье гэхэд шийдээд байгаа юм шиг гулсаж явж байгаад яг эцэслэн батлах

болоод гуравны хоёроор батлахдаа энэ асуудал маань дахиж зад-
 раад бүх юм эхнээсээ эхлэж байгаа мэт болох ийм байдал үүсч
 болно. Тийм учраас эхлээд л бид асуудлаа шинэ сэргэг, өргөн
 дэлгэрэнгүй ярьж байгаа анхны хэлэлцүүлэг дээрээ тохиролцоон-
 доо хүрч энэ гарч ирж байгаа зарчмын саналуудаас тохиролцооны
 хувилбар болж чадаж байгаа тэр юугаа гуравны хоёроороо шийдэх
 нь зүйтэй юм уу гэсэн ийм зүйл байна. Өөрөөр хэлбэл бид нар
 энэн дээр өөрчлөлт оруулж байгаа биш түрүүн тохирсноороо
 л тохирёё. Нэмэлт оруулж байна гэж ойлгож байна. Нэмэлт тодруу-
 лалт. Ийм л санал дээр шийдвэрлэвэл яасан юм бэ гэсэн ийм са-
 налтай байгаа юм.

Соронзон хальстай тулгаж
 нийлсэн

Дийлаус

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

Ж. Уртнасан: Асуултууд олон байх шиг байна. Микрофоныхоо дарааллаар явъя. I дүгээр микрофон Бямбаа

35 дугаар тойргийн депутат В. Бямбаа:

Өчигдөр цөөнх гээд БН Монгол Улс гэдэг асуудлыг хэлэлцүүлж явж байгаад дундуур нь горимын санал гэж бужигнуулаад, аль аль ч болоод ингээд тарсан шүү дээ. Тэгэхээр нэг асуудлаа шийдээд, зарчмын асуудлаа дийлэнх олонхиор шийднэ гэж анхнаасаа ярьж тохирчихоод хоёр асуудал байсан, хуулийн нэр, улсын нэр хоёр. Хуулийнхаа нэрийг дийлэнх олонхиороо шийдчихээд улсынхаа нэр дээр гацахаараа зэрэг энэ дэгээ өөрчилж байж, үүнийгээ аваачиж, хуучин юугаар хүчээр шийднэ гэдэг чинь буруу.

Ийм учраас улсынхаа нэрийг эхэлж, хуучин түрүүний зарчмын асуудал гэснээрээ дийлэнх олонхиор шийдсэнийхээ дараагаар дэгээ өөрчлөөд, шинээр хэлэлцэх асуудлуудаа, шинэ нэмэлт өөрчлөлт хийсэн дэгээрээ явуулах хэрэгтэй байна.

Тэгэхээр улсынхаа нэрийг дийлэнх олонхиороо нэгэнт түрүүн шийдсэн асуудлаа шийдсэний дараагаар дэгэндээ нэмэлт өөрчлөлтөө хийгээд тэгээд шинээр хэлэлцэх асуудлуудаа одоо саяны, өчигдрөөс хойш тавьсан нэгдийн горимын саналын дагуу шийдэж болж байна. Чадаагүй асуудлаа дэгээ өөрчилж байж, тулгаж шийднэ гэдэг бол энэ чинь нөгөө цөөнхийн эсрэг хүч хэрэглэсэн асуудал болж хувирч байна. Өчигдөр цөөнхийн саналыг сонсч байгаад 6 дугаар микрофон дээр тасраад зогсоон. Дундуур нь олонхийн хүн хүртэл орж ирж саналаа хэлсэн.

Ийм учраас зөвшөөрвөл БН Монгол улс гэсэн саналаа үргэлжлүүлж хэлмээр байна. Би залгаад яримаар байна. Хэрэв Хурлын дарга зөвшөөрвөл.

56 дугаар тойргийн депутат Р.Гончигдорж:

Ингэж тохирч байна шүү дээ. Зарчмын санал мөн үү, үгүй юу гэдэг асуудлыг одоо бид буцааж хэрэглэхийн шаардлагагүй байх, нэгэнт улсын З нэр дээр ярьж байгаа, тэр бол ярьж байгаа асуудал.

Ганцхан асуудал мунаас үүссэн бэ гэхээр энэ Монгол улс гэдэг маань Үндсэн их цаазын төсөлд байсан учраас ингээд үлдчихлээ гэдэг асуудлыг гэнэтхэн зарлаад, тэгээд үүнээс дэгэндээ гомдол үүссэн шүү дээ.

Тийм учраас дэгийн ийм гомдлыг арилгачихъя. Тэгээд улсынхаа З нэр дээр яаж бид зөвшилд хүрч, улсынхаа нэрийг бид шийдвэрлэж болох вэ гэдэг дээрээ ярина. Тэгэхдээ бол БН Монгол улс гэдэг дээр цөөнх болж хэлж байгаа улсуудуунийхээ дараагаар үргэлжлээд ярина. Тэгж ярих гэж байгаа улсууд энэ дэгийнхээ асуудлыг шийдсэнийхээ дараагаар л ярья. Тийм учраас эхлээд дэгээ ингээд шийдчихье. Бямбаа гуайг дахин сонсоно.

В.Бямбаа /35 дугаар тойрог/

Тэгвэл асуулт байна. Ердийн олонхийн саналаар гэж дэгээ та одоо санал хураалгаад, эвшөөрүүлснийхээ дараагаар улсынхаа нэрийг ердийн олонхиор та батлуулах гэж байгаа юм биш биз?

Р.Гончигдорж: Биш, биш. Түүнийгээ буцааж хэрэглэхээ больё гэж байна шүү дээ. Нэгэнт асуудал үүссэн буку гэнэтхэн зүйл гарахад би буцааж хэрэглэх нь хууль зүйнхээ хувьд ч тохирохгүй шүү дээ.

В.Бямбаа: За. Тэгвэл болж байнаа.

40 дүгээр тойргийн депутат Дагвадорж:

Ер нь нэлээд хэдэн хоног ажиглаад би дараах эүйлийг эаавал хэлэх нь зүйтэй юм гэж бодлоо. Тэгэхээр аливаа ажлыг чанартай хийхэд сайн зөв зохион байгуулалт хэрэгтэй байдаг. Зөв зохион байгуулахын тулд үндэслэл сайтай сайн төлөвлөгөө хэрэгтэй нь мэдээж. Энэ төлөвлөгөө өнгөрсөн туршлага, одоо, ирээдүйн төлөв байдлыг тодорхой харуулсан байх ёстой.

Бидний шийдэх гэж байгаа энэ ажлын зохион байгуулалтыг хангахад аль аль талаасаа ухаалаг байдлыг шаардана. Бид анхны нухаа хурлаас сонгож итгэл хүлээлгэсэн Улсын Бага Хурал, Ерөнхийлөгч удирдан бараг 2 жил боловсруулсан төслийг хэд хэдэн удаа нухацтай сайн хэлэлцээд, хамтын хөдөлмөрийн үр дүн болгон бидэнд төслөө хэлэлцүүлж байна.

Энэ төслийг судлахад аль ч талаас нь үзсэн агуулгаараа бидний хэлэлцэх асуудлын эх загвар нь болж болохоор санагдаж байна. Иймд Улсын Бага Хурлаас оруулж байгаа төсөлд бичигдсэн зүйлсийг үндэс гэж үзэж хэлэлцэх нь бүлэг, зүйл бүрийн өмнө үндэслэлийг нь эхлэн сонсоё гэсэн ийм саналыг би оруулж байгаа юм.

Энэ саналын үндсэн дээр хажуугийн саналыг дараа нь тус тусад нь хэлэлцэх нь зүйтэй болов уу гэж би бодож байна.

63 дугаар тойргийн депутат Х.Пүрэвдагва:

Бага Хурлын даргаа, Саяны тайлбар дээр бас эцсийн шатандаа очоод наадах чинь бүрхэг болоод, өөрөөр хэлбэл үндсэн санал, хажуугийн шалгарч ирсэн зарчмын санал энэ хоёрыг шалгаруулахад, хажуугийн санал нь дийлэнх олонхийн санал авахгүй байвал үндсэн саналаа ялахгүй байхаар ийм юманд орж байна шүү дээ, тийм үү?

Үндсэн санал нь хэвээр үлдэх гэж. Биш үү? За зүйтэй. Тэгвэл би өөрийнхөө саналыг хэлье.

Ерөөсөө Үндсэн хууль хэлэлцэх асуудал бол Их Хурлынх нь өөрийнх нь бүрэн эрхийн асуудал. Бага Хурал бол бусад хуулиудыг өөрийнхөө бүрэн эрхийн хэмжээнд хэлэлцдэг. Тэгэхээр энэ дээр онцгой тийм юм гаргаж хэрэггүй юм байна. Тэгэхээр ерөөсөө зарчмын саналууд дээрээ зүйл бүр дээр зарчмын саналууд гарч ирэх юм бол дийлэнх олонхийнхоороо яваад л энэ бол нэгдүгээр хэлэлцүүлэг дээрээ ч энэ, эцсийн хэлэлцүүлэг дээрээ ч энэ. Эцэслэн батлахдаа гуравны хоёроор явахгүй бол бид нар энэ хүнд байдлаас гарахгүй нь ээ. Энэ чинь одоо өнгөрсөн энэ 10-аад хоногийн хугацааны хэлэлцүүлэг, үүнийг чинь батлаад амьдрал харуулаад байна шүү дээ. Тийм гуравны хоёр гэдэг юмаа авъя. Авахгүй бол энэ явахгүй шүү. Ердийн олонхиор л явъя.

420 дугаар тойргийн депутат Гомбожав:

Тэгэхээр бид олон хоног хуралдлаа. Асуудал шийдэж чадахгүй байна. Тэгэхээр гадна талын маань байдал ямар янзтай байна вэ? Бид хурлаа ямар янзтай хийж байна вэ? Олон түмний уур амьсгал ямар байна вэ гэдэгт дүгнэлт хийж, энэ хурлынхаа явцыг дэгд өөрчлөлт нэмэлт хийх төдий биш, явцаа нэлээн тодорхой ярьж авч, тогтож аваад цаашаа явахгүй бол үнэхээр асуудал шийдэж чадахгүй нь ээ.

Тэгэхээр дэг дээр дэгээ ч хэлэлцье, ер нь ямар байдалтай явуулах вэ гэдэг асуудал, гадна талынхаа уур амьсгалыг ч одоо нэлээн мэдрэх хэрэгтэй байна.

Үүнтэй холбогдуулж юу хэлэх гэж байна вэ гэвэл, дэгд биднийг цааш нь явуулахгүй байгаа, хоёр, гурван үндсэн асуудал байгаа юм. Түрүүн ч улсууд ярилаа, түүнтэй санал нэг байна. Нэгдүгээрт, Үндсэн асуудал гэж орж ирж, өндөр эрхтэйгээр 66 хувийн эрхтэйгээр үлдэж байгаад, бусад хажуугийн асуудлуудыг

унагадаг энэ зарчмаас эрс татгалзах шаардлагатай байна. Адилхан асуудлууд, тийм учраас, аль алиныг нь адилхан авч хэлэлцээд, ердийн олонхиор асуудлыг шийдэхгүй бол энэ асуудал болохгүй ээ.

Хоёрдугаарт, цөөнх нь үгээ хэлж, саналаа гаргана гэдгээр хурлыг хоёр дахин, гурав дахин илүү их цаг зарахаар болгож байна. Байдлыг ч хурцдуулж байна. Цөөнх нь үг хэлэх асуудлыг хяэгаар хэмжээтэй хэлмүлье, хүндэтгэх асуудал байлгүй яах вэ? Үүнийг жишээ нь, цөөнх нь болсон хичнээн хүн байна вэ? Түүний хэдэн хувиар нь гэдэг юм бэ? ийм байдалтай найруулах уу? яаж найруулах вэ гэдгийг эрхэм депутатууд үүнийг нэлээн болгоож үзэхгүй бол ерөөсөө асуудлыг 3 дахин, хоёр дахин хэлэлцсээр байгаад болохгүй нь ээ. Энэ асуудал үнэхээр явахгүй.

Ийм учраас энэ асуудал дээр анхаармаар байна. Ер нь бид ард түмнийхээ, сонгогчдынхоо саналыг нэлээн тусгаж бодох асуудал ч хэрэгтэй байна. Ийм учраас гадна тийшээ хурал ажиллах шаардлагатай, ийм асуудлыг анхаармаар байна. Дэгд нэмэлт өөрчлөлт оруулах энэ хэдэн асуудлууд дээр зориудын анхаармаар байна.

Ер нь энд тодруулж хэлэхэд 71 хувьтай гарсан юм, 55 болоод, эцэс рүүгээ 40 хэд болоод, эргээд ингээд унаж байдаг, үндсэн төслийн асуудал гэдэг нь 66 хувьтайгаа байсаар байгаад, эрхтэйгээ үлдэж байгаа энэ асуудал бол үнэхээр ардчилал биш, үнэхээр зарчмын асуудал биш. Ер нь бичигдээгүй хууль оржирээд байгаа юм.

Яагаад вэ гэхээр үндсэн төслийн асуудал бол одоо эрхтэйгээ үлддэг гэсэн ийм асуудал, энэ хаанахын юм бэ? аль парламентын ёс юм бэ? Би нэгэн хурал дээр сууж байгаад сонссон. Энэ хэмжээгээр ч хурал хийж байсан.

Ер нь асуудлыг хэлэлцэхдээ хамгийн анхны тавьсан саналыг нэгдүгээрт хэлэлцээд, дараалан хэлэлцдэг ийм олон улсын зарчим байдаг гэдгийг тавиад үүгээр явж байсан ийм практик байгаа юм. Ингэхээр зэрэг одоо тэр 66 хувьтайгаа байдаг ноёны бөх шиг байж байдаг энэ асуудлыг өөрчлөх хэрэгтэй. Цөөнх нь гэдэг дээр онцгой анхаарах шаардлагатай байна. Энэ хэмжээгээр, эцэст нь хурлынхаа явцыг нэлээн ухаалаг хэлэлцэж, цаашаагаа алхъя. Энэ дээр цаг зарж байж хэлэлцье. Ер нь одоо яах ёстой юм бэ? Ард түмнээсээ асуудал, санал авъя.

321 дүгээр тойргийн депутат Дхагваа:

Саяны депутаттай санал нэг байна. Ийм учраас хоёр зүйлийн санал хураалт явуулж өгөөч ээ гэж хүсэх байнаа.

Нэгдүгээрт, энэ дэг дээр ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн энэ саналыг дэмжиж байна. Үүнийг санал хураалгаж өгөөч ээ.

Хоёрдугаарт, Улсын Бага Хурлаас оруулж байгаа энэ төслийн санал дээр санал адилхан хураалгаж байх ийм саналтай байна. Ийм учраас энэ дэг дээр саналыг илүү эрх олгохгүйгээр улсын Бага Хурлаас оруулж байгаа төслийг адилхан саналхурааж байх. Өчигдөр, уржигдлын бүх хурлыг удаашруулсан асуудал бол ерөөсөө энэ Улсын Бага Хурлын саналыг үлдээнэ гэсэн энэ асуудлаас болж, цөөнх боллоо ч гэсэн, үүнийг дахин дахин хэлэлцүүлж, цаг алдаж байгаа явдалд дүгнэлт хийж, үүнийгээ төсөлд оруулж өгмөөр байна.

Ийм учраас улсын Бага Хурлаас оруулж байгаа төслийн талаар санал хураана гэсэн ийм томъёоллыг дэвшүүлж байна. Ингээд үүнийг санал хурааж өгөөч ээ гэсэн ийм саналтай байна.

Ж.Уртнасан: Дэг дээр горимын саналууд ярьж байна. Ярьсан зүйлээ давхардуулалгүй явъя.

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж:

Хүндэт депутатуудад хандаж 2,3 зүйл хэлмээр байна. Яг энэ горимын саналын дагуу, дэгийн дагуу. Та бүхэн сонсооч ээ. Ямар учиртай юм бэ гэхээр бид гуравны хоёроор хажуугийн саналыг оруулах, хэрвээ гуравны хоёроос дээш санал авах юм бол хажуугийн санал үндсэн төсөл рүү орж, үндсэнх төсөл дээр байгаа тухайн асуудал хасагдаж байна гэсэн ийм зарчмыг барьж байгаа. Энэ нь туйлын ээв гэж бодож байна. Үүнийгээ би тайлбарлая.

Нэгдүгээрт, бид нар ард түмнээр 2 жил шахам хэлэлцүүлсэн Улсын Бага Хурлаар 2 удаа хэлэлцсэн, Монголын энэ хуулийн төлөө зүрх сэтгэл нь зовж явдаг, энэ ардчиллын төлөө зүрх сэтгэл нь зовж явдаг бүхэн, монголчууд бүгдээрээ оролцож бүтээсэн, энэ их цаазынхаа төслийг бид нар хүндэтгэж байгаа юм.

Энэ Их цаазын төсөлд орсон тэр үг, өгүүлбэрийг та бүхэн өөрчилье гэж бодож байгаа бол та бүхэнд тэр эрх чинь бий.

Та бүхэн үнэхээр сайн үндэслэл гаргаж ирээд, гуравны хоёроос дээш санал аваад тэр хажуугийн саналыг Их цаазын төсөл рүү орж байх ёстой. Ийм учраас энэ төсөл байгаа юм.

Тийм биш бол дээр нь үндсэн хууль гэж биччихээд, ардын Их Хурлын депутат бүхэн босч, нэг нэг өгүүлбэр хэлээд тэнд нь санал хураалгаад, гуравны хоёр авсан өгүүлбэр бүрийг оруулаад тэгээд их цаазаа хийгээд батлаад явъя. Тэгвэл Их цаазаа бид нар нэг өдөр батална. Тэгээд 30 хоног 30 хууль баталчихаад яваад өгье. Ийм юм байдаггүй ээ.

Төслөө барьж, төслөө хүндэтгэж, тэр саналаа хүндэтгэж, та бүхэнд шийдвэр гаргаад тэр рүү оруулах бүрэн эрх байгаа, та бүхэнд хэлэх бүрэн үндэслэл байгаа. Ингэхгүй бол нэрийг нь тавиад л, өгүүлбэр хэлээд л, гуравны хоёроор гар өргөөд л тэтгэвэр, тэтгэмж, бүх хуулиа хэдүүлээ дахин баталчихаад л яваад өгье.

Тэгэх юм бол нэг өдөр л нэг хууль батлах боломжтой гэж би бодож байна.

Дараагийн нэг зүйлийг хэлье гэж бодсон юм. Юу вэ гэхээр энэ гуравны хоёр гэдгийг төслөөс ердөөсөө авч болохгүй, төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ямар нэгэн асуудал байхгүй. БНМАУ гэдэг санал 71 хувь авчихаад байхад хүмүүс дуугарахгүй байсан, дараа нь 49 хувь аваад, явахгүй болоод ирэхээр ердийн олонхи болгоё гээд, ердийн олонхиор түлхэж, энэ төслийг бүгдийг нь ердийн олонхиор явуулаад хуучин 60 оны Үндсэн хуулийг дахин гаргаж ирэх гэж байна. Ийм юмыг тэвчиж чадахгүй ээ. Гуравны хоёроороо байх ёстой. Төслөө хүндэтгэх ёстой. Та бүхний ур ухаан, та бүхний чадал тэвчээр тэр бүхэн хүрээд, үндэслэл хүрдэг л юм бол төсөлд байгаа үгийг та нар гуравны хоёроос дээш санал авахуулж байж оруулах ёстой гэж бодож байна.


Нэг зүйлийг сануулъя. Монгол улсын Үндсэн хууль гэсэн нэр дээр бүхлээр нь 4 үгийг зэрэг хураасан санал дээр 69 хувийн санал аваад одоо байж байгаа. Их засаг гэсэн хууль гэсэн санал 74 хувийн санал аваад байж байгаа. Өөр төсөлд ороон үүнээс өөр юм одоогоор байхгүй байгаа шүү. Дараагийн нэг зүйд байна. Хэлэхгүй бол болохгүй нь ээ гэж бодож байна.

Үнэхээр энд шинэ ардчилсан төрийн тогтолцоогоо хамгаалах, үүнийг бэхжүүлэх, батжуулахын төлөө та бүгд бид байгаа.

Ер нь энэ Их Хурлын хуралдах чадварын тухай, энэ их Хуулийн энэ чимхлүүр ажлыг хийх чадварын тухай хүмүүс ярьж байгаа. Миний хувьд бол би сонгогчдоо юу гэж бодсон бэ гэхээр энэ Их хуулийг л батлахад би оролцох, энэ бол надад хүлээлгэж байгаа хамгийн өндөр хариуцлага, миний хамгийн том ачаа гэж би үзэж, сонгогчиддоо ч хэлж байсан, тэгж ч энэ алаг тэмдгийг авсан. Ардын Их Хурлын депутатын улаан үнэмлэхийг авсан.

Хэрвээ явахгүй асуудлыг ийм байдлаар олонхийн байдлаар далайл-
 гэж ингэж шийдэх гэх юм бол би энэ алаг тэмдгээ тайлж тавиад,
 улаан үнэмлэхээ тавиад явж болно. Үүнийг олон депутат хийж
 чадна. Ардын Их Хурлын ирц ч энэ тохиолдолд хүрэхгүй байж болно.
 Дараагийн нэг асуудал Бага Хурлынхныг янз бүрээр хэлж байгаа.
 Бага Хурлын 53 суудал бол ард түмний санал асуулгаар бий бол-
 сон суудалшүү. Ард түмний санал асуулгаар бий болоод, би үүнийг
 хэлэх ёстой. Ийм байдлаар гуравны хоёрыг энэ дэгээс авч хаяна
 гэх юм бол та нар ердийн олонхиороо далайлгаад, Монголд эргүүлж,
 зүгээр л эргүүлээд хуулийн замаар ердийн олонхиороо далайлгаж
 бүх юмыг хуучнаар нь авч үлдэх гэж байна. Үүнийг чинь дахин
 хэлье. Та бүхэн аашаа гаргах юм бол та бүхний мэддэг тэр хүч-
 нүүд бас аашаа гаргаж болно. Зүгээр л хүч тэнхээ нь хүрэхгүй-
 дээ юм уу, та бүхнийг баталчихна гэж найдаад дуугүй байгаад
 байгаа болохоос биш, түүнээс хараад суугаад байгаа юм бишээ.
 Алга болчихсондоо биш шүү. Монголын ардчиллыг хүсдэг, энэ
 монголчууд чинь зүгээр байж байгаа юм биш шүү.
 Та бүхний сонгогчид дотор ч гэсэн олон янзын санаа бодолтой
 улсууд бий шүү.

Соронзон хальстай тулгаж
 нийлсэн



Д.ЧУЛУУНШЭЦЭГ

1991.XI.21.

кассет № 34

9.40-9.53

59 дүгээр тойргийн депутат Д.Дамжав: -Түрүүн бид баталсан, дэгийг батлахдаа хэнээс ч нуугаагүй, олон хоногийн өмнө өгөөд хэлэлцэж байгаад нэгбүрчлэн хэлэлцээд баталсан. Тэгэхэд одоо гомцол тавьж байгаа улс төрийн хариуцлага хүлээсэн энэ депутатууд хаа байсан юм бэ? Хаа байсан юм бэ тэгэхэд.

Тэр гомцол тавьж байгаа улсууд тэр улсаас хэрэглэсэн бүх зардлаа эхлээд банкинд мөнгөө шилжүүлчихээд энэ асуудлыг ярих ёстой. Би ажил хэргийн чанартай юм ярья, цааш нь. Түүнээс гадна нэгэнт баталсан дэг рүү ингэж ухарч орж ерөөсөө болохгүй. Ямар ч асуудал руу ухарч болохгүй. Би эцсийн эцэст ардчилсан Үндсэн хуулийг энэ хурлаас гаргахын төлөө байгаа. Би энийг хэд хэдэн зүйлээр үндэслэж хэлье.

Бага Хурлын даргыг тэнд гаргаж суулгахдаа ямар эрх олгосон бэ? дэгийг хэлэлцэх гэж гаргасан уу, Үндсэн хуулийг цааш нь үргэлжлүүлж хэлэлцүүлэх, санал групплэхэд тус бол гэж гаргасан уу? дэг хэлэлцэх тухай асуудлыг хэлээд өг гэж тэнд гаргаагүй. Тийм учраас эрхийг хэтрүүлж хэрэглэж байна. Би олонхийн саналаар ингээд цаашаа яваад байна гэх юм бол нэгдүгээрт, энд би ний нуугүй үнэнийг хэлье. Өчигдрийн БНМАУ гэсэн санал дээр хураасан хамгийн сүүлийн саналаар хуучинсаг хүчин шинэ хүчин хоёрын харьцаа тэнд харагдаж байгаа. Тэрүүгээр яваад одоогийн оруулж байгаа ердийн олонхийн саналаар юмыг батлаад явъя гэх юм бол хамгийн эцэст нь хуучин төрийн тогтолцоог батална гэсэн үг.

Өнөөдөр монголын ард түмний хувь заяа төрийнхөө тогтолцооны тухай асуудал байгаа. Хуучин ямар төрийн тогтолцоонд явж ирэв, бид нар. Төрийн буруу ажиллагаатай машинтай явж ирлээ. Би олгогдсон эрхийн дагуу үг хэлж байна. Ямар байдал байна вэ гэхээр, ямар төрийн машинтай явж

ирэв. 1924 онд тавигдсан тэрийн машины хууль бол алдаатай байсан учраас тэр алдааны улмаас байн байн гажуудалд ороод гажуудсан тохиолдолдоо тэрийнхөө толгойд байгаа хүмүүсийг барьж иддэг тийм механизм ажиллаж ирлээ. Өнөөдөр бид нар анх удаа тэрийг засъя гэж сууж байна. Энийг бол ойлгох хэрэгтэй.

Одоо ч гэсэн толгой дээр байгааг нь барьж идье гэдгээж байна. Нэгдүгээрт би юу хэлэх гэж байна гэхээр, Бага Хурлаас орсон төсөл бол маш их хүч зарсан, маш олон эрдэмтэн, мэргэдийн санал хүсэлтийг тусгасан, олон улсын конференц хийсэн энэ бүхэн дээр тулгуурласан төсөл байгаа. Тийм учраас гаднаас орж байгаа төсөл бол гуравны хоёроор орно гэж бид нар баталсан байгаа. дэгээ тэгэж баталсан байгаа. Хэрвээ тэгэхгүй юм бол ямар байдалд орох вэ гэхээр энэ хурал тарж дуусна.

Хэрвээ тэрийг өөрчлөх гэж байгаа бол Их Хурал тарахад хүрнэ. Би Их Хурлыг нэр төрөө гутаан битгий тараасай гэж бодож байна. Энэ бол бодитой зүйл болно шүү. Чухамхүү би Их Хурлыг тараахгүй, ардчилсан Үндсэн хууль батлаад тараасай гэж бодож байна. Энэ тулгараад байгаа аюулыг би маш сайн мэдэрч байна. Тийм учраас эхнээсээ гуравны хоёроор санал гаднаас орвол орж ирнэ. Орохгүй бол төсөл үлдээд явна. Ингэхэд эцсийн эцэст ямар ч байсан гайгүй нэг Үндсэн хуулийн төсөл хоцорно. Тэрийг хамгийн эцэст гуравны хоёроороо батлах уу, үгүй юу гэдэг асуудал байна.

Эцэст нь, 66-гаараа батална уу, болино уу, тэр нь тодорхой болно. Хэрвээ баталж чадахгүй бол хурал тарна, хурал тарахаараа барьж идэх асуудалдаа орох ёс суртахууны эрх байхгүй шүү гэдгийг би одоо хэлье. Хэрвээ ардчилсан Үндсэн хуулиа баталсны дараа барьж идвэл барьж идэг.

47 дугаар тойргийн депутат С. Дхагвасүрэн: -Уучлаарай. Хурлын дарга, орлогч нар аа, депутатууд аа. Энэ хурлынхаа үйл ажиллагааг бид нар үнэхээр бас бодохгүй бол болохгүй

санагдаж байна. дэгийн зарчмын асуудлыг ярьж байгааг ойлгож байна. Тэгэхээр бид нар дэгийнхээ талаар хичнээн оролдлоо ч гэсэн бас бус янз бүрийн хурал үймүүлж байгаа байдал их ажиглагдаж байна. Хэн хунгүй сэтгэл зовж байна.

Ярьсан үгэнд битгий эмзэглээрэй гэж бодож байна. Эцсийн эцэст бид улс, эх орны хувь заяаны асуудал шийдэх гэж ирсэн. Гэтэл одоо хэдхэн хүмүүсийн хоорондын хэл амны бай болж маргаан болсон ийм хэлбэрээр хурал үргэлжилж байна. Энийг бүгд харамсч байгаа байх гэж бодож байна. Гэхдээ манай депутатуудын ихэнх нь босч үг хэлэхгүй байгаа. Энэ улсууд маань юу ч мэдэхгүй тийм хомсдолд орсондоо тэгэж байгаа биш байх гэж бодож байна. Энэ улсуудих зүйлийг бодон тунгааж байгаа байхаа гэж бодож байна.

Олон удаа микрофоны ард гарсан хүн болгон цэцэн байдаг, түүнийг ажиглан чагнаж байсан хүн нь мангар тэнэг байдаггүй байхаа гэж бодож байна. Ер нь монгол хүн ч цөөхөн дуугаар оновчтой хэлж, асуудлыг шийддэг түүхтэй. Тэгэхээр хурлын уур амьсгал маш эвгүй байдалд байна гэдгийг ойлгож байна, мэдэрч байна. Зарим нөхдүүдэд шууд хэлэхэд сүрдүүлгийн хэлбэр бол сүүлийн үед их гарч ирж байгаа. Миний хувьд босож үг хэлье гэж дайрч давшлаагүй. Би бараг үг хэлээгүй байгаа. Тэгэхээр тэсээд суугаад байж болохгүй байна, нэгэнт энд оролцож байгаа учраас. Үндсэн асуудал руугаа ерөөсөө огт орохгүй байна шүү дээ. Тэгээд дундуур нь их хэмжээний үймээн явагдаж байна. Жишээлбэл, хурал яагаад үймж байна вэ гэдгийг би өөрийн толгойгоор хэлье гэж бодож байна. Нэг нь хурлаа үймүүлэхгүй, бодол санаагаа, эв эеэ уралдуулаад явах юм бол болохоор бололцоо бүрэн харагдаж байна. Ганцхан зориудаар хоёр зааг бий болгоод байна. Жишээлбэл, хүний үг гэдэг бол хамгийн хорон байдаг. Үг шиг хамгийн айхтар юм байдаггүй, ямар ч зөвсөгтэй хүнийг үгээр буцааж болдог. Гэтэл ийм байна, жишээлбэл, манай ахмад уучлаарай миний ганц нэг нэр дурдаж байгаа улсууд уурлаж удаарлаж, тойруу замаар юм бүү бодоорой гэж бодож байна. Хурал үгээр үймүүлэгдэж байна. Жишээлбэл, Нямбуу гуай босоод тэглээ шүү дээ,

уржигдар. МАХН чадваргүй, хүчингүй нам гэж үзэхэд буруудах юм алга гэж. Тэгэхээр ингэж энэ хурал дээр ярих хэрэг байгаа ч юмуу, үгүй ч юмуу. Лоохууз гуай, депутатууд үнэмлэхээ хураалгаад явбал таарна гэж ярьж байгаа юм. Гэх жишээтэй. Элбэгдорж босч ирээд ярьж байна шүү дээ, өмнөх Үндсэн хуулиудаар цаазлагдсан нөхдүүдийн, хэлмэгдсэн нөхдүүдийн дурсгалыг хүндэтгэхгүй бол та нарын нэрийг сонин дээр бичнэ шүү ч гэх шиг. Бичүүлээд аль ч гэх шиг. Мөн хурлыг тараая гэдэг санаачлага ч хэд хэдэн хүнээс гарлаа. Тэгэхээр ийм байдлаар үндсэн асуудал руугаа орохын оронд эвдрэлцэх, хэмхэлцэх, нэгнийгээ мэтгэх, хатгах, бүдүүлэгхэн яривал аазгай хөдөлгөсөн ийм байдлаар нэгэнтэйгээ харьцах юм бол ийм том асуудлыг туулах нь битгий хэл, өчүүхэн горхин дээгүүр ч гаталж чадахгүй шүү дээ. Тэгэхээр энийгээ бас бодолцмоор байна.

Уучлаарай, бидний дунд золгүй явдал болж байна. Би өнөө өглөө босч, шөнө бодож байсан. Маргааш өглөөнөөс бас хэдүүлээ юм их бодмоор юмаа, нийтээрээ гэж бодож явлаа. Гэтэл ерөөсөө дөнгөж орж ирэнгүүтээ сүрдүүлэг эхэлж байна. Ингэж битгий тэгээч ээ. Харин тэр санал буруугүй санагдаж байгаа юм. Горимд жижигхэн нэмэлт еөрчлөлт хийгээд цааш нь явахад буруугүй юм. Амар горим юм бэ гэхээр, ердийн хөндлөнгийн асуудлыг олонхийн саналаар шийдээд эцсийн шийдвэрээ гуравны хоёроор шийдэхэд болохгүй юмаа гэдэг бол бас нэг их буруу биш юмаа гэж бодож байна.

Ж. Уртнасан: - Эрхэм депутатуудад дахин сануулъя. Бид ийм л юм яриад байгаа учраас хурал маань сунжраад байгаа юм. Өнөөдрийн хувьд дэгээ өөрчлөх үү, өөрчлөхгүй юу гэсэн хоёр гарын дор товчхон саналаа яримаар байна. дэгэн дээр нэмэлт өөрчлөлт оруулъя, хэвээрээ явъя. Тайлбаргүй баймаар байна.

165 дугаар тойргийн депутат Ч. Гомбосүрэн: - Өчигдрөөс хойш нэг үг хэлэх гээд би чадахгүй байгаа юм. Тэгэхээр депутатууд аа, бид ганцхан зорилготой ирсэн, Үндсэн хуулиа батлах. Тэгэхээр бид гадагшаа ч тэр, дотогшоо ч тэр, хүний

нуур харахад ичих, сүүлийн үед ичих, айх ийм сэтгэгдэл төрөөд байгаа.

Бид ард түмнээсээ жаахан зовмоор байна. Энд дайсан байхгүй ээ. Энэ танхимд ч байхгүй, тэр олон янзын нам дотор ч байхгүй, цөмөөрөө бид чинь монголын ард түмэн. Уучлаарай, би яагаад энийг хэлэх гээд байгаа юм гэхээр, бид ингэж бие биендээ үгээр мэтгэлцэж байх ийм зав алга. Тийм цаг байхгүй, гадаад нөхцөл чинь ийм ийм байтугай, энээс аюултай юм биднийг хүлээж байна шүү, цаана чинь. Хоолтой байх уу, үгүй юу? Амьдарч чадах уу, үгүй юу? Маж хэдэн ард түмнээ, ажил хийж байгаа ард түмнээ яаж сэтгэл санаагийн нь төвшин байлгах вэ гэдэг юм цаана чинь хаяанд чинь тулчихаад яг сигнал өгчихөөд зогсож байна шүү дээ. Ийм үед бид чинь ингэж тэр нам, энэ нам, ийм ийм юм ярих цаг биш. МАХН ч дайсан биш, бусад ямар ч нам дайсан биш. Уучлаарай, би энийг өчигдрөөс хойш хэлэх гээд өнөөдөр ингээд илүү үг болгож хэлж байгаа юм. Би ганцхан зүйл гуйя. Юу гуйх гэж байна вэ гэхээр, бие биендээ хатуу хөтүү үг хаяхаа больё, энийг эцэслэе. Хөрвөө ийм өнгө аястай үг гаргасан депутатыг Ардын Их Хурлын II хуралдаан анхааралдаа аваач ээ гэж хүсье. Депутатын хувьд Их Хурлын хуралдаанд хүсч байна.

Санал бол ийм байна. Анхнаасаа гарч ирсэн төсөл маань ард түмний саналыг олон удаа авч хэлэлцсэн гэх боловч жинхэнэ тусах ёстой юм нь тусах газраа тусаагүй учраас энэ маш их зөрчилд орж байгаа. Үнэнийг хэлэхэд бид чинь асар их, хэдэн мянган жилээр, хэдэн зуун жилээр урагшаа тасарч болно, хэдэн арван жилээр. Бас ард түмнээсээ бүр дээр нь дүүжлэгдэж болохгүй ээ. Тийм учраас энэ хуулийг хэлэлцэх энэ явцад ердийн олонхийн саналыг зарим асуудал дээр харгалзаж үзэхгүйгээр энэ саян бид нарын яриад байгаа зүйл тохиролцоонд хүрэх үндэс алга байна. Тийм учраас нөхөр Гомбожавын гаргасан түрүүний саналыг би дэмжиж байна.

Соронзон хальстай тулгаж нийлсэн: *Ц.Баярмаа* Ц.БАЯРМАА
Бичээч Ө.Оюунчимэг

С.Чулуунбаатар

-Баярлалаа.

Би горимын саналаа ярина.Би хүн загнаж чадахгүй, айлгаж чадахгүй, сүрдүүлж чадахгүй юм.Мунхаг болоод ч тэр байх.Зүгээр сайн нөхрийн маань сууж байгаад эх орныхоо төлөө гэж элгэн халуун сэтгэл гаргаж сууж байгаад талийгаач, бурхан болсон тэр суудал нь халуунаараа байгаа.Гэтэл тэрнийг хүндэтгэж байна гэж босож ирэнгүүтээ эргээд бие биенийгээ барьж идэх тухай ярина гэдэгт тун их харамсаж байна.Энэ монгол хүний билэг ёсонд таарахгүй л болов уу.Энийг харин оршил болгоод хэлчихье.

Хоёрдугаарт, Их Хурлын дарга та шударга биш байна.Зарим хүн ямар юм ярьж байхад нь та анхааруулга өгдөг, зарим хүн юу ярьж байхад нь та анхааруулга өгдөггүй юм гэдгээ нэг тунгаагаарай.

Гуравдугаарт, Би өнөөдөртөө БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын даргаас нэгэн зүйл хүсмээр байна.Таныг зөвлөж туслаач гэж энэ өндөр ширээнд гаргасан.Тийм болох учраас наад даргадаа та зөвлөхдөө Улсын Бага Хурлынхаа практикийг бас эргэж бодож зөвлөөчээ.Хэзээ Улсын Бага Хурлаар хууль дүрэм авч хэлэлцэж батлахдаа хажуугаас орж ирсэн саналыг заавал гуравны хоёр хувийн санал авч байж тэрнийг зарчмын гэж үзэж байсан юм бэ гэдгийг би нэг л сайн санаж егөхгүй юм.Энийг нэг бодооч.

Р.Гончигдорж -Чулуунбаатараа ойлгоогүй буруу яриад байж болохгүй.Энд гуравны хоёроор зарчмын эцсийнхээ асуудлыг шийдэх тухай огт яриагүй.Тэгэхээр гуйвуулж ярьж болохгүй.

С.Чулуунбаатар -Би ойлгосон.Би цааш нь дуусгая.Тийм болох учраас би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг нэгэнт хууль баталсан тэр субъект нь өөрөөр хэлбэл тэр хууль баталсан Их, Бага Хурал нь баталсан хуулиндаа засвар хийдэг эрхтэй л юм бол энэ дэгийг баталсан энэ Их Хурлын депутатууд энэ дэгэнд учир дутагдал байна, үүнийг маань засаачээ гэдэг санал

гаргах эрхтэй байх. Тийм учраас нэгдүгээр удаагийн хэлэлцүүлгэн дээр асуудал бүрийг ердийн олонхийн саналаар хоёрдугаар удаагийн хэлэлцүүлгэн дээр гуравны хоёроор гэсэн Улсын Бага Хурлын гишүүн, Ардын Их Хурлын депутат, байнгын хорооны дарга Энхсайхан, депутат Мижид, депутат Өелд, депутат Раш нарын өчигдрийн саналыг хүндэтгэж санал хураалгаж өгөөч гэж гуйх байна.

Ж. Уртнасан - За баярлалаа. Ер нь гишүүдийн санал хоёрхон горимын юм байгаа юм. Дэг дээр нэмэлт тайлбар оруулъя гэсэн энэ хувилбараар санал хураалт явуулчих юм бол асуудал шийдэгдчих юм шиг байна.

-Төгэхээр

энэ чинь зарчмын санал, зарчмын юм, зарчмын биш юм гэж чухам юуг хэлээд байна вэ? Үндсэн хуулин дээр зарчмын биш юм юуг жишээлбэл бид юуг зарчмын биш юм гэж хэлэх вэ? Энийг чинь бид ялгаж тогтож авахгүй бол бас нэг будлианы юм гарч ирэх гээд байна шүү. Төгэхээр зарчмын биш юм Үндсэн хуулинд юу байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт оруулж ирсэн Улсын Бага Хурлын санал бол үндсэн санал гэж үзээд яваа. Ардын Их Хурлын саналыг бол үндсэн биш санал гээд байгаа. Тэгээд зарчмын биш гэж бас нэг юм гаргаж ирээд. Тэгээд категориор ингээд тогмоод байх юм бол бид ерөөсөө барахгүй шүү. Энийг тодруулж хэлж өгөөчээ.

Ж. Уртнасан - Зарчмын, зарчмын биш гэдгээр Бага Хурлын даргаас тайлбар сонсъя.

Р. Гончигдорж - За эрхэм депутатуудаа. Тэр дээр гарч суусан нь ер нь буруу юм шиг байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт би та бүхэнд ерөөсөө энэ байдлыг хамгийн төв байдлаар тайлбарлах нь зүйтэй юм байна. Ингээд ярьж байхад ойлгоогүй юм уу, ярьж байхад буруу сонссон учраас дараачаар нь яг миний бодож, түрүүн томъёолсон юмнуудыг давтаж эргэж шүүмжилж

3.

яриад байх юм. Олон хүн болохоор болохгүй байх шиг байна. Нөхөддөө, өөртөө болоод өөрөөл бусдадаа юмыг анхааралтай сууж байх боломжийг бүрдүүлээчээ гэж эрхэм депутатуудаас тэргүүнчлэн хүсье.

Нэгдүгээр асуудал бол бид нэгэнт энэ дэгийгээ баталсан. Энэ дэгэнд хоёр зүйл тодорхойгүй үлджээ гэж үзэж байна. Тэр утгаар нь энэндээ нэмэлт оруулах тухай асуудал. Тэрнээс биш асуудлыгаа хэлэлцэж явж байгаад асуудал хэлцлийн байдалдаа зохицуулж, юмаа өөрчилнө гэдэг бол хуулийг тухайн этгээдэд тохируулан гаргана гэдэгтэй адилхан зүйл. Би хуулийн улсуудыг энийг ойлгож байгаа гэж ойлгож байна. Тийм учраас бид нар энэ тодорхойгүй үлдсэнээс болсон маргасан асуудал нэгдүгээрт. Хэн гуай та зарчмын асуудал гээгүй, зөрүүтэй зарчмын асуудал. Бид нэг асуудал энд томъёологджээ. Гэтэл нэг хүн хажуугаас нэг санал хэллээ. Энэ санал зарчмын хувьд энэ саналаасаа зөрүүтэй байна уу, зөрүүгүй байна уу гэдэг асуудал ярьж байгаа болохоос биш, бидний хэлэлцэж байгаа асуудал зарчмын уу үгүй юу гэдэг асуудал огт яриагүй байна.

Ингээд энэ хүний санал үнэхээр зарчмын зөрүүтэй асуудал энэн дотор нь байна гэж үзвэл, зөрүүтэй асуудал, энийг нь ердийн олонхиороо, үнэхээр энэнд зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна гэдгийг нь ердийн олонхийнхоо зөвшөөрлөөр гаргая гэж байна шүү дээ. Тэрнээс биш тэр асуудлыг шийдэж байгаа юм биш. За ингээд зарчмын зөрүүтэй асуудлуудын хувилбарууд гарч ирэх нь. Сая Монгол улс гэдэг дээр гурван зарчмын зөрүүтэй нэр гарч ирлээ шүү дээ. Энийгээ энэ рүүгээ оруулахдаа энд ерөөсөө яриагүй. Энд тайлбар гэж байгаа. Саналын зөрүүтэй зарчмын асуудал гэж анхны хэлэлцүүлгийн үед шинээр үүсч гарсан болон тухайлбал санал хурааж шийдвэрлэхээр хуралдаанд оролцож шийдвэрлэсэн асуудлыг ойлгоно гэж.

Гэтэл гарсан болгоныг зарчмын зөрүүтэй гэж олонхиороо үзэхгүй шүү дээ. Тийм учраас зарчмын зөрүүтэй гэж оруулж ирэх энэ асуудлаа ердийн олонхиор шийдье гэж. Дараачаар нь ингэж гаргаад ирсний дараачаар зарчмын зөрүүтэй асуудлууд гэж томъёо-

логдсон асуудлууд, энэ төсөлд байж байгаа асуудал. Одоо энэний хээ хувьд ингэснийх нь дараачаар үндсэн, үндсэн биш гэж ялгах аа больё гэдэг асуудал ярьж байна шүү дээ. Ингээд зарчмын зөрөөтэй асуудлуудын цогцолбор дотроос ямар нэгэн аргаар хэлэлцэж байгаад, хэлэлцэж байгаа асуудлаа, одоо хэлэлцэж байгаа асуудлаа, тэрнээс зөрөөтэй асуудлаа биш, хэлэлцэж байгаа асуудлаа гуравны хоёроор анхны хэлэлцүүлэг дээр шийдвэрлэнэ гэж. Ийм л хоёр зүйл байна. Тэрнээс одоо анхны хэлэлцүүлэг дээр гуравны хоёроор шийднэ гэсэн энэ дэгийн зарчмын асуудлыг өнөөдөр өөрчилж, анхны хэлэлцүүлгээр асуудлаа 50 хувиар шийднэ гэж өөрчлөх юм бол бид үнэхээр хурлынхаа байдалд тохируулж горимоо өөрчилж байгаа асуудал буюу, миний түрүүний хэлснээр тухайн нэгэн хүнд зориулж, хуулийн зүйлчлэлийг өөрчилж байгаагаар адил зүйл болно. Ийм л тайлбар байна. Эрхэм депутатууд энэ тайлбарыг сонсоод, тэгээд өөрсдийнхөөрөө бодож, энэ асуудал дээрээ зөвхөн яриад шийдэх хэрэгтэй байна.

Одоо гарсан санал бол ийм байна. Одоо гарсан санал бол ерөөсөө энэнд ямар ч нэмэлт тайлбар хэрэггүй. Ямар ч өөрчлөлт хэрэггүй гэсэн нэг санал байна. Зүгээр энэндээ өөрчилбөл нэмэлтийн түвшинд биш өөрчлөлтийн түвшинд хийж, тэр дийлэнх олонхиор гэдгийг 50 хувь болгоё гэсэн ийм хоёр санал гарч ирж байна. Эндээс санал ярихдаа бол бид нар энэ тухай огт яриагүй. Нэмэлт тайлбар оруулах тухай асуудал.

Ийм л байна эрхэм депутатуудаа. Ийм учраас саян энэ нэмэлтийг зөвшөөрч байгаа дээр эрхэм даргыг санал хураалгаж өгөхгүй юу гэж хүсэж байна.

Ж. Уртнасан - За санал төвлөрсөн гэж бодож байна.

Санал төвлөрлөө. Учлаарай депутатуудаа. Дэгэн дээр ийм санал ирсэн. Дэгэн дээр хоёр санал Дэд ерөнхийлөгч ярилаа. Дэгд нэмэлт тайлбар оруулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэгд саян төслөөр нэмэлт тайлбар оруулъя. Оруулъя гэвэл бид томъёоллоо сонгож авах болно.


Нэгэнт бид дэгээ баталсан. Дэгээ бас бид өөрчилж болох учир бий. Зөвшөөрсөн 276 депутат буюу 77 хувь нэмэлт тайлбар оруулъя гэж байна. Нэмэлт тайлбарыг сая Гончигдорж дарга эндээс томъёолсон. Бидэнд бичиж ирсэн хоёр томъёолол байна. Гончигдорж даргын дэгэнд нэмэлт тайлбар оруулъя гэсэн томъёоллыг та бүхэн сонссон. Энийг сайн ойлгож байгаа юу. За баярлалаа.

Сая Дэд ерөнхийлөгчийн хэлсэн томъёоллоор дэгд нэмэлт тайлбар оруулахаар боллоо. Энэн дээр санал хураалт явуулъя. Томъёоллыг дахиад нэг хэлбэ, тэгээд санал хураалт явуулъя. Дэд ерөнхийлөгчийн Гончигдоржийн оруулсан энэ нэмэлт томъёоллор санал хураалт явуулах гэж байна.

Д.Гончигдорж - Дэгийн 12 дугаар зүйлийн "г"-гийн тайлбар гэдэг хэсэгт тухайн зарчмын зөрүүтэй гэж үзэж дэвшүүлж байгаа саналыг дийлэнх олонхиор, ердийн олонхиор зарчмын зөрүүтэй гэж асуудал гэж үзсэн тохиолдолд түүнийг, тэдгээр саналуудыг үндсэн саналтай хамт зэрэгцүүлэн хэлэлцэж, хэлэлцэнэ гэж. Ерөөсөө тэгээд л хэлчихэд эцэст нь гуравны хоёроор гэж байгаа шүү дээ. Ерөөсөө ганцхан өгүүлбэрээр. Зарчмын зөрүүтэй гэсэн санал оруулж байх тохиолдолд түүнийг зарчмын зөрүүтэй эсэхийг нь ердийн олонхиор шийдвэрлээд ердийн олонхи зарчмын зөрүүтэй санал гэж үзсэн тохиолдолд түүнийг үндсэн саналтай зэрэгцүүлэн хэлэлцэнэ гэж.

Ж.Уртнасан - За энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэнэ үү. Санал хураалт явж байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн



ТӨМӨРБААТАР

Бичээч Уранчимэг

Уртнасан: -Уучлаарай, депутатууд санал хураалтанд оролцсонгүй, дөнгөж 47 % нь санал хураалтанд оролцож байна. 199-хөн хүн саналаа өглөө. Дахиад санал хураалт явуулъя. Анхааралтай байхыг хүсч байна. Тайлбар дээр зарчмын зөрөөтэй асуудлыг авч цийлэнх олонхийн саналаар шийдэж, зарчмын гэж үзвэл үндсэн саналтай зэрэгцүүлэн санал хураалт явуулна гэсэн тэр томъёолоор ердийн олонхиор, эхнийх нь ердийн олонхиор зарчмын зөрөөтэй асуудлаар сонгож авна гэдэг дээр, санал хураалтанд бүгдээрээ оролцохыг хүсч байна. Депутатууд аа,

Гончигдорж: -Зэрэгцүүлнэ гэдэг үгийн дотор тэдгээрийг эрхийн статусыг ав адилхан боллоо гэж оруулж байна гэдэг үгээ л хэлж байна шүү дээ.

Батбаяр:

-Нэмэлт тайлбар тодруулж нэг зүйлийг хэлэх гэсэн юм. Өчигдөр асуудал үндсэндээ шийцвэрлэж чадахгүй, олон хүмүүсийн дургуйцлийг төрүүлээд байсан зүйл бол хажуугийн саналыг хэлэлцээд, хажуугийн саналд 3-ны 2-ыг авч чадахгүй бол төсөлд байгаа үндсэн санал үлдэнэ гэдэг дээр хүмүүс их дургуйцсэн. Тэрнийг залруулах үүднээс энэ зүйлийг оруулж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол, эхлээд за энэ төсөл байж байна, энэ төсөл дээр ямар ямар шинэ санал байна гэж асуунаа, тэгэхээр хүмүүс шинэ саналаа хэлнэ, а/ б/ гээд, улсын нэр дээр БНМАУ, бүгд найрамдах монгол улс гээд хэлчихлээ, тэгэхээр энэ зүйлийг чинь үндсэн саналтай зэрэгцүүлэн хэлэлцүүлэх үү, тийм ээ, эрх тэгш эрхтэйгээр, адил хэмжээнц тэнцүүлэх үү үгүй юу гэдгээр санал хураагаад ердийн олонхийн санал авах дээр зарчмын зөрөөтэй санал гэж тооцогдоно. Ингээд зарчмын зөрөөтэй гэж тооцогдсоны дараагаар Монгол улс, БНМАУ, Бүгд найрамдах монгол улс гэдэг 3 саналыг адил тэгш эрхтэй гэж авч үзээд, хэлэлцүүлээд аль нэгэн санал нь аль цийлэнх олонхийн саналыг авах юм бол тэр саналыг баталж хүчинтэй болсон гэж тооцно гэж, энэ ойлголтыг л бий болгохын төлөө саяны заалтыг хэлж байгаа юм, ойлголцов уу.

Уртнасан: -За санал хураалтанд бэлтгэнэ үү, томъёолол тодорхой

боллоо, 2 дахин тайлбар тавилаа. Санал хураалт эхэллээ, анхаараарай, санал хураалт явж байна. Баярлалаа, 346 депутат оролцлоо, 81 % нь, 314 хүн буюу 91 % нь энэ саналыг зөвшөөрч байна, баярлалаа. Бид За одоо хуралдаанаа үргэлжүүлье. Бид тохиролцоонд хүрлээ. Ингэвэл бид нэлээд цаашаа явах боломжтой болох байх. Энэ саналыг одоо баталчихъя. Саналыг батлах санал хураалт явуулж байна. Саналаа батлая. -За баярлалаа, ечигдөр та бид нар 3 дахь хувилбар буюу цөөнхийн цөөнхийн саналыг сонсож байсныг саваж байгаа байх, бүгд найрамдах монгол улс, энэ дээр ечигдрийнхөө дугаараар хэлэлцүүлгээ үргэлжлүүлье. Бүгд найрамдах монгол улс . За баярлалаа, дийлэнх олонхийн саналаар бүгд найрамдах Монгол улс гэдэг дээр санал хураалт явуулъя. Шууд. Дахи[д томъёоллыг хэлье. Депутатууд аа, Санал хураалтанд бэлтгэнэ үү. Жагварал депутат аа, санал хураалтанд бэлтгэнэ үү, саналаа хураая. Томъёоллыг дахин давъя. Бүгд найрамдах Монгол улс, -Уучлаарай, техникийн саатал орж байна уу, аль эсвэл бид будилж байна уу, 337-хон хүн санал өглөө. Тийм учраас анхааралтай байхыг хүсч байна. Дахин санал хураалтанд бэлтгэе. Томъёолол хэвээрээ Бүгд найрамдах Монгол улс. За анхааралтай байгаарай, санал хураалт явууллаа, одоо 155 хүн буюу 39 % нь зөвшөөрч байна, бид БНМАУ гэдгээр хураагаадахсам. . Бүгд найрамдах монгол улс дээр хураалаа, одоо Монгол улс гэдэг дээр санал хураалт явуулъя. Санал хураалтанд бэлтгэнэ үү, Монгол улс, томъёолол нь. За Монгол улс гэдэг дээр олонхийн санал авч чадахгүй байна, 37 %, 145 хүн, татгалзсан 203 буюу 51 %, ердийн олонхи нь татгалзаж байна, түдгэлзсэн 47 хүн байна, Одоо бид горимыг еөрчилж, зөвшилд хүрэх хэрэгтэй болж байна.

Уучлаарай депутатууд аа! Тэгэхээр бид энэ 3 нэрийнхээ талаар санал хураачихлаа. Одоо горимын , одоо бид нар бүгд найрамдах гэсэн нэг тодотгол, ард гэсэн нэг тодотгол дээр санал хураалт явуулчихвал энэ асуудал шийдэгдлээ.

39-р тойргийн депутат Ламжав:

-Тэгэхээр саяхан бид нар дэгдээ нэг өөрчлөлт, нэмэлт оруулчихсан, тэр саяын оруулсан нэмэлт ёсоор Гончигдорж даргын санаачилж оруулсан нэмэлт ёсоор улсын нэр, зарчмын асуудал мөн үү, биш үү гээд олонхиороо шийдлээ. Тэгэхээр байна шүү дээ, олонхи маань

лах вэ гэхээр энэ бол зарчмын асуудал биш ээ гээд саналаа өгчигдэг, тэгэхээр нь дараа нь одоо БНМАУ гэдэг дээр саналаа хураа, тэгэхээр олонхи болоод , тэгээд БНМАУ чинь та нарын гарт үлдлээ, би зааж өгч байна.

Гончигдорж: -Эрхэм депутат Ламжав буруу ойлгосон байна, асуудлыг зарчмын асуудал уу үгүй юу гэдэг дээр биш, асуудлын хажуугаар гаргаж байгаа санал , зарчмын зөрүүтэй юу үгүй юу, зөрүү нь зарчмынх уу үгүй юу гэдэг асуудал ярьж байгаа шүү дээ, тийм учраас эрхэм депутатууд аа, бид нар олон хоног хуралдлаа, нэрэн дээрээ олон хоног хуралдлаа, бид нар уур амьсгал дотор талдаа хүнд байгаа учраас бие биендээ их сэтгэл санааны, бие, эрүүл мэндийн даралт үзүүлж байна, тийм учраас бид нар ер нь энэ их зүйлийг амгалан хэлэлцэж байж л бид шийднэ уу гэхээс биш омголон хэлэлцэж байж шийдэхгүй гэдэг нь ойлгомжтой болоод байна, асуудал дээр бид яаж бид нар амгалан байдаг вэ гэхлээр зэрэг яаж энэ асуудлууд дээр бид тохиролцоонд хүрэх вэ гэдэг л асуудал байдаг. Түрүүн бид нар 3, 3-аар нь цувуулахад болдоггүй юм байна гэдгийг харлаа, 3-3-аар нь цувуулахад, тэгвэл одоо бид нар энэ 3 дотор хоорондоо юу юугаагаараа нэгдэж болох вэ гэдэг асуудал байна, Бүгд найрамдах гэдэг тодотголоор 2 нь нийлж байна, ард гэдэг тодотголыг хасахаараа 2 нь нийлж байна, тийм байгаа биз дээ, тийм учраас энэ тодотголүүдийнхаа асуудал дээр ярьчих юу бол харьцангуй бөөгнөрөх байдал үүсч болох нуу гэсэн, ийм байдал үүсч байгаа учраас горимын асуудал ард гэдэг тодотгол байлгах эсэх тухай асуудал бүгд найрамдах гэдэг тодотгол байлгах эсэх тухай асуудлыгаа хэлэлцэх асуудлаа болгоод, энэ асуудал дээр ярья. Эхлээд нэгэнт бүгд найрамдах гэдэг тодотгол, ярих болгондоо бид нар бүгд найрамдах гэдэг тодотгол дээрээ бүгдээрээ ярьсан, хасья гэдэг нь хасья гэдгээрээ, байлгая гэдэг нь байлгая гэдгээрээ, ард гэдэг тодотгол дээр хасья гэдэг нь хасья гэдгээрээ, байлгая гэдэг нь байлгая гэдгээрээ ярьсан. Тийм учраас одоо энэ 2 тодотгол дээр ярих байдал бол одоо дууссан болов уу , гэж ингэж ойлгоод би тэр томъёоллыг гаргаж зөвлөж байна.

Эрхэм депутат ууд аа, эхлээд БНМАУ гэдэг дээр бид 71 %-ийн санал, дараа нь 51%, дараа нь 49 %-ийн санал авсан шүү дээ. Одоо ТОДОТГОЛОО ЯРЬЯ.

Уртнасан: -Уучлаарай Депутатууд аа, бүлгүүд завсарлага авахыг хүсч байна.Тайван зөвшилдөө.Бүлгүүд зөвлөлдөхийг хүсч байна. 30 минут.Ардчилсан эвслийн бүлэг А зааланд.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

1991.XI.21.
Кассет № IY37, 38
II.53-II.58.

38. т. олуурсану

М. Уртнасан: -Уучлаарай, депутат нөхөд өө. Бид сая нам, эвслийн дарга нартай уулзаж Ерөнхийлөгчтэй зөвлөлдлөө. Тэгэхээр бид энд ингэж олуулаа, олон янзын уур амьсгалтай, олон янзын томъёололтойгоор маргалдвал хурал цаашаа үргэлжлэхэд хэцүү байна. Ийм учраас нам, эвслийн дарга нарын хүсэлтээр өнөөдөр нэлээн буурьтай суурьтай намууд тус бүр ярилцах нь зүйтэй гэж ингэж тохиролцоонд хүрлээ.

Өнөөдөр 17 цаг хүртэл нам, эвслүүд уулзах ийм боломжийг хүсч байна. Ардчилсан эвсэл 14 цагаас энэ хажуу талын зааланд, МАХН-ын бүлэг МАХН-ын Төв Хорооны байранд 14 цагт цугларч та бүхэн дотроо ярилцах нь зүйтэй гэсэн ийм шийдэлд хүрч байна. Ингээд хурлыг завсарлая.

МАХН-ын гишүүд Намын Төв Хорооны шинэ байранд 14 цагаас. Хурал эхлэх цаг 17 цагаас. Орой хуралдана, орой бид шөнө дөл болтол хуралдана. Бие даасан депутатуудын бүлэг энд үлдэхийг зарлаж байна. Дашбалбар зарлуулж байна.

Кассет № IY38
17.24-17.40

Ж. Уртнасан: -Эрхэм депутатуудын оройны амгаланг айлтгая. Бид улсын нэрийн талаар санал зөрөлдөөнтэй, нам, эвслийн бүлгүүд тохиролцоонд хүрэхийн тулд, зөвшилцөхийн тулд нэлээд удаан хугацааны завсарлага авсан. Одоо нам, эвсэл, бүлгийн удирдлагуудын мэдээлэл, саналыг сонсоё.

42 дугаар тойргийн депутат Б. Даш-Бидон: -Бид нар төр, улсынхаа нэрийг Үндсэн хуулиндаа бататган тогтоохын тулд олон өдөр хуралдчихаад төвөгтэй байдалд байна. Энэ төвөгтэй байдлаас гарахын тулд хоёр шатны зөвшилцөлт /манай намын хувьд/ хэрэгтэй юм байна. Хоёрдугаар шатны зөвшилцөлт буюу намын бүлгийн, намуудын бүлгийн ахлагч нарын

саналаар бол нэг хувилбар гарсан. Тэр хувилбараар МАХН дотроо зөвшихөд бэрхшээл учирч байна. Ингээд би МАХН-ын бүлгийн нэрийн өмнөөс хурлын удирдлага, эрхэм хүндэт депутатуудад бүлгийн нөхдийн дамжуулсан хүсэлтийг хэлье.

Энэ нь БНМАУ гэдэг нэрээр санал хураалгаач гэж байгаа юм.

Ж. Уртнасан: -Ардчилсан эвсэл бүлгийнхэн ямар тохиролцоонд хүрээ бол.

Э дугаар тойргийн депутат Р. Барсболд: -Ардчилсан эвсэл бүлгийнхэн үдээс хойш тийм зохион байгуулалттайгаар том хуралдаан явуулсангүй. Харилцан цөөхөн тооны хүмүүс цугларч байж саналаа солилцлоо. Гэхдээ үдээс өмнө түр завсарлахдаа бид цугларч байж мөн зарим чиглэлээр ярилцсан юм.

Манай эвсэл хэдий санаа бодлоороо бүрэн гүйцэд нэгдэхгүй, ялгаатай байгаа боловч үндсэн чиглэл дээр бол санаа нэгтэй юм шиг байна лээ. Энэ бол юуны түрүүнд хурлаа үргэлжлүүлбэ, зөвшилцөх арга зам дуусаагүй байгаа. Үндсэн хуулийн төслийг баттай шүүн хэлэлцээд батлахаар хэмжээнд хүргэх боломж алдагдаагүй. Хэрэв өмнө нь бид хэд хэдэн зүйлээр зөвшилцөх бололцоог эрж хайж байсан. Нам, эвсэл, холбоод, бүлгийнхний ахлагч нар Ерөнхийлөгчтэй уулзаж ярилцахдаа бид ихэнхдээ дэвшүүлсэн нэг саналыг мөн бүрэн гүйцэд дэмжиж байлаа. Энэ бол цаашид бас зөвшилцөх нэлээн өргөн зам байсан гэж бид үзэж байсан юм. Энэ бол бас төдийлөн явсангүй.

Өчигдөр, өнөөдөр дэгийн талаар нэмэлт тайлбар оруулах дээр бид бас саналаа өгч, үүнийг зөвшилцөх бололцоотой нэг арга зам гэж үзэж байсан. Мөн бас л төдийлөн явсангүй гэж үзэж байна. Цаашид энэ төслийн талын ажлыг үр дүнтэй үргэлжлүүлэхийн тулд цаг их зарцагдаж байгааг харгалзаад ер нь 400 хүн энд суугаад нэг төсөл дээр ярилцахад маш их бэрхшээлтэй байгаа учраас 4 бүлэг байгуулаад хэлэлцэх, шүүн

хэлэлцэх ажлаа явуулъя. Зарчмын тохиролцоогүй зарим асуудлыг түр хугацаагаар үлдээж ажлаа жаахан дөхүүлж байж шийдвэрлэж болох байхаа гэж үзэж байна.

Гэхдээ манай эвсэлд оролцож байгаа нам, бүлгийнхний арай еер саналтай нөхөд ярьж болох юм.

24 дүгээр тойргийн депутат Р.Хатанбаатар: -Би ИСДН-ын бүлгийн өмнөөс, нэрийн өмнөөс ярих гэж байна. Бид 70 зүйлтэй улс орны төрийн байгуулалт, хүний эрх, улсын тусгаар тогтнол бүх талаа хамарсан том хуулийг хэлэлцэх гэж байгаа. Өдөөгөөр бид нар нэг ч зүйлийг хэлэлцэж эхлээгүй байна. Энэ бол бидэнтэй адилхан тоталитари дэглэмээс ардчилал руу шилжиж байгаа. Зүүн европын олон социалист орнуудад давтагдсан тэр гашуун туршлагыг давтах аюулд биднийг хүргээд байна. Өөрөөр хэлбэл, Зүүн европын энэ орнууд дээр хуучин байсан Парламент нь алин ч Үндсэн хуулиа баталж чадаагүй. Ингээд дандаа парламент тарж шинээр сонгууль явуулахад хүрч байсан. Бид энэ гашуун туршлагыг давтах ёсгүй. Тэгэхээр хөрвээ бид өнөөдөр Ардын Их Хурал дээр ямар нэгэн зөвшилд хүрч чадахгүй бол бид энэ асуудлыг улс төрийн аргаар шийдэхийн тулд цаашид Ерөнхийлөгчийн удирдлагын дор улс төрийн бүх хүч, намуудын улс төрийн яриа хэлэлцээрийг эхлүүлэхээс еер замгүй болоод байна гэж үзэж байна.

Тухайлбал, энэ дотор юу ярих гээд байгаа юм гэхээр, манай төрийн эрх барих дээд байгууллага болох Ардын Их Хурлын маань талаар ард түмний дунд төдий л сайнгүй төсөөлөл гарч ирлээ. Хөрвээ төр ингэж нэрээ барвал ард түмэн төрд итгэхийг болино. Бид ийм болохоор энэ улс төрийн хүчнүүдийн дугуй ширээний ярилцлагыг шууд радио, телевизээр нэвтрүүлж ингэж явуулахаас еер аргагүйд хүрнэ. Тэгэхээр бид юуны өмнө эхлээд зөвшилдөө хүрэхийг хичээе. Ер нь манай намын барьдаг байр суурь дээр бол ардчиллын төлөө тэмцэл бол парламентынхаа хүрээнд л явж байгаасай гэж боддог. Энээс цааш гаргахгүй байхыг бид хичээж байна. Тэгэхээр бид

эцсийн удаа энэ Ардын Их Хурал дээрээ зөвшилцөхийг хичээе. Хэрвээ болохгүй бол Ерөнхийлөгчид хандаж хүсч байна. Улс төрийн хүчнүүдийн ярилцлага, хэлэлцээрт орох ийм л зам үлдэж байна гэж хэлэх гэсэн юм.

9 дүгээр тойргийн депутат С.Зориг: -Тэгэхээр ардчилсан хүчний эвсэлд ордог хоёр намыг төлөөлж би энд нэг мэдэгдэл уншъя.

Чөлөөт хөдөлмөрийн нам, Бүгд найрамдах намын хамтарсан мэдэгдэл. Монголын олон нийт Ардын Их Хурлын II хуралдааныг түүхэн ач холбогдолтой хуралдаан болно хэмээн үзэж түүний үйл явцыг машид анхааралтай ажиглаж эхэлсэн билээ. Гэтэл Ардын Их Хурлын депутатууд хуралдах хугацааныхаа талыг нь өнгөрөөсөн атлаа энэ хуралдааны хэлэлцэх асуудлын цөм болсон Монгол улсын шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх асуудлыг сунжруулсаар байна. Энэхүү туйлын хариуцлагагүй байдлын улмаас энэ улсад Парламентын хямрал үүсч болзошгүйг эрхэм депутатууд оюун санаандаа болгоож Улсын Бага Хурлаас өргөн мэдүүлж буй Монгол улсын Их цаазын төслийг хэлэлцүүлгийнхээ үндэс болгож ажлаа шуурхайлан, тодорхой үр дүнд хүрэхийг манай хоёр нам уриалж байна.

Ардын Их Хурлын II хуралдаан Монгол улсад эхлэлээ тавьсан ардчиллын үйл явцыг баталгаажуулах түүхэн үүрэг хүлээсэн билээ. Энэхүү үүргээ гүнээ ухамсарлан ардчиллын эрх ашиг, Монгол улсын цаашдын хөгжлийн эрх ашигт нийцсэн тодорхой шийдвэр гаргахыг уриалж байна. Тэгээд энэ хоёр намын зөвлөл, энэ Их Хуралд суугаа депутатуудын хуралдаанаас бид нар ийм саналыг гаргаж байгаа. Улсын нэр, туг, сүлдний асуудлыг нээлттэй орхиж, хамгийн сүүлд нь хэлэлцэх. Тэрний наана 427 байсан одоо 426 болчихлоо, Барсболд депутатын хэлснээр бүлэг, бүлгээр 4 хэсэг хуваагдаад бүлэг болгонд депутатуудын бүлгүүдээс өөрийнхөө төлөөлөгчдийг оруулж 4 хоногийн хугацаанд зарчмын бүх асуудлуудаа даван туулаад оруулж ирж хэлэлцээд батлах, тэгээгүй тохиолдолд бид нар Ерөнхийлөгчтэй энэ асуудлыг хэлэлцэж дараагийн сонгуулийг ойрын хугацаанд явуулах асуудлыг бололцооны бусад аргаараа

шийдвэрлэх арга хэмжээнд оръё гэж бодож байгаа юм.

10 дугаар тойргийн депутат О. Дашбалбар: —Бие даасан депутатуудын бүлэг өнөөдөр хуралдсан. Ингээд хурал удаж байгаа шалтгааныг бид цөөнх нь өөрсдийн санаа бодлыг олонхдоо тулган хүлээлгэж заавал өөрсдийн нь оруулж ирсэн тэр хувилбараар байлгах гэж оролдож байгаагаас хурал 10 хоног сунжирлаа гэж үзэж байна.

Улсын нэрний хувьд бид яаралтай шийдэх ёстой. БНМАУ гэдэг бол энэ нэрэн дээр энэ бүлэг хөдөлгөөнгүй зогсоно. Өөр ямар ч нэрийг хүлээн зөвшөөрөхгүй гэж тогтсон. Хоёрт, энэ бол ард түмний тэр байх юм бол "ард" гэдэг үгийг хасна гэдэг бол утгагүй ажил гэж үзсэн.

Гомбосүрэн депутатын өчигдрийн хэлсэн үгэнд нэг өгүүлбэр гарсан. Хүндэт депутатууд ажигласан байх. Энэ дээр панмонголизм буюу аль эсвэл нармай монгол улсыг байгуулах вий гэдэг энэ асуудал бол дэлхий нийтийн томоохон гүрнүүдийн анхаарлыг татаж байгаа бөгөөд үргэлж ажиглаж байдаг нэг асуудал мөнөөсөө мөн. Энэ бодлого одоо ч хэвээрээ байгаа гэж хэлнэ. Тийм учраас бид БНМАУ-ын газар дээр одоогоор амьдарч байгаа бөгөөд БНМАУ гэж эх орноо нэрлэж байгаа тул энэ нэрийнхээ төлөө цаашид зогсох болно.

22 дугаар тойргийн депутат Л. Дашням: —Би МҮДН-ын бүлгийн өмнөөс ярьж байна. Манай намын бүлэг Их Хурлын үйл ажиллагаа ийм мухардалд орж байгаад ихээхэн сэтгэл харамсаж байгаа. Бид энэ мухардлаас гарах гол арга зам бол манай депутатуудын оюун ухаан гэж ойлгож байгаа. Гэтэл бид нар энэ өнгөрсөн хоногуудад депутат болгон оюун ухаанаа зарж байгаа боловч энэ ажил үр дүнтэй болохгүй байна. Тийм учраас ардчилсан эвсэл, бүлэгт хэлсэнчлэн бид нар энэ оюун ухааныг илүү дайчлах, илүү оновчтой болгох үүд зам нь бүлгүүдийн, бүлгүүд дотроо харьцангуй үг хэлээ ололцоод тэд нарыг цааш нь зангидсан ийм зөвшилцөөн манай хурлын үйл ажиллагааг цааш нь ахицтай болгох нэг арга зам юм байхаа гэж бодож байгаа.

МАХН-ын саналын хувьд бол би бодож байна. Энд бид нар энэ заалны хүмүүс одоо юуны төлөө, яаж санал аваад ямар байдалтай орчихов гэдгийг бараг ойлгогдохгүй болтлоо тийм олон санал авлаа. Миний мэдэж байгаагаар бол БНМАУ гэдэг саналыг бид нар гурван удаа аваад дэгд заасанчлан өөр энэ дээр нэмээд хурлын даргаас дахиж нэг удаа авахуулсан байгаа, дөрвөн удаа. Тэгэхээр одоо ямар байдалтай, яагаад ийм байдалтай болов гэдгийг хурлын дарга нар энэ депутатуудад ойлгомжтой болгооч. Тийм учраас одоо энэ санал авна гэдэг асуудал бол ямар учиртай болж байна, тэгээд МАХН-ын бүлэг дотроо ерөөсөө зөвшилцөх мөртлөө ерөөсөө хэл олсонгүй гэж ирдэг. Энэ бол бүлгүүдийн хоорондын зөвшилцөөн байж болох юмуу, үгүй юу гэдэг асуудалд хүргэж байгааг ч бас анхаараасай гэж бодож байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Ж.Уртнасан -Гуравдугаар микрофон.

Э.Бат-Үүл /52 дугаар тойргийн депутат/ -МАХН-ын бүлэг бие даасан депутатуудын бүлэг нөхцөл байдлыг зөвөөр ойлгож боломжит **хувилбарыг** хайх болов уу гэж ингэж бид ухаарч байсан. Саяын энэ 2 бүлгийн **хатуу** байр сууриа илэрхийлж гаргасан мэдэгдэл нь бидэнд нэлээд санаандгүй байдал бий болголоо. Ийм учраас МоАН-ын бүлэг 15 минутын зөвшилцөх хугацаа олгохыг хурлын даргаас хүсч байна. 15 минут.

Ж.Уртнасан -Өөр үг хэлэх хүн байна уу? 8 дугаар микрофон.

С.Баярцогт /288 дугаар тойргийн депутат/-Залуучууд ардчиллын төлөө бүлэг. Манай бүлэг 258, парламентын бүлгүүд хоорондоо үеэл бодлоо уралдуулж шийдвэрлэх ёстой. Энэ бол улс төрийн бодлогын асуудал.

Хэрэв энд шийдэгдэж чадахгүй бол энэ шийдвэрлэх арга замыг зөвхөн улс төрийн аргаар шийдвэрлэж, зөвшилцөх хэлбэрийг олох ёстой ийм байр суурийг хатуу баримталж байгаа. Энэн дээр залуучууд ардчиллын төлөө бүлэг бол бүх намуудад сануулга гэх юм уу зөвлөмж өгөхийг хүсч байгаа. Намууд бол үзэл бодлын зөвшилдөөнд өөр хоорондоо хүрсэн байх ёстой. Тэгж байж төр бол парламентын аргаар үйл ажиллагаагаа явуулна гэдгийг ил тод харуулах ёстой гэсэн ийм л байр суурин дээр байгаа юм.

Ж.Уртнасан -За өөр эвсэл холбоодоос үг хэлэх хүн байна уу? За байхгүй байгаа юм байна. За тэгвэл Монголын ардчилсан намын хүсэлтээр зөвлөлдөх хугацааг дахин 15 минутаар сунгаж байна.

Монголын социал демократ намын бүлэг 437 дугаар ерөөнд цугларна уу гэж байна. Монголын ардчилсан намынхан "ж"

зааланд.

За хүний эрхийн хорооны Бямбаа, Авхиа, Төмөрбаатар, Лун-
дээжанцан нар наашаа ирнэ үү.

Монголын үндэсний дэвшлийн нам 430 дугаар өрөөнд.

Аймгийн МАХН-ын хорооны дарга нар Даш-Ёндон даргын өрөөнд
очно уу.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

ЭНХТҮЯА

Бичээч Уранчимэг

Ж.Уртнасан -За сая Монголын ардчилсан намын хүсэлтээр 15 минутын завсарлага авсан.Одоо Монголын ардчилсан намын дарга депутат Бат-Үүл, гуравдугаар микрофон .

Э.Бат-Үүл /52 дугаар тойргийн депутат/ -Сая Монголын ардчилсан намын бүлэг хуралдлаа.Тэгээд би та бүхэнд Монголын ардчилсан намын бүлгийн шийдвэрийг танилцуулъя.

Ардын Их Хурлын депутатуудын 12 дахь удаагийн сонгуулийн II хуралдаан шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх чадваргүй болж мухардалд орлоо гэж бид ингэж үзэж байна.Иймд шинэ Үндсэн хуулийн төслийг шинээр сонгогдох Ардын Их Хурлаар хэлэлцүүлэх бололцоог нээхийн тулд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг өөрчилж, энэ удаагийн хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг өөрчилж Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг хэлэлцэх шаардлагатай байна.Үүний тулд Ардын Их Хурлын II хуралдааныг түр завсарлуулж, намуудын бүлгүүдийн төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсгийг Ерөнхийлөгчийн удирдлаган дор байгуулах санал оруулж байна. Манай бүлгийн байр суурь энэ байна.

С.Баярцогт /288 дугаар тойргийн депутат/ -Залуучууд ардчиллын төлөө бүлэг, МСДН-ын бүлэг хамтраад 9 цаг хүртэл завсарлагаа авах хүсэлт байна.

Ж.Гомбожав /326 дугаар тойргийн депутат/ -Их хурлын дарга би танд нэгдүгээрт нэг асууя тавьсан.Тэр хариулагдахгүй байна.

Хоёрдугаарт надад горимын хоёр санал байна.Нэгдүгээрт би очигдөр нэг санал тавьсан.БНМАУ, Монгол улс гэсэн хоёр нэрийг хоёулангий нь хэрэглэж явъя.Тийм эрх бидэнд байна гэж. Энийг шийдэхийн тулд бол их амархан юм шиг харагдаад байгаа юм. Эрхэм хүндэт депутатууд өөр өөрсдийнхөө төслийг үзэхгүй юу. Монгол улсын Их цааз гэдэг төслийн I дүгээр бүлэг дээр Монгол улсын бүрэн эрхт байдал гэсэн гарчиг байгаа.Миний хувьд бол санал ийм байна.Энийг БНМАУ-ын бүрэн эрхт байдал хаалтан дотор

цаашид монгол улс гэж нэрлэнэ гээд ингээд хаалтаа хаачихмаар байна. Тэгэхэд бол бид одоо ч БНМАУ, Монгол улс гэдэг хоёр нэрийг хэрэглээд явж байгаа шүү дээ. Хоёр талуудын саналыг аль алийг нь тусгаж байна. Тэрнээс цааш бол БНМАУ гэж нэрлээд байх ийм шаардлага байхгүй. Энэ Үндсэн хуулийн төсөл дээр. Хэрвээ гарчиган дээр нь болохгүй байгаа бол тэр нэгдүгээр зүйлийн нэг дээр бас тэгээд хийчихэж болохоор байгаа юм. Нэгдүгээрт нэг ийм горимын санал байна. Хэрвээ миний энэ санал зөвшөөрөгдөхгүй бол хоёрдахь хувилбар байна. Энэ асуудлыг эв зүйгээ олоод шийдэж болох ийм хувилбар байна. Би энэ саналаа хэлье.

Энэ юу вэ гэвэл энэ Монгол улсын нэр дээр санал нийлэхгүй байгаа нам, эвсэл бүлгүүдээс хоёроос гурван депутатуудыг оролцуулаад, Ардын Их Хурлын нэг орлогч дарга гаргасан тийм зөвлөлдөх бүлгийг ажиллуулаад энэ нэрийг нээлттэй үлдээгээд цааш нь асуудлуудаа хэлэлцэж явах ийм бололцоо бидэнд байна шүү. Тэр бүлгүүд бол манай хэдэн бүлэг бүртгэгдээд байгаа юм, анхны өдөр бол 9 бүлэг байгаа гэсэн. Хэрвээ тэгэх юм бол 18 хүнтэй зөвлөлдөх бүлгийг Их Хурлын нэг орлогч дарга удирдаад өдөр бүр энэ асуудлаа ярьж байж болно шүү дээ. Тэр хооронд нь энэ 400 гаруй депутатууд цаашид дахь Үндсэн хуулийн асуудлаа ярьж байхад бид болох байна. Ингэж тармааргүй байна. Янз бүрийн завсарлаганууд авмааргүй байна. Ер нь зарим эвсэл, бүлгүүд хариуцлагагүй л ажилласан юм шиг байна. Өдөр бол өнөөдөр 5 цагийн завсарлага авсан байхад хоорондоо ярилцалгүй орж ирчихээд дөнгөж эхлэнгүүт 15, тэгээд цагийн завсарлаганууд аваад байгаа явдал бол бидний хурлыг хурдатгах биш харин одоо сунжруулах ийм байдалд хүргэж болзошгүй байна. Ийм учраас харилцан тохиролцож, (эв эеэ) хичээж асуудлаа шийдвэл яасан юм бэ гэсэн санал оруулж байна.

Н.Ганбямба /415 дугаар тойргийн депутат/ -Би нэг зарчмын тодорхой санал тавих гэсэн юм.

Тэр БНМАУ гэсэн томъёолол дээр санал хураахад түдгэлзсэн хэдэн цөөн депутатуудын нэг юмаа. Энэ БНМАУ, Монгол улс гэсэн хоёр хувилбарын үндэслэгээг бид хэдэн өдөр дараалан ярих явц дунд энэ хоёр тал дээр хатуу байр байсан хүч тэнцүүхэн шахуу

түрүүн бүлгийнхээ зөвлөлгөөний дараа санал хэллээ. Зарим нэр, сүлдний асуудлаар нээлттэй орхиод цаашаа явж болох бололцоо

байна шүү дээ гэж. Тэгэхээр мухардалд орлоо гэж хэлэхээсээ илүү тэрнээс гарах гарцыг яривал энэ мэтээр авч үзээд байж болох зүйлүүд байх шиг санагдаж байна. Тэгэхээр бид бол жишээлбэл хурлыг миний хувьд цаашаа үргэлжлүүлбэ гэсэн ийм санал хэлэх бодолтой байна. Дээр хэлсэн энэ хажуугийн хоёр санал БНМАУ, БНМУ гэсэн хоёр саналыг дахин нэг хэлэлцээд олонхийн санал авсан тэр нэрэн дээр нь уг асуудлыг нээлттэй үлдээх нь зүйтэй байна. Ингээд ер нь нэр бол агуулгатай холбоотой байдаг учраас явц явцдаа хуулийн төслийн дотор асуудлыг хэлэлцээд ирэх үед бидэнд бас буцаад уг нэрнийхээ асуудлыг ярилцах боломж гарна гэж бодож байна. Тийм учраас би дээр хэлсэн нөхдийн саналыг дэмжиж энэ хоёр нэрийн талаар санал хураах байдлаар хурлыг үргэлжлүүлбэ гэж хэлэх гэж байна. Энэ болбол бас МАХН-ын бүлгийн ажлагч нар саяын 15 минутын завсарлага аваад энэ хугацаанд бас саналаа солилцсон энэ санал юм байгаа юмаа гэдгийг нэмж хэлбэ гэж бодож байна.

Д. Дожодорж /31 дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр одоо ер нь хичнээн завсарлага аваад, хичнээн дахин хуралдаад энд олигтой үр дүн, олигтой санал гарч ирэхгүй, мөн л хуучин бахь байдгаараа байгаа учраас энэ цаашаа завсарлага авч цаг идэх явдал их харамсалтай байна. Маш их цаг алдаж байна. Тэгэхээр би ийм горимын санал дээрх нөхдүүдтэй адил дэвшүүлбэ гэж бодож байна.

Нэгдүгээр санал бол тэр Зоригийн хэлснээр ер нь энэ нэрээ нээлттэй орхиод цаад үндсэн зүйлдээ орохгүй болбол бид II өдөр хуралдахад ганцхан хавтсан дээр явж байна. Цаад 70 зүйл байж байна. Энэ маш их харамсалтай. Ийм учраас энийгээ түргэлэхийн тулд үндсэн зүйлдээ орбэ гэж ингэж бодож байна. Нэг.

Хоёрдугаар асуудал гэвэл энэний өмнө ерөөсөө Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээр санал аваад 71 хувь ч болов уу тэгсэн, 68 ч болов уу. Ер нь тэр бол хүчин төгөлдөр юмаа. Аль аль талдаа хоёр хүчний хоорондох нэлээн одоо буулт хийсний үндсэн дээр, эсвэл энэ саналыг хүчинтэй гэж үзвэл ахиж хураах хэрэгтэй гэж үзэж

цаашид монгол улс гэж нэрлэнэ гээд ингээд хаалтаа хаачихмаар байна.Тэгэхэд бол бид одоо ч БНМАУ, Монгол улс гэдэг хоёр нэрийг хэрэглээд явж байгаа шүү дээ.Хоёр талуудын саналыг аль алийг нь тусгаж байна.Тэрнээс цааш бол БНМАУ гэж нэрлээд байх ийм шаардлага байхгүй.Энэ Үндсэн хуулийн төсөл дээр.Хэрвээ гарчиган дээр нь болохгүй байгаа бол тэр нэгдүгээр зүйлийн нэг дээр бас тэгээд хийчихэж болохоор байгаа юм.Нэгдүгээрт нэг ийм горимын санал байна.Хэрвээ миний энэ санал зөвшөөрөгдөхгүй бол хоёрдахь хувилбар байна.Энэ асуудлыг эв зүйгээ олоод шийдэж болох ийм хувилбар байна.Би энэ саналаа хэлье.

Энэ юу вэ гэвэл энэ Монгол улсын нэр дээр санал нийлэхгүй байгаа нам, эвсэл бүлгүүдээс хоёроос гурван депутатуудыг оролцуулаад, Ардын Их Хурлын нэг орлогч дарга гаргасан тийм зөвлөлдөх бүлгийг ажиллуулаад энэ нэрийг нээлттэй үлдээгээд цааш нь асуудлуудаа хэлэлцэж явах ийм бололцоо бидэнд байна шүү.Тэр бүлгүүд бол манай хэдэн бүлэг бүртгэгдээд байгаа юм, анхны өдөр бол 9 бүлэг байгаа гэсэн.Хэрвээ тэгэх юм бол 18 хүнтэй зөвлөлдөх бүлгийг Их Хурлын нэг орлогч дарга удирдаад өдөр бүр энэ асуудлаа ярьж байж болно шүү дээ.Тэр хооронд нь энэ 400 гаруй депутатууд цаашид дахь Үндсэн хуулийн асуудлаа ярьж байхад бид болох байна.Ингэж тармааргүй байна.Янз бүрийн завсарлаганууд авмааргүй байна.Ер нь зарим эвсэл, бүлгүүд хариуцлагагүй л ажилласан юм шиг байна.Өдөр бол өнөөдөр 5 цагийн завсарлага авсан байхад хоорондоо ярилцалгүй орж ирчихээд дөнгөж эхлэнгүүт 15, тэгээд цагийн завсарлаганууд аваад байгаа явдал бол бидний хурлыг хурдатгах биш харин одоо сунжруулах ийм байдалд хүргэж болзошгүй байна.Ийм учраас харилцан тохиролцож, (эв эе , хичээж асуудлаа шийдвэл яасан юм бэ гэсэн санал оруулж байна.

Н.Ганбямба /415 дугаар тойргийн депутат/ -Би нэг зарчмын тодорхой санал тавих гэсэн юм.

Тэр БНМАУ гэсэн томъёолол дээр санал хураахад түдгэлзсэн хэдэн цөөн депутатуудын нэг юмаа.Энэ БНМАУ, Монгол улс гэсэн хоёр хувилбарын үндэслэгээг бид хэдэн өдөр дараалан ярих явц дунд энэ хоёр тал дээр хатуу байр байсан хүч тэнцүүхэн шахуу

ийм хэсэг гарчихлаа л даа. Тэгээд бид өнөөдөр мухардалд орсон шалтгаан бол энэ хоёр хатуу байр сууриа цаашид үнэхээр явахгүй байдалд орох нээ. Ийм учраас миний хэлэх гээд байгаа санаа бол БНМУ гэсэн, өөрөөр хэлбэл энэ хажуугийн хоёрдахь хувилбарыг, хувилбараар дахин санал авч өгөх талаар анхаарч өгнө үү гэсэн ийм санал байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол бид төрийн удирдлагынхаа хэлбэрийг агуулгаас нь аваад мөн давхар нэрэндээ зүүсэн нэг ийм томъёоллоор бид нэг удаа санал авбал ясан юм бэ гэж. Үндэслэлийг би олон хоног ярьсан учраас би бас давтаж ярих, дэлгэрүүлж ярих шаардлагагүй болов уу гэж бодож байна. Тийм учраас БНМУ гэсэн энэ томъёоллоор дахин санал хурааж өгнө үү гэсэн хүсэлт байна.

Ж.Норовсамбуу /303 дугаар тойргийн депутат/ -Ардын Их Хурлын депутатууд бид төрийн эрх барих дээд байгууллагынхаа үйл ажиллагааг удирдан зохицуулж, үйл ажиллагааг нь хөтөлж явуулах бүрэн эрх, итгэл найдвар ард түмэн бидэнд олгосон. Энэ хурлыг бид үргэлжлүүлж ямар ч асуудлаар монгол хүмүүс хоорондоо асуудлаа зохицуулж санал бодлоо солилцож шийдвэрлэх бүрэн үндэс байна гэж бодож байна. Нэмэлт санал бол МАХН-ын Төв Хорооны дарга Даш-ёндон санал гаргалаа. Улсын Бага Хурлаас оруулсан Монгол улсын Их цааз гэдэг үндсэн төслийг хэлэлцэж байгаа нөхцөлд гарсан үндсэн хоёр хажуугийн санал байгаа. БНМАУ, БНМУ гэсэн хоёр нэрээр санал хурааж олонхийн санал авсан нэрийг нээлттэй үлдээж хэлэлцэх асуудлыг дарааллаар нь зүйл, бүлгээр нь хэлэлцүүлж өгөөч гэсэн саналыг оруулж байна.

Д.Дэмбэрэл /234 дүгээр тойргийн депутат/ -Миний хэлэх гэж байгаа санал бол дээрх нөхдийнхтэй төсөөтэй байна. Ер нь бид бол энд хамгийн гол зорилгоо гэж тавьж байгаа зүйл бол энэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх асуудал байгаа. Энэнээс яаран ухармааргүй байна, үндсэн зорилтоосоо. Энэ мухардмал байдалд орчихлоо гэсэн дүгнэлтийг бас эрт хиймээргүй байна гэж тэмдэглэж хэлмээр байна. Ингээд миний санал бол энэ Зориг депутат түрүүн бүлгийнхээ зөвлөлгөөний дараа санал хэллээ. Зарим нэр, сүлдний асуудлаар нээлттэй орхиод цаашаа явж болох бололцоо

байна. Ингэж хэрэв тохирох юм бол энэ бол болохгүй гэхийн газаргүй гэж би хувьдаа бодож байгаа юм.

Гуравдугаар санал бол ерөөсөө энэ чинь одоо БНМАУ, БНМУ гэдэг ийм хоёр хажуугийн санал гэж байгаа. Үндсэн санал маань хоцрогдчихоод Монгол улс гэдэг чинь саналыг хураахгүй байна шүү дээ. Энэ үндсэн санал бол хажуугийн хоёр саналд давамгайлж гарч ирсний нэг үндсэн саналтай өрсөлдөж санал хураана гэсэн ийм томъёолол байсан. Энэ одоо хүчингүй болчихсон юм шиг байгаа юм. Тэгэхээр гурвууланг нь санал хураах хэрэгтэй. Тэгэхгүй бол үндсэн санал хүчинтэй гээд байдаг, төсөл нь ерөөсөө ярилцагдахгүй ингээд Бага Хурлын оруулсныг ерөөсөө хэлэлцэгдэхгүй байна шүү дээ. Хэрэв үндсэн санал хүчинтэй байдаг юм бол хүчинтэйгээр нь тооцоод дор хоёр саналын аль жаран хэдэн хувь авсан байдаг юмуу тэнд ёстой өрсөлдүүлэх хэрэгтэй байна. Энийг ялгаж өгөхгүй болохоор гурван юмны хооронд ацан болчихоод байнаа. Энийг шийдэж өгөөчээ. Завсарлага олон авахад үндсэндээ маш их цаг алдаж байна, маш их хөрөнгө үрэгдэж байна. Баярлалаа.

П. Энхсайхан /327 дугаар тойргийн депутат/ -Манай хоёр дугаар хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудал Үндсэн хуулийг, төслийг хэлэлцэж байгаа асуудал бүхэлдээ мухардалд ороогүй гэж бодож байна. Депутатууд бол Монгол улсынхаа нэрийг хэлэлцэх асуудал дээрээ мухардалд орсон байнаа гэж бодож байна. Зүгээр горимын санал дээр нэгдүгээр зүйлийн I-д бол Монгол улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт бүгд найрамдах улс мөн гэж байгаа юм. Тэгэхээр энийг агуулгын хувьд өөрчлөгдөхгүй, БНМУ гэдэг нэрэн дээрээ дахиад нэг санал хураавал яасан юм бэ гэсэн санал байна.

Ж. Уртнасан

Аль хувилбараар гэнээ.

П. Энхсайхан: БНМУ, Хуулийн төсөлд бол Монгол улс бол БНУ мөн гэж томъёолсон байгаа л даа. Тэгэхээр БНМУ гэдэг дээр санал хураавал яасан юм бэ.

Ж. Уртнасан

Саналууд олон байна. Бид дэс дарааллаар хэлэлцүүлж санал хураалганаа.

Соронзон хальстай тулгаж нийлсэн

Бичээч Уранчимэг

Алтанцэцэг

АЛТАНЦЭЦЭГ

1991.11.21
Кассет № IY-4I
18.45 -19.58

52 дугаар тойргийн депутат: Э.Бат-Үүл: Тэгэхээр би Хурлын даргад нэг зүйлийг анхааруулъя. Түрүүн бид нар МОН-ын саналаар завсарлага авсан. Энэ завсарлагаар бид нар хэлэлцээд өөрсдийнхөө дүгнэлтийг, тодорхой саналтайгаа оруулж ирсэн. Тэгэхээр энэ бидний оруулж ирсэн энэ саналыг хэлэлцэх хэрэгтэй байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, шаардлагатай гэж үзвэл бид өөрсдийнхөө мухардмал байдалд орсон гэдгээ депутатуудад бүрэн тайлбарлаж чадаж байна.

Гуравдугаарт, нэг анхааруулах зүйл бол Гомбожав дарга сайн нэлзэн гүжирдсэн өнгө аясаар ярилаа. МАХН өөрийн тодорхой саналтай орж ирсэн бол бидэнд бас тодорхой санал байсан. Гэтэл бидний бодож байснаас өөрөөр асуудалд хандаж орж ирсэн явдал бол биднийг тийм шийдвэр гаргахад хүрсэн.

24 дүгээр тойргийн депутат Р.Хатанбаатар: Хурлын даргаа бид завсарлах цаг хүссэн, та энэ асуудлыг яагаад тавихгүй байна вэ?

Ж.Уртнасан: Хураалгая, одоо санал хураалт явуулна, МСДН-ын завсарлага авах саналыг одоо бид хэлэлцүүлнэ.

375 дугаар тойргийн депутат Баяндалай:

Би хурал, чуулган маань үргэлжилж байна гэж бодож байна. Тийм мухардалд орсон юм алга байна. Бид чинь ахмад үеэ, залуучууд аа, дунд үеэ, Ерөнхийлөгчөө, Их Хурлаа хүндэтгээд, бүгдээрээ харилцан ухаалгаар асуудлыг хоёр талаасаа буулт хийгээд, нэг шийд гаргаж яагаад болохгүй байна вэ? Яг энэ шийдэл гаргах даваан дээр ирчихээд байна гэж би бодож байна.

Эрхэм депутатууд минь үүнийг анхаарч өгөөч. Манай энэ ахмадууд маань ухаалаг бодооч дээ. Залуучууд маань бас одоо ухаалгаар бодооч дээ. Асуудалдаа харилцан аль аль талдаа бололцоотой ийм шийдлийг гарах даваан дээр ирчихээд, тэгээд гарч чадахгүй байна гэж бодоод байна. Би бод мөхөс миний бие юм мэдэхгүй, гэхдээ бага зэргийн юм уншдаг. Манай монголчууд чинь би биендээ мэтгэлзсээр байгаад, харийн колончлолд орох замыг тавьж байсан гашуун туршлага одоогоос 300 гаруй жилийн өмнө бий шүү. Бид чинь өчигдөр, уг дотор сэтгэлдээ бодож явдаг, зүрхэндээ бодож явдаг, бүх нууцаа илэн далангүй ярьсан шүү. Эндээс хүмүүс янз янзын дүгнэлт хийсэн шүү. Үүнийгээ бид бодъё л доо. Энэ чинь мухардаад байх юм алга байна шүү дээ. Намуудаас оруулж ирсэн саналыг хурлын дарга анхааралдаа авч үзээд энэ депутатуудаараа хэлэлцүүлье л дээ. Яах юм гэж? тарах юм уу? болих юм уу? завсарлага авах юм уу? Хурлаа цаашаа үргэлжлүүлэх юм уу? яах юм бэ? Үүнийг бид л шийдэхээс биш, ямар нэгэн нам шийдэхгүй биз дээ. Энэ чинь ямар намын хурал биш дээ. Тэгэхээр МАХН ч гэсэн өөрийнхөө үйл ажиллагаанд дүгнэлт хийх хэрэгтэй. Би өөрөө МАХН-ын гишүүн. Тодорхой саналтай орж ирэх байх гэж бодсон. Алга байна. Хуучин л бахь байдаг БНМЖУ гэдэг дээр санал өгнө гэсэн ийм бүдүүн хатуу ийм хөшчихсөн ийм юм битгий хэл л дээ. Бид чинь ухаалгаар сэтгэдэг, эрүүл саруулаар боддог, ийм юм байна шүү дээ. Бүгдээрээ сайхан ухаалгаар, бүр тайван сууж байгаад, нэг бодоод үзье л дээ. Тэгээд санал хураах юм дээрээ саналаа хураагаад, ярилцах юман дээрээ ярилцаад, цаашаа явах юман дээрээ яваад, ингээд бүр болохгүй бол дахин цуглараад явъя л даа. Энэ олон бүлэг, эвсэл холбоодууд чинь яагаад ч байгаа юм мэдэхгүй, толгой эргүүлээд ингээд бужигнуулаад байх юм байна шүү дээ. Одоо битгий тэг л дээ. Энэ чинь өвөл байна, хүйтэн болж байна, зарим газар нь цас шуурга болж байна, зарим нь бүр урд сууж байна, энэ чинь хэцүү байна шүү дээ. Энэ дээр бүгдээрээ нөхдүүд минь анхаараад ухаалаг шийд гаргая л даа.

Би энэ чуулган бол ямар нэгэн хязгаарлагдмал байдалд орчихоод бүр цаашаа явахаа больчихоод байна гэж бодохгүй байна. Харин яг явах даваан дээрээ хүрч ирчихээд, яг ингээд тунараад байна.Одоо цааш нь явуулъя л гэж бодож байна.

40 дүгээр тойргийн депутат Дагвадорж:

Бидний хурал үргэлжилж байна.Бид нэг юмыг бодох ёстой. Бид эх орон, ард түмэндээ хайртай ийм хүмүүс энд хуран цугларсан.Бид маргалдаад ямар ч асуудлыг шийдэж чадахгүй.Ийм учраас би юу гэж хэлэх гэж байна вэ? гэхээр БНМАУ гэсэн энэ нэрээр дахин санал хураах ийм хүсэлгүй байгаа бол БНМУ гэсэн энэ хажуугийн саналаар санал нэг хураалгаж өгөөч ээ гэж хүндэт даргаас хүсч байна.Яагаад гэвэл өнөөдөржингөө бид нар завсарлага авлаа.Үүний үр дүн бас байх ёстой шүү дээ. Үүнийг манай улс төрийн нам, хүчин бүх хүмүүс харгалзаж үзээч ээ.

287 дугаар тойргийн депутат Хурц:

Тэгэхээр бид энэ ард түмнийхээ өмнө хүлээсэн хариуцлагаа маш хатуу ойлгох ёстой юм.Монголын ард түмэн энэ хамгийн төрийн дээд эрх барих энэ байгууллагынхаа шийдийг хүлээж сууж байна.Одоо хурал мухардалд орчихсон гэж ярьж байна. Хурал мухардалд ороогүй.Бид ганцхан БНМАУ уу, Монгол улсуу гэдэг асуудал дээрээ л харилцан бие биенцээ тайлбарлаж, ойлголцох асуудал бидэнд үлдээд байна.Тэгэхээр миний санал бол нэгдүгээрт, санал маань Дагвадоржийн саналтай адилхан байна.БНМАУ гэсэн саналыг нэгдүгээрт санал хураалгаж өгөөч,

Хоёрдугаарт, би энэ Гомбожавын саналтай бараг төсөөтэй юм.Ер нь редакцийн шинж чанартай ингээд цаашаагаа яриад ирэхээр бидэнд бас ярьж болох вариантууд байна.Жишээ нь миний хоёрдугаар вариант бол Монгол улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт бүгд найрамдах монгол ард улс мөн гэж ингэж хийж болмоор байна.

Энэ санаа бол монгол улс гэж одоо бидний нэрлээд байгаа чинь Бүгд найрамдах монгол ард улс мөн юм шүү гэдгийг даян дэлхийд зарлаж өгөх ийм вариант байгаа юм.

Ийм учраас бид энэ асуудал дээр айхтар их сэтгэлийн эмоциар биш, хүлээцтэй, залуу үе нь залуу үедээ, ахмад үеэ хүндэлж, ахмад үе нь залуу үеэ хүндэлж, харилцан бие биенийгээ хүндлэх системээр энэ хурлынхаа үйл ажиллагааг цааш нь явуулах явдал бол та бидний Монголын ард түмний өмнө хүлээсэн хатуу хариуцлагатай үүрэг гэдгийг дахин хэлье гэж бодож байна.

Ингээд миний хоёр санал дээр санал хурааж өгөхгүй юу гэж хүсч байна.

Ж.Уртнасан: Саналуудыг хэлэлцүүлэхгүй бол давхардаж байна. Санал хэлэлцүүлмээр байна. Энэ түрүүчийн уг хэлснээс өөр санал байна уу?

247 дугаар тойргийн депутат Шоовдор:

Тэгэхээр би энэ Их Хурлыг үргэлжлүүлэх саналтай байна. Гэхдээ бидэнд энэ танхимын нэг ийм уур амьсгал байна. Би өөрөө ойлгохдоо, энэ Бага Хурлаас оруулсан санал ер нь өөрчлөгдөхгүй юм байхаадаа гэсэн тийм ойлголт манай депутатуудад байгаа юм биш байгаа даа гэж ойлгож байна.

Гэхдээ энэ хуулийн төслийг би хүндэтгэж байгаа. Манай Монголын энд л хандгах улсууд оролцсон учраас би энэ хуулийн төслийг хүндэтгэж байгаа. Хуулийн төсөл маань тийм цогц, тийм өнөөдөр ярьж байна билээ, Бага Хурлын улсууд, тийм амьд организм шиг нэг хэсгийг нь хасчих юм бол нөгөөдөх нь болохоо байчиддаг ийм юм ярьж байна билээ. Тэгэхээр энэ бол тийм байдаг байх. Энэ аргагүй юм. Энэ бүхнийг бид нар бас мэдэж байх албагүй, ийм юм.

Тэгэхээр Бага Хурал нэг хуралдаж, хэдэн цагаар байдаг юм? 2,3 цагаар хуралдаж, энэ оруулж байгаа төслийн 71 зүйлээс ямрыг нь өөрчилж болох юм бэ? ямарт нь гарч хүрч болох вэ? ямрыг нь болохгүй юм бэ? гэсэн ийм асуудлыг тайлбарлаж оруулмаар байна.

Өөрөөр хэлбэл өчигдөр Бага Хурлын гишүүд, орлогч дарга, дарга нараас оруулсан тэр тайлбар саналаас үзэхэд бол мөн улсуудын хэмжээнд өөр ойлголт төрмөөр ийм юм ажиглагдаж байсан. Ийм учраас энэ асуудалдаа бас эргэж харвал яасан юм бэ? Тэгэхгүй бол нэрнээсээ өгсүүлээд ер нь өөрчлөгдөхгүй юмнууд, энэ Их Хурлаар өөрчлөгдөхгүй, ингэж үлдэх гээд байна. Ийм учраас, хэрвээ энэ хурал ингэж хуралдаад, цаашдаа төсөл гарвал зарим нь Бага Хурлаар батлагдсан, зарим нь Их Хурлаар батлагдсан ийм хоёр төрлийн хурлаар батлагдсан ийм хууль гарах нь ээ. Энэ маань үнэн чанартаа тэр нэмэлтийн тухай хуультайгаа харшилсан ийм асуудал болох нь ээ гэж ингэж бодож байна.

94 дүгээр тойргийн депутат Б.Сандуйжав:

Тэгэхээр би оршилгүй өөрийнхөө саналыг хэлье. Ер нь бидний хуралдааны явц их удааширч, мухардмал байдалд ороход бэлэн болжээ. Үүнийг үгүйсгэх арга алга. Одоо үүнээс гарах хоёрхон арга зам байна. Эсвэл бүр хуралдаанаа зогсоож тарах, нэг хэсэг улсууд ярьж байсан, эсвэл хуралдаанаа үргэлжлүүлж, зөвшилцөх ийм хоёр арга зам байна.

Энэ нэгдүгээр арга замыг хүлээж авах бололцоогүй, энэ дээр манай депутатууд ихэнх нь санал нэгтэй байгаа байх гэж ойлгож байна. Тэгэхээр би саяны тэр депутат Ганбямбын тавьсан саналыг би төдийгүй манай Баянхонгор аймгийн хэсэг депутатууд бас сая ярилцаж ер нь БНМУ гэсэн хажуугийн саналыг дахин хурааж өгөөч ээ гэж ингэж хүсч байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ
ТУЛГАЖ НИЙЛСЭН



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

АМХ-ын ээлжит II
хуралдаан

КАССЕТУ.42 1991.XI.21.

18.58- 19.04 цаг

- Энэ дээр Их журлын II дэх өдрийн хуралдаанд 2 дахь удаагаа босч би уг хэлж байна. Уг хэлэх бололцоо их муу байна. Санал бодлоо хэлэх гэхлээр микрофон олдохгүй, энд хориодхон хүн жижүүрлээд авчихсан, ер нь танхимын доторх депутатууд бүрэн оролцохгүй байна шүү. Энийг зориуд би анхээрүүлж хэлээ гэж бодсон юм, нөхдүүдэд. Энэ төслийн I.I-д Бүрэн эрхт бүгд найрамдах улс мөн гэж баталгаажуулж өгсөн. Ингэснээрээ эжний Бүгд найрамдах гэсэн хоёр үсгийг авч болж байгаа юм. Харин нэмэлт тодорхойлолт бол манай орны тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн улс улс хоорондын болон дэлхий дамины түүхэн баримт бичгүүд хүчин төгөлдөр байх болно гэдгийг Үндсэн хуулиндаа баталгаажуулж өгч болж байна.

Хоёрдугаарт нь "ард" гэдэг үгийг хасч болж байна. Хэрэв ард гэдэг үгийг хасвал мөн Үндсэн хуулиндаа Ардын гэдэг үгийг аливаад хэргэлж болох хууль эрхийн баталгааг шигтгэж өгөх хэрэгтэй юм. Жишээлбэл: ардын жүжигчин, ардын багш, ардын эмч, ардын арми, ардын аж ахуй гэх мэт. Хэрэв энэ үгийг шигтгэж өгч чадвал, баталгаажуулж өгч чадвал ардын гэлгүйгээр БНМУ гэж болохоор байгаа юм. Тэгээд түрүүчийн хүмүүсийн саналын дагуу би энэ нэр дээр дахиад санал хураахыг санал болгож байна. Ерөөсөө энэ хурал мухардаагүй, цаашдаа үргэлжлэн явагдаж байна. Үргэлжлүүлэх нь бидний эрх, үүрэг гэж би бодож байна.

С.Зориг /9-р тойргийн депутат/ - Сая ардчилсан хүчний эвслийнхэн хуралдлаа. Тэгээд энэ мухардлаас гарах асуудлыг бид хэлэлцэж арай дуусаагүй байна. Одоо шууд санал хураалт хийсэн тохиолдолд ямарч үр дүн гарахгүй нөхцөл бүрдээгүй гэж үзэж байгаа. Тийм учраас манай ардчилсан хүчний эвслээс оройн 21 цаг хүртэл завсарлага авах санал гаргаж байна.

Ж.Уртнасан - Эрхэм депутатуудаа бидэнд хэд хэдэн хувилбар санал ирлээ. Тийм учраас бид хэлэлцэж ярилцах нь зүйтэй

С.Зориг - Уртнасан даргаа, завсарлага өгөх эсэхээ шийдмээр байна.

Ж.Уртнасан -Завсарлага өгнө. Уучлаарай Зориг депутатаа, санал хураалт явуулая. Ганцхан санал хураалт явуулаа. Бидэнд гурван хувилбар байна. Үүнийг тоймловол, хамгийн эхлээд МоАН-ын дарга Э.Бат-Үүлийн оруулсан Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг хэлэлцэн Ерөнхийлөгчийн дэргэд удирдлагын хороо байгуулаа гэсэн санал байгаа юм. Хоёрдох нь завсарлага авах асуудал нээлттэй. Гуравдах нь БНМАУ, БНМУ, мөн зарим депутатууд Монгол Улс гэсэн нэрээр санал хураалгаачээ гэсэн санал байна. Энэ дээр бид гөримын гуравдахыг шалгаруулах буюу гадаалах хуулийг хэрэглэж болох юм. Бид бас хуульчид зөвөлсөн.Гурван нэрээ **хэлэлцээд** хамгийн олон санал авсан хоёрыг нь үлднэгээд дахин тэр хоёрыгөө хэлэлцээд үлдсэн хувилбараа анхны хэлэлцүүлэгтээ хэрэглээд явъя гэсэн ийм хувилбараар санал хураалт явуулах асуудал бидэнд нээлттэй байна. Тэхээр юуны өмнө нэгдүгээр хувилбар МоАН-ын дарга Э.Бат-Үүлийн хувилбар байгаа юм.Үүнийг хэлэлцүүлбэ. Хоёрдах нь бид тэртэй тэргүй завсарлана. Гуравдах нь Монгол улсын гурван нэрэн дээр санал хураалт явуулаад гуравдахийг нь хасаад хоёр дээр нь дахин санал хураалт явуулаад үлдсэн ганц саналыг аваад явах ийм санал байгаа юм. Одоо депутатууд санал хураалтанд бэлтгэнэ үү. МоАН-ын даргын санал ёсоор санал хураалт явуулчихаад завсарлая, депутатууд аа.

Монголын социал демократ нам, ардчилсан залуучуудын эвслийн саналыг бид хүндэтгэн үзэж байна. Одоо бидэнд үйлчилж байгаа олон хүмүүс байгаа юм.Ялангуяа гуанз, рестораны хүмүүст өвлийн хүйтэнд оройтход унаа техникийн хувьд их хүндрэлтэй. Тийм учраас та бүгдийг оройн зоогоо бариад 2Г цаг гэхэд энэ танхимдаа цуглахыг урьж байна.

Ардчилсан эвслийнхэн Ш зааланд.

МАХН-ын гишүүд эндээ үлдэхийг зарлаж байгаа юм байна.

Соронзон хальстай нийлсэн *Ц.Баярмаа* Ц.Баярмаа
Бичээч С.Туул

Ж.Уртнасан:--Эрхэм депутатуудын оройн амгаланг айлтгая. За бид цаг багатай учраас сунган хуралдаж байна.Өнөөдөр хурлын уур амьсгалыг зөөлрүүлэх,харилцан тохиролцоонд хүрэх, зөвшилцөх зорилгоор намын болон эвсэл,холбоод,бүлгүүд олон удаа завсарлага авлаа.Ямар нэгэн хэмжээгээр бид нэг л зорилгын төлөө явж байгаа учраас ямар нэг хэмжээгээр бид тохиролцоонд хүрсэн гэж бодож байна.Одоо завсарлага авсан нам,эвсэл холбоодын бүлгийн ахлагч нарын үгийг сонсоё.

Ардчилсан эвсэл бүлэг Р.Барсболд:-- Арлын Их Хурлын II /АИХ-ын 3-р тойргийн депутат/

цахь удаагийн хуралдааныг цаашид бүтээлчээр явуулах зорилгоор хэлэлцэж байгаа асуудлаар бий болсон хүнд байдлыг гэтлэн туулж, зөвшилцөх арга замыг өргөжүүлэхийн тулд улсын нэрд Бүгд Найрамдах Монгол Улс гэдэг саналыг дэвшүүлж байна. Эрхэм депутатууд тунгаан үзэж саналаа хураахыг хүсч байна.

МоАН-ын дарга Э.Бат-үүд:-- Бид нар асуудлыг зөвшилц хүргэж цааш явах үүднээс Бүгд Найрамдах Монгол Улс гэдэг нэр дээр санал хураах ийм горимын санал тавьж байна.Дэмжиж байна.

МАХН-ын дарга , АИХ-ын 42 дугаар тойргийн депутат Л.Даш-ёндон: --Тээглэгдсэн зүйлийг урагш нь хөдөлгөхөд олуулаа саналаа нэгтгэж,ажлаа ахиулахыг оролцохоос өөр аргагүй боллоо.Саяын депутатуудын тавьж байгаа саналыг дэмжиж байна.Өөрөөр хэлбэл бид төр улсынхаа нэрийг Үндсэн хуулиндлаа Бүгд Найрамдах Монгол Улс гэж томъёолж оруулах энэ саналыг дэмжиж байна.Энэ саналын тухайд, өөрөөр хэлбэл энэ улсын нэрийн тухайд би өөрийнхөө намын дотор ажилладаг бүлгийн ахлагч нартай товч саналаа солилцсоныг тэмдэглэж байна.

Арлын Их Хурлын 22 дугаар тойргийн депутат Л.Дашням:-- Энд гарч байгаа санал Бүгд Найрамдах Монгол Улс гэдэг саналыг

манай намын бүлэг дэмжиж байна. Монголын Үндэсний дэвшлийн нам энэ саналыг дэмжиж байна.

Ардын Их Хурлын 10 дугаар тойргийн депутат О. Дашбалбар:— Бие даасан депутатуудын бүлэг өөрийн үзлээс буцахгүй энэ зөвшилийг эсэргүүцэж байна. Хувь хүмүүс ганц нэг хун манай бүлгээс татгалзаж байгаа явдал бий. Гэхдээ зууны ерэн хэдэн хувь нь дэмжиж байгаа учраас бид үеэл бодлоосоо буцахгүй. Хоёрт гэвэл энд байгаа депутатуудыг би зүгээр МАХН-ын бүлгийнхэнд үнэхээр харамсаж байна. Ардчилсан хүчнийхний эднийг эагнаад байгаа нь ч бас зөв талтай юм шиг байна. Ийм нялцгай, цагийн зүү шиг нааш, цааш савласан энэ хүмүүс бол харамсалтай байна. Одоо би бол аливаа нэг намын бүлэгт, алиныг нь ч одоо үл тоох бөгөөд, бүх намууд эх орныхоо хувь заяагаар тоглож байна гэж үзэж байна. Ийм учраас бие даасан депутатуудын бүлгээс зүгээр энд байгаа депутатуудыг хэрвээ эх оронч сэтгэл гаргаж байгаа бол аль нэгэн намын эрх ашгийн үүднээс бус Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг нэрийнхээ төлөө, депутатынхаа, сонгогчдынхоо өмнөөс санал өгөхийг хүсч байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг нэрээр санал хураалгахыг энэ депутатуудын бүлгийн өмнөөс хүсч байна.

Р. Хатанбаатар:— Монголын социалист демократ намын бүлэг бол Монгол улс гэдэг нэрийн төлөө байгаа. Гэхдээ бид хуралдааныг мухардмал байдлаас гаргаж зөвшилд хүрч, цаашид энэ хуулийнхаа хэлэлцүүлгийг үргэлжлүүлэхийн тулд санал хураалтанд оролцоход бэлэн байна.

Г. Ганбалд:

Залуучууд ардчиллын төлөө гэсэн бүлгийн байр суурийг бүлгийн ахлагч, депутат Баярцогт түрүүн илэрхийлсэн. Манай бүлэг зарчмын хувьд бол ер нь Үндсэн хуулинд, Их цаазад заасан одоогийн төсөлд заасан зарчмын байр сууриудыг хадгалахын төлөө ийм байр суурьтай байгаа. Харин дашрамд хэлчихэд энэ 10 залуучууд нэгдсэн энэ бүлэг бол ямар нэг улс төрийн нам, бүлэглэлийн эрх ашиг, тэдний бодлогыг баримтлахгүй байгаа гэдгийг дашрамд хэлчихье. Бид бол Монгол улс гэсэн нэ-

рийн төлөө байгаа. Гэхдээ нэгэнт Ардын Их Хурлын чуулганыг цаашид явуулах, зөвшилцлийн замаар асуудлыг шийдэхийн үүднээс Бүгд Найрамдах Монгол Улс гэсэн нэрийн төлөө санал хураахад саналаа өгч байгаагаа энэ дашрамд тэмдэглэе.

Ж.Уртнасан:—За баярлалаа. Манай хуралдаанд оролцож байгаа гол гол эвсэл бүлгүүд зөвшилцөлд хүрсэн юм шиг байна. Ийм учраас бид нэг томъёоллоор санал хураахад бэлэн болжээ гэж ингэж ойлгож байна. Санал хураахад бэлтгэнэ үү. Ирцээ эхлээд авъя. Техникээ нэг шалгая. Энэнд бид найцаж байна. Юуний өмнө депутатуудын ирцийг бүртгэж байна. 92 хувь буюу ЗЭГ хүн санал хураалтанд бид хүчин төгөлдөр байна. Ийм учраас та бүгдийг санал хураалтанд бэлтгэхийг хүсч байна. Санал хураалтын томъёолол улсын нэр "Бүгд Найрамдах Монгол Улс". Санал хураалтанд бэлтгэнэ үү.

За баярлалаа депутатууд. Зарим депутатууд нэмж орж ирж байна. Сүүлд орж ирсэн депутатууд томъёоллыг сонсоогүй байх. Эвсэл, намын бүлгүүд зөвшилцөөнд хүрсний эцэст бид "Бүгд Найрамдах Монгол Улс" гэсэн томъёоллоор улсын нэр дээр санал хураалт явуулж байна. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

Улсын нэрээр санал хураалт явуулж байна. Томъёолол "Бүгд Найрамдах Монгол Улс"

Баярлалаа. Санал хураалтанд 427 депутат буюу ирвэл зохих депутатуудын 94 хувь нь оролцсон байна. 268 буюу цийлэнхи олонхи нь 67 хувийн саналаар улсын нэр "Бүгд Найрамдах Монгол Улс" гэсэн томъёоллоор анхны хэлэлцүүлгийг гэтэлж байна. Баярлалаа депутатууд аа.

Эрхэм депутат Дашбалбар бие даасан депутатуудын бүлгийн саналыг оруулж байна. Та бүгдийг санал хураалтанд бэлтгэхийг хүсье.

Улсын нэрийн томъёолол "Бүгд Найрамдах Монгол Ард Улс". Санал хураалтанд бэлтгэнэ үү.

Санал хураалт явуулж байна. За эрхэм депутатууд аа та бүхэнд баярлалаа.

Одоо хуулийн анхны хуудсыг эргүүлбэ. Хуулийн удиртгал хэсэг байгаа. Бид нэг алхаж үзээд зогссон. Удиртгал хэсгийн талаар хуулийн төслийг оруулж байгаа субъект Бага Хурлын тайлбар сонсох уу?

За баярлалаа. Тэгвэл санал хэлэх депутат байна уу? За баярлалаа.

Ардын Их Хурлын II дүгээр тойргийн депутат Ж. Бямбаа:— За энэ нэг, хоёр, гурав дахь хэсэг дээр, төр ёс гэж эхэлж байгаа хэсэг дээр төр ёс, түүх, шашин, соёлынхоо уламжлалыг. Энэ шашин бол энд орох ёстой гэж би өөрийн санал дэвшүүлж байна. Төр ёс, түүх, шашин, соёлынхоо гээд. За энэ Монгол улсын Их цаазыг даяар олноо гэж байна шүү дээ тийм ээ. Энэ дээр бол даяар олноо гэхлээр чинь зэрэг хэнд тунхаглаж байгаа юм, цэлхий дахинд тунхаглаж байгаа юм уу, хаана тунхаглаж байгаа юм, өөрийнхөө ард түмэнд тунхаглаж байгаа юмуу, энэ ойлгомжгүй байна. Тэгэхлээр энэ даяар олон гэдэг үгийг хасья гэдэг ийм л хоёр санал байна.

Ардын Их Хурлын 59 дүгээр тойргийн депутат Ч. Пүрэвдорж:— Энэ дээр би тайлбаргүйгээр санал оруулж байна. Энхийг эрхэмлэх гэдэг уг оруулмаар санагдаад байна. Энхийг эрхэмлэх. Хаана нь байдаг юм, нэг бололцоотой газар нь. Ивээгээд байх юм байхгүй, хүн төрөлхтөний ч гэдэг юм уу, хаана орохоосоо ач холбогдол нь хамаарахгүй юм. Тэгээд хоёрдугаар обзацыг төр нэгдүгээр зүйлийн хоёрдугаар зүйлтэй жаахан уялдуулж, хоёрдугаар зүйлээ хэлэлцэхдээ байдаг юм уу, эндээ байдаг юм уу жаахан уялдуулах хэрэгтэй юм шиг байна.

Ардын Их Хурлын 293 дугаар тойргийн депутат И. Бадарч:— Монголын ард түмний үндсэн хүсэл, эрмэлзлэл, цаазын гол зорил-

гыг дэлхий дахинд зарлан тунхаглаж байгаа, хуулийн агуулгыг тодорхойлон харуулах чухал хэсэг юм. Энд таван хэсэг дээр гол санааг хураангуйлан нэлээд аятайхан гаргасан. Хуулийг хэр ээрэг настай болох, ирээдүйгээ зөв харж чадах эсэх онолын чухал асуудал энд байна. Ард түмнээр хэлэлцүүлэхэд санал гараагүй юм байх даа. Анхны хэлэлцүүлгийг харьцуулж үзэх юм бол анхны хэлэлцүүлгийн үед гарснаас эх оронлоо хүнлэг, ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэх зорилт гэснийг шинэ төсөлд хүнлэг гэдэг үгийг иргэний гэдэг үгээр сольж ганцхан үгийн өөрчлөлт хийжээ. Ганцхан үг төдий ч энэ ихээхэн ач холбогдолтой үг ээ. Иргэний ардчилсан нийгэм гэдэг асуудал бидний чин хүсэл боллоо. Энэ нийгмийг сонгож авснаараа бид социализмаас бүрэн татгалзаж, хуучин бидний нэрлэж байсан капитализм уруу, өөрөөр хэлбэл төвлөрсөн хатуу төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн эдийн засгийн системд шилжиж байгааг ойлгож байна. Тэгэхдээ капитализмын бүх дамжсан олон зуун жилийн хар бараан зам уруу биш, өнөөгийн их хөгжсөн иргэний нийгэм болсон энэ үе уруу нь тэдний зээл тусламжийг авч ашиглах замаар туршлагыг нь хэрэглэх замаар ороод явчихна гэсэн ийм ойлголтыг би авч байна. Энэ зөв үү? Тэгж байж л бид нар 30-40 жилийн дотор "бар" болно гэж ингэж л ойлгож байна.


Монголчууд бид нийгмийн хөгжлийг алгаслах дуртай. Энэ талаар дэлхий дахины түүхэн туршлагатай, туршлага гаргаж, капитализмыг алгаслан хөгжсөн орон маань өнөөдөр дээшээ дэвшил уруу нь алгасах биш, доошоо туулж ирсэн замыг нь алгасч болохоор ийм одоо бүцэг санаа байгаа юм аа. Бид буурай хөгжилтэй орон шүү дээ. Капитализм их хөгжиж байж өнөөгийн иргэний нийгмийн хэмжээнд хүрсэн энэ зам уруу нь баттай хөгжиж чадна гэж ингэж үзэж байна уу?

Энэн 500 гаруй жилийн хөгжлийн дунд үе уруу нь юм уу доод үе уруу нь орчих юм бол бид ихээхэн зам туулна аа. Манай бүх намууд өнөөдөр хүнлэг ардчилсан нийгмийг эх орондоо байгуулна гэсэн мөрийн хөтөлбөртэй байгаа. Энд санал өгсөн намуудаас

ганцхан Социал демократ нам энэнээс эсрэг саналтай байгаа. Би энэ Социал демократ намын саналын дагуу хүнлэг ардчилсан иргэний нийгмийг зорьж байна гэсэн ийм байдлаар, хүнлэг ардчилсан иргэний нийгэм гэдэг үгээр нь оруулах саналтай байна. Энэ бол чухал асуудал. Энд бол би хариу ч хүсч байгаа юм. Хүнлэг гэсэн үг бол, бид бол бас, манай ард түмэн бол хүсэн хүлээж байгаа ийм үг шүү дээ. Энд бусад намууд мөрийн хөтөлбөрөөсөө ухарсан байгааг бид анзаарахгүй байж болохгүй, ганцхан Социал демократ нам өнөөдөр энэ зам дээрээ байгаа. Энэ Социал демократ намын саналаар нэмэлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

П. ТӨМӨРБААТАР



Бичээч Л. Хорлоо

Уртнасан: -Эрхэм депутатууд аа, нэг зүйлийг анхааруулъя. Та бид одоо ерөнхий хэлэлцүүлгээ дууссан, санал асуулт, хариултаа явуулчихсан, яг хэлэлцэж байгаа зүйл дээрээ оюун сэтгэлээ төвлөрүүлж, товч тодорхой яримаар байна I-рт, 2-рт бидэнд бас нэг ийм боломж байгааг анхааруулъя. Өөрийнхөө томъёоллыг редакцийн чанартай засварыг шууд томъёолоод манай ажлын группт өгөх нь **хавьгүй илүү** ашигтай гэж ингэж бодож байна. Депутат Пүрэвдоржийн Энхийг эрхэмлэх гэсэн тэр уг 6 дугаар хуудас, 10 зүйлийн I дээр бичээстэй байгаа, тийм учраас бид энэ хуулиа нэлээн сайн үзэж харж, нягталж, байж саналаа илэрхийлж байх нь зүйтэй болов уу гэж **та бүхнээс хүсэх байна.**

246-р тойргийн депутат Дашдондог: -Тэгэхээр би горимын ганц, хоёр санал хэлээтхээ гэж бодож байна. Тэр хуулийн төслийг боловсруулахад манай бага хурал, комисс олон хоног итгэл зүтгэл гаргаж, энийг удиртгалын хэсэг дээр ярьж байгаа шүү. Санал хэлэхлээр би тэгж хэлэх гээд байна. Одоо энэ хууль боловсруулахад бид чинь депутатууд, хөдөлмөрдийнхөө санал хүсэлтийг авчраад энд чинь бага хуралд оруулсан байгаа, хэлэлцүүлэхэд, тэгэхэд одоо тэрийг ойшоож үзэлгүй бага хуралээр томъёолол гаргаж, ингэснээс л олон хоног сунжирч, одоо энэ хэлэлцүүлэг ийм боллоо гэж үзэж байна.

413-р тойргийн депутат Насан-Очир: -Тэгэхлээр бид өндөр цаваан дээрээс бууж байна, 2 дугаар хуудсаа ер нь ингээд санал хураалтанд оруулбал яасан юм, найруулгын чанартай зүйлүүд байна, тэрнийгээ бичээд өгчихье. За горимын нэг 2 зүйл хэлэх байна, хурлын дарга удирдлага зөвшөөрөх байх гэж бодож байна. Бид улсынхаа нэрийг хуулийнхаа нэртэй тохирлоо. Энд бол 100 % санал нийлсэнгүй, ийм учраас нэрээ хамгаалах, депутатууд нэгэн дугаар ярих, хэвлэл мэдээллийн хэрэгсэл яагаад ардыг хасав гэдгийг зөв мэдээллээсэй гэж хүсэж байна. Хуулийн нэр дээр тайлбарыг бас их зөв хийх хэрэгтэй.

Их гэдэг ч бол ойлгомжтой, засаг хууль гэдэг яагаад ийм болов гэдгийг маш зөв тайлбарлахгүй бол гаднах уур амьсгал янз янз байгаа учраас элдэв янзын бэрхшээлтэй тулахгүй байгаа гэж бодож байна. 2-рт горимын санал түрүүний хэд хэдэн намууд завсарлагааны дараа санал гаргасан, дараа дараагийн бүлэг энэ 2 дугаар хуудас шиг явахгүй байх, ийм учраас нам, эвсэл холбоодоос бүрдсэн ажлын хэсгүүдийг байгуулаад, енее орой ажилд оруулаад, завсарлагаа хийвэл яасан юм бэ гэсэн ийм санал оруулж байна.

Уртнасан: -Зарчмын нэмэлт санал байна уу гэдэг дээр бид яримаар байна. Санал хураалтанд бэлтгэж байна ихэнх депутатууд,

405-р тойргийн депутат Б.Дигдэн: -Тэгэхлээр хамгийн сүүлчийн өгүүлбэрийг ер нь энэ үндсэн хуулиа зарлан тунхаглах уу, эсвэл энэ бүх үесээ Үндсэн хуулиар зарлан тунхаглах уу гэдэг 2 тийм салаа утгын ойлголт гарч байгаа юм. Тэгэхлээр зүгээр хамгийн сүүлийнх дээр ийм л санал хэлэх гэж байгаа юм, тэр иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно оо гээд, үүний учир тэгээд тэгээд зарлан тунхаглах нь уу гэхлээр зэрэг энэ урдахаа дүгнээд, арцах дээрээ бүх зүйл холбогдох юм аа гэсэн ийм л ойлголт байгаа юм,

380-р тойргийн депутат Батчулуун: -Монголын ард түмний дэлхийн соёл иргэншилд оруулсан нэг түүхэн гавьяа өнөөдөр хүртэл үргэлжилж байгааг та бүхэн анхааран үзэх ёстой болов уу гэж бодож байна, тэгэхээр юу гэж хэлэх гэж байна вэ гэхлээр энэ монголын ард түмэн бид гэдгийн 3-т нүүдлийн соёл иргэншлээ өвлөн хадгалах гэсэн маягаар оруулах ийм саналтай байна. Нүүдлийн соёл иргэншлийг өвлөн үлдэж.

287-р тойргийн депутат Хурц: -Над бараг редакцийн шахуу юм, тэгэхдээ бас хороод ажиллах үед анхаараасай гэсэн нэг 2 санал байна. I-рт, хамгийн эхэнд Монголын ард түмэн бид гэдгийг Монголын гэдгийн дараа Монгол улсын ард түмэн **бид** гэж хэлье. Монголын ард түмэн биш, Монгол улсын ард түмэн **бид** гэгээд цаашаа явъя. Эх орондоо иргэний ардчилсан нийгмийг гэж хамгийн сүүлд байгаа, тэгэхлээр би бол иргэний гэдгийг хүнлэг ардчилсан нийгмийг гэж иргэний нийгэмлэг гэдэг бол хамжлагат ёс засаг өөрчлөгдөж, капитализм шилжихэд хөрөнгөтний нийгэмлэгийн хөрөнгөтнүүдээс гаргаж ирсэн нийтлэг нэр томъёонд гэж үздэг, тийм учраас иргэний тийм ийм гэлгүйгээр би зөвхөн миний санал бол эх орныхоо, эх орондоо, хүмүүнлэг, ардчилсан нийгмийг цогцлон байгуулж гэж цааш нь редакци хийж явуулах саналтай байна. Өөр санал алга.

I2-р тойргийн депутат Г.Очирбат: -Энэ оршил хэсгийн эх нь бол монголын ард түмэн бид тунхаглаж байна гэж байгаа юм, тэгэхлээр монголын ард түмэн бид түрүүн АИХ-аас одоо ингэж тунхагладаг нь мөн байна уу, биш байна уу, тийм учраас Монголын ард түмний нэрийн өмнөөс Бүгд найрамдах монгол улсын ардын их хурал гэж хэлмээр санагдаж байна, яагаад вэ гэвэл энэ чинь ард түмний хэлэлцүүлэг явуулаад, тэрнээс энэ улсын нэр, хуулийн нэр, гэх мэтийн зарчмын юмнуудаар хэлсэн гол саналы нь бид нар авч чадсангүй, тэгээд энд ард түмний нэрийг бариад шууд тунхаглаж арай болохгүй болов уу гэж, зүгээр Франц зэрэг зарим хөрөнгөтөн орны үндсэн хуулинд ард түмний санал асуулгаар үндсэн хуулиа зөвшөөрөхдээ ард түмэн бид гэж бичсэн юм байдаг байна. Ард түмний санал, **асуулга** авалгүйгээр ардын төрийн эрх барих дээд байгууллагаас баталж байгаа үндсэн хууль учраас би бол ард түмний нэрийн өмнөөс ардын их хурал гэж хэлэх нь зохимжтой юм уу гэж бодож байна. Дараа нь хамгийн эхний мөрөн дээр би ечигдөр нэг цухас зүйл хэлсэн, БНМАУ-ын тусгаар тогтнол хэзээ тунхаглагдсан юм бэ гэдэг асуудал жаахан тодорхой биш байгаа юм. Тийм учраас 1924 оны үндсэн хуулиар тунхагласан улс орныхоо тусгаар тогтнол гээд тэгээд цаашаа явчихвал яасан юм бэ, 1924 оны Үндсэн хуулиар тунхагласан улс орныхоо тусгаар тогтнол гээд ингээд хэлээд явбал яасан юм бэ? Тэр саяын иргэний

нийгэмлэг ардчилсан гэдэг бол ер нь давхар санаа л даа. Иргэний нийгэм ардчилсан нийгэм гэдэг бол давхар санаа, тийм учраас тэр сая н. Бадарч ч түрүүн ярина лээ. Тэр иргэний гэдэг уг дарчихаад хүнлэг ардчилсан нийгэм гээд явчихаж бүрэн болох юм биш үү дээ. Ийм л3 санал байна.

62 дугаар тойргийн депутат Гантөмөр: -Би энэ дээр энээхний хэсэгт байгаа даяар олноо зарлан тунхаглаж байна гээд нэгэнт ингэж үзэж байгаа учраас өнөөдөр бидний дотор Монголчуудын дотор үнэхээр орхигдоод байгаа нэг тийм нэг үзэл санааг тусгаж хийе үү гэсэн юм. Энэ юу гэх дээр зэрэг хамгийн эхний зүйл дээр нь улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, эх орноо дээдлэн хүндэлж гэдэг энэ үгийг нэммээр байна. Тэгээд дараагийнх нь зүйлээс нь эрхэмлэн дээдэлж гэж байгаагийнхаа дээдэлж гэдгийг авчих, тэгээд л авчих, ийм л санаа хэлэх гэсэн юм.


31-р тойргийн депутат Д.Д. Жоодорж: -Тэгэхлээр одоо энд бид их цаг алдсан учраас энэ дээр нэг ийм санал гаргах гэж байна. Энэ одоо сая бүлгүүд ингээд одоо намууд, эвсэл хоорондоо ингээд саналаа гаргаад зөвшилцлөө. Тэгэхлээр одоо энүүгээрээ цуглаад, энэ одоо бүлэг бүлэг дээрээ орох засвараа хийгээд, ингээд тэндээсээ гарах саналаа 2 юмуу хүнээр тавиулаж ингэж яах юм бол маш шуурхай болно. Тэгэхийн тулд маргааш, өнөөдөр энэ бүлгээ барах нь уу үгүй юу, маргааш II цагт цуглаад 9-11 цагийн хооронд энэ I, 2 дугаар бүлгийг ян тан болгох хэрэгтэй байна. Тэгээд II цагаас бол яг зөвшилцсөнөө ярилцвал арай түргэн биш үү гэж санал оруулах гэж байна. Тэгэхгүй бол ингээд ярих юм бол мөн их замбараагүй болох гээд байна, их цаг авах гээд байна.

151-р тойргийн депутат Алгаа: -Энэ иргэний гэдэг үгийн оронд, хүнлэг энэрэнгүй гэдэг үгийг нэмж оруулья гэсэн саналтай байна. Яагаад гэвэл өнөөдөр хүн хүнээ хүндлэх чадвар, бас зарим талаар алдагдаж, цаггүй замбараагүй байдал ихсэж байгаа учраас хүнлэг энэрэнгүй гэдэг санааг оруулья гэсэн бодолтой байна.

Горимын 2 санал байна. Ээдрээтэй зарчмын зөрүүтэй асуудлаар их удаан цагаар хурал удирдаж байгаа хүмүүс маргуулмааргүй байна. 2 өдөр маргасан юмыг I-хан цагийн дотор үдээс хойш зөвлөлдөөд, зохицож болж байхад, хэрэв маргаан үүсвэл депутатын хэсэг, намын хэсгийн ажлагч нарыг цуглуулаад өнөөдрийнхөө арга барилаар цаг унжралгүй, мөнгө үрэлгүй, шийдэх бодлогыг I-рт, энэ туршлага дээрээсээ явуулаасай гэж, хүсэмжлэх байна. 2-т нь ер нь хажуугийн саналыг микрофон бүр дээр 2-3 хүнээс илүү хэлүүлдэггүй, ийм журманд ормоор байна, энэ зарчмыг барихгүй бол түрүүчийн явж ирсэн байдлаас харахад бид цагаа их үрж, биеэ их чилээж, мөнгө үрж байгааг бодмоор байна.

360-р тойргийн депутат Найдан: -Тэгэхээр энэ дээр 2 дугаар абзац дээр ийм найруулга оруулбал зүйтэй юм уу гэсэн санаа байна, уул санаа жаахан бүдэг байгаа юм, тийм учраас тодотгох саналтай байна. Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдэл, зан заншилыг эрхэмлэн дээдэлж гэж, зан заншил гэдэг үгийг тодотгож орох нь зүйтэй гэж бодож байна, энийг соёл болон соёлынхоо өв уламжлал гэдэг дотор бүрхэж байх шиг байна. Мөн найц хамгийн их алдагдаж, хамгийн их бүрхэж байгаа зүйл бол зан заншлын асуудал юм. Тийм учраас энийг сэргээх асуудлыг улс орныхоо сэргэн мандалтын үед тод тусгаж өгөх нь зүйтэй юм. Хамгийн сүүлийн абзац дээр эх орондоо иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэх гэдгийг найруулах найрлагыг нь нийгмийг цогцлуулан хөгжүүлэх юм уу, цогцлоон хөгжүүлэх гэж найруулах нь зүйтэй, цогцлон хөгжүүлэх гэхлээр нийгэм өөрөө цогцлож хөгжөөд байх шиг ийм утга байх шиг санагдаж байна. Монгол улсын Их цаазыг цаяар олноо гэдэгийн оронд мэдээж саяхан тунхагласан Бүгд найрамдах монгол улсынхаа Их засаг хуулийг цаяар олноо гэж тэмдэглэх нь мэдээж, хэрэг, энэнээс хойш тэр давтагдахгүй байх аа, энийг хэлэх үгсийг давтахгүй байхыг хүсч байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

1991.XI.21.
Кассет № 1145
21.30-21.46.

280 дугаар тойргийн депутат Ш.Цэнлбаяр: -Энд би хоёр санал хэлье.Улсын тусгаар тогтнол гэдэг тэр абзацын дараагаар шинэ санаа гаргаж хэлье гэж бодож байна.Энэ нь бол манай ард түмэн, түүний хойч үеийнхний сайн сайхан амьдралыг ханган гэдэг ийм шинэ санаа оруулж байна.

Түрүүн Цүрэвдорж депутатын тавьсан тэр саналыг би дэмжиж байна.Гэхдээ хурлын дарга бол хойно байгаа гэж хэлсэн.Энэ бол надад учир дутагдалтай гэж үзэж байна.Лагаад гэвэл, удирдлага хэсэгт бол энэ хуулийн гол амин сүнс эхэлж орж байх ёстой.Ийм учраас төрт ёс гэдэг өгүүлбэр эхэлж байгаагийн өмнө "дэлхийн улс түмэнтэй эв найртай амьдарч энх тайвныг эрхэмлэн" гэдэг ийм шинэ санаа оруулж байна.

317 дугаар тойргийн депутат Д.Мандах: -Эхлээд хурлыг хурдлах үүднээс хоёр пропедурын санал хэлье.Нэгдүгээрт, би энэ саналыг нэлээн хэд хоногийн өмнө хэлэх гээд амжихгүй байсан.Му гэхээр, бидний депутатууд өөр өөрсдийнхөө суудлаас хурлыг удирддаг энэ байдлаасаа болимоор байна.Өөрөөр хэлбэл, ямар нэгэн өөрөөс нь эсрэг саналтай юмуу, хурлын дарга зогсоох тийм байдлыг бүгдээрээ эндээс хурал удирдах маягаар бүгд зэрэг эмх замбараагүйгээр ийм байдал олон ажиглагдсан.Энэ үүднээс бол нэгэнт сонгогдсон хурлынхаа даргад эрхээ эдлүүлээд хурлын дарга ч гэсэн өөрийнхөө зүгээс зогсоох ёстой юмаа зогсоож байхгүй бол бид нар бүгдээрээ хурлыг удирдаж болохгүй байхаа гэсэн ийм горимын санал байна.

Хоёрдугаарт, саяны 5 дугаар микрофон дээр хэлсэн депутатын саналыг би дэмжиж байна.Өөрөөр хэлбэл, одоо цаашдаа хэлэлцүүлгийн явцад тухайн асуудал болгоныг хэлэлцэж эхлэхээс өмнө хурлын дарга өөрөө шийдээд хүнийхээ тоог шууд тодорхойлж баймаар байна.Тэгэхгүй болохоор нэгдүгээрт маш олон хүн сунжирч хэлэх, асуудал ахин дахин давтагдаж байна.Хоёрдугаарт, явцын дунд энэ санал шүүмжлэлийг зогсоохоор нэгэнт микрофоны ард гарч ирсэн депутат хүнийг гомдоох

ийм асуудал гарч ирж байна. Тийм учраас тухайн хэлэлцэх асуудлынхаа шинж байдлаас шалтгаалаад тэр асуудлыг хэлэлцүүлж эхлэхээсээ өмнө хүнийхээ тоот шууд тогтоод явж байгаа бол хурлын үйл ажиллагаанд хурдан болно гэж бодож байна.

Гуравдугаарт, депутат та нөхөд ч гэсэн дэмжих байх гэж бодож байна. Му гэхээр, нэгэнтээ хэлсэн саналыг давтаж хэлэх юм бол тэр депутатын үгийг зогсоох эрхийг ер нь хурлынхаа даргад заавал дэгд оруулахгүйгээр өгөх нь зүйтэй байгаа гэсэн ийм саналтай байна.

Эцэст нь, тухайн оршил хэсгээр би бага Хурлаас оруулж ирсэн энэ төслийг бүрэн дэмжиж байгаа. Үүнтэй холбогдоод Учирбат гуайн хэлсэн саналтай, гурван саналаас хоёртой нь санал нийлэхгүй байгааг хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Нэгдүгээрт, монголын ард түмнийг Их Хурал бүрэн бүрэлдэхүүнээрээ энэ Үндсэн хуулиа баталсан тохиолдолд нэгэнтээ төлөөллийнхөө журмаар төлөөлөөд гарч ирсэн учраас монголын ард түмнийг төлөөлж зарлах эрхтэй болов уу гэж бодож байна. Зөвхөн Их Хурлыг гэж тавья гэсэн ийм санал гарсан. Хоёрдугаарт, 1924 онд тунхагласан тусгаар тогтнолыг бэхжүүлэх гэдэг утгыг оруулья гэж байна. Би бол энээс өмнө 1924 оноос еер еер үеүдэд монгол улс тусгаар тогтносон байсан учраас ганцхан 1924 оныг оруулах шаардлагагүй гэсэн саналтай байна.

228 дугаар тойргийн депутат Н.Адъяажав: —Манай улсын тусгаар тогтнол ганцхан бидний эв нэгдлээс ихээхэн шалтгаална байх гэж бодож байна. Ийм учраас би энэ оршил хэсгийн өмнө хоёрдугаар абзацыг ингэж найруулбал яасан юм бэ гэж бодож байна. "Үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэн" гэж оруулж өгвөл яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Д.Уртнасан: —Саяны үг хэлсэн депутатууд өөрийнхөө томъёоллыг манай ажлын группт бичгээр ирүүлээрэй.

190 дүгээр тойргийн депутат С.нүрэвжав: -Энэ дээр бусад хүмүүсүүдийн санал дээр орсон юмыг давхцуулж хэлэхээ больё.Иргэний ардчилсан нийгмийг гэдгийг "дарлал мөлжлөггүй хүмүүнлэг" гэж оруулах санал байна.

Манай энэ хуулин дээр чинь ард, иргэн гэдэг хоёр үгний ялгаа байхгүй болчихоод байх юм.Энэ дээр та бүхэн анхаарна биз ээ.Нэгэнт ард гэдгийг нь хасчихсан юман дээр монголын иргэн гэдэг юмуу тиймэрхүү юм оруулдаг болов уу.

22 дугаар тойргийн депутат Л.дашням: -Их эасаг хуулийн хороо ажиллаж эхэлсэн байгаа гэж би нэг сануулмаар санагдаж байна.Бас цагаа хэмнэхийн үүднээс найруулгын чанартай юмыг бид нар хэлмээргүй, шууд бичээд өгмөөр байна гэж бодож байна.Цаашилбал биенийхээ хэлсэн юмыг нэгэнт хэлэлцүүлэх учраас дахиж давтаж хэлмээргүй байна, цаг хэмнэмээр байна.

Надад хоёр санал байна.Эхний абзацыг би засаглалын бие даасан эхний хэсгийг засаглалын бие даасан байдлыг манай ахмад үе илүү зөв орчуулж байсан, илүү зөв ойлгуулж байсан гэж үзээд энийг бүхэлд нь эхний хэсгийг Монгол улсын ард түмэн бид гэдгийн дараагаар улсынхаа өөрөө оршин тогтнох дархан эрхээ бататган бэхжүүлж гэж, энэ бол зарчмын юм гэж би ингэж ойлгож байна.

Ард түмэн гэдэг даяар олон хоёр адилхан утгатай болчихдог учраас "даяар олноо" гэдэг хамгийн суулийн хэсгийн тэрийг "даян дэлхийд" гэж солих саналтай байна.

84 дүгээр тойргийн депутат Н.Самат: -Горимын санал хэлэх гэсэн юм.Сая уг нь дашням депутат хэлчихлээ л дээ. мийшээ нь энэ дээр төрт ёс гэдэг юмуу цогцлон хөгжүүлэх гэдэг дээр энэ дээр санал хэлээд цаг авмааргүй байна. Бид нар юуны төлөө депутатын хороо байгуулсан билээ, тэр ажиллаж байгаа, дараа нь редакцийн найрлагын чанартай саналыг тэд нар хүлээж аваад боловсруулаад хоёрдугаар хэлэлцүүлэгт

оруулж ирэхдээ аль саналыг хүлээж авсан, аль саналыг хүлээж аваагүй, яагаад гэдгийг дараа нь тайлбартайгаа, нэлээд цэгцтэй бид нар ажиллах байгаа гэж бодож байна. Тийм учраас яг зарчмын, санал хураах саналаа хэлээд томъёоллоо хэлбэл их сайн байна.

Ж. Уртнасан: -депутатуудын анхааралд нэг зүйлийг хэлье. Манай депутатуудын хороо, ажлын групп та бүгдийн саналыг бичгээр авч байна. Гэхдээ түрүүчийн ирсэн саналууд нэлээн тодорхойгүй байгаа учраас саналыг ирүүлэхдээ зарчмын санал нь энэ, найруулгын чанартай засвар хийх санал нь энэ гэсэн ийм хоёр хувилбараар еерийнхөө саналыг тодорхой бичиж ирүүлнэ үү гэж та бүхэнд дамжуулж байна.

296 дугаар тойргийн депутат Л. Батжаргал: -Миний өчигдрийн дэвшүүлсэн саналд яагаад хариу өгсөнгүй вэ? Тэрэнд хариу өгөөч ээ, би бичгээр өгсөн. Хуралд уг хэлэх бололцоо гарсангүй, босох гэхээр үймүүлдээд байсан. Нэг тийм асуулт байна.

М. Уртнасан: -Ажлын группэд шийдэгдэнэ. Тэндээс хариу өгнө.

Л. Батжаргал: -Нэгэнт хэлэлцэгдээд өнгөрлөө. Гэхдээ би тэрэнд хариу авмаар байсан юм. Хоёрдугаарт, горимын чанартай юм, дээр дожоодорж гуай хэллээ, ер нь бүлгүүдээрээ энэ зүйл ангиудыг хэлэлцээд төлөөлөгчөөрөө цөөхөн тоотой хүнээр хэлүүлж байвал зүгээр байна гэж, энэ шуурхайлах болох юм.

Хоёрдугаарт, үндсэн энэ төсөл дээр оруулахад "монголын ард түмэн бид" гэдгийн оронд энэ шинэ нэр томъёогоороо БНМАУ-ын иргэн бид гэж оруулбал яасан юм бэ?

Депутат тойрог нэрээ хэлээгүй:

-Би тайлбар хэлэхгүйгээр саналаа шууд хэлье. Энэ хоёрдугаар зүйл дээр "хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэс-

ний эв нэгдэл" гээд энэний дараа "шударга ариун хөдөлмөрийг эрхэмлэн дээдлэн" гэж ийм оруулмаар байна. Шударга ариун хөдөлмөр гэдэг чухал ач холбогдолтой гэж бодож байна.

дараачийн хэсэгт , төр ёс, түүх гэдэг үгийн дараагаар бол вүүдлийн өвөрмөц соёл иргэншлээ эрхэмлэн дээдлэх гэсэн ийм санаа оруулмаар байна.

Эцсийн хэсэг бол хоёр, гурван хүний санаан дээр давхардаж байна. Гэхдээ яах вэ, хэлчихье. Хүнлэг ардчилсан нийгэм гэж. "Иргэний" гэдэг үгийг хасаад "хүнлэг, ардчилсан нийгэм" гэж хийвэл яасан юм бэ? Хүнлэг гэдэг үгийн утга учир бол их өргөн дэлгэр ач холбогдолтой юм гэж бодож байна.

415 дугаар тойргийн депутат Н. Ганбямба: -Энэ дээр эхний хэсэг дээр "иргэний ардчилсан нийгмийг" гэсэн томъёоллоос "иргэний" гэсэн үгийг хасъя гэсэн санал нэлээн гарах юм. Би хувьдаа энэ саналын эсрэг саналтай байгаа юм. Учир нь гэвэл хуулийн маань агуулга энэ үгийг авснаас нэлээн өөрчлөгдөх болов уу. Энэ ард талынхаа агуулга, хуулийн ерөнхий гол зарчим, би санал зөрөөтэй зүйл, бүлгүүд бий л дээ. Гэлээ гэхдээ агуулгатай холбогдуулсан энэ тодотголыг хасахгүй гэсэн ийм ганцхан санал хэлье гэж бодож байна.

107 дугаар тойргийн депутат Л. Баяндалай: -Зарчмын санал байна. Энд байгаа бүхэн хойно аяндаа Их засаг хуульдаа тунхаглагдаж байна. Тухайлбал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал гээд байхад эргүүлээд I дүгээр зүйл дээр аяндаа тунхаглал болоод орсон байна. Гэх мэтчилэнгийн, оруулбал оруулмаар юм зөндөө гарч ирээд байна. Тэгээд хооронд нь байрыг солимоор, ингээд энэ ажил сунжраад байна. Тэгэхээр ерөөсөө энийг удиртгал хэсэггүй хийчихвэл яасан юм бэ? Ийм хэсгийн хэрэг заавал байгаа юмуу? Энийг ерөөсөө орхичихвол яасан юм бэ гэсэн санал оруулж байна. Орхих уу, байлгахгүй гэдэг дээр санал хураалгаад энийг тэгээд шийдээд цаашаа явбал яасан юм бэ?

35 дугаар тойргийн депутат В.Бямбаа: -Монголын ард түмэн бид гэдгээс "бид" гэдэг үгийг хасч Монголын ард түмний өмнөөс гэж оруулах санал байна.

Хоёрдугаарт, иргэний ардчилсан нийгмийг гэж хэлсэн байгаа.Тэгэхээр иргэний ардчилсан нийгэм гэдэг дээр Улсын Бага Хурлаас товч тайлбар хэлж өгнө үү гэж бусад депутатуудын хамт хүсч байна.Ийм л хоёр санал байна.

36 дугаар тойргийн депутат Д.Сүрэнхорлоо: -Бид хойд, урьд хөршөөсөө, энэ нэрнээс авахуулаад айсан, эмээсэн, болгоомжилсон маш их юм ярилаа.Үүнтэй холбогдож тэр 6 дугаар хуудсанд байгаагийн чинь урагш нь Цүрэвдорж депутатын саналаар "энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулж" гэсэн шинэ улаан мөр хоёрдугаарт нь хийж өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хоёрт нь энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулж гэж хийе.

32 дугаар тойргийн депутат Д.Мандах:

Горимын санал.Бид ингээд уг хөөцөлдөөд байвал, дэгээ барихгүй байвал ахиад ярих болчихно.Ийм учраас нэгэнт дэгэн дээр бий.Найруулгынхаа саналыг бичгээр өгөөд зарчмынхаа саналуудыг дээр ярилцъя гэсэн.Энэ дотор би ингэж бодож байна.Нэгэнт бид групп томилсон, группүүддээ хэлэх, ярих хэл найруулгынхаа чанартай зүйлийг өгөөд тэгээд тэр групп бичээд авах ёстой.Тэгээд эцэст нь редакцийн санал, үндсэн төслийн санал хоёр дээр бид найруулаад ийм санал өглөө, бичиж ирсэн саналыг найруулсан хувь нь энэ, эх төслийн хувь энэ хоёр гэдэг санал хураалт явуулаад ингээд тохироод цаашаа явсан нь зөв байхаа гэж бодож байна.Редакцийг энэ санал боловсруулж байх хооронд тэр групп боловсруулж байх хооронд харин бид нар цаашдаа зарчмын санал тохирох хэд хэдэн асуудал байгаа.Марламентын бүтэц, төрийн бэлгэдэл гэсэн ийм тулсан тулсан хэдэн асуудлууд дээрээ ярилцаж

байсан нь зөв байгаа. Түүнээс бий асуудлуудаа бичгээр өгье гэсэн ийм л горимын санал хэлье.

М. Уртнасан: -Баярлалаа. Удиртгал хэсэг дээр санал хурааж дууслаа. Саналаа тасалъя гэсэн санал хураалт явуулж байна. Санал хураалтад бэлтгээрэй.

Хуудас эргүүлье. Хуулийн төслийн 1 дүгээр бүлэг. Монгол улсын бүрэн эрхт байдал. 1 дүгээр зүйл. 2 дугаар микрофон.

13 дугаар тойргийн депутат С. Чулуунбаатар:

-депутатуудын хорооны гишүүд зөвшөөрөх байх гэж бодож энэ горимын санал хэлж байгаа юм. Тэгэхээр сая бол Их Хурлын дарга ингэх ёстой байх аа. Энэ эхний хэсэг дээр гарсан редакцийн саналыг бид хариуцна. Харин зарчмын зөрөөтэй саналаар та санал хураалгаж авахгүй бол депутатын хороо ажиллаж чадахгүй. Тэгэхээр миний ажигласнаар хэрвээ би андуураагүй бол, саяын бүх ярианы явцад зарчмын гэж санал хураалгах шаардлагатай болов уу гэмээр ганцхан санал байна. Тэр нь юу гэхээр, нэг депутат энэ эхний хэсгийг бүхэлд нь хасна гэсэн санал оруулж байна. Бусад нь редакцийн санал байна. Тийм болох учраас тэр хүн дараа нь депутатын хорооноос асуудал оруулаад ирэхэд "миний хасах гэсэн саналыг чи яагаад оруулаад ирэв" гээд байж болзошгүй. Тэгэхээр энүүгээр санал хурааж өгөөч ээ. Дараа, дараагийн хэсэг дээр ийм замаар явахгүй юу.

М. Уртнасан: -Эрхэм депутатууд аа, бид бас ялиггүй жижигхэн техникийн чанартай зүүлийг та бүхэнтэйгээ зөвлөх хэрэгтэй байна. Тэгэхээр сая Чулуунбаатар депутат хэллээ. Саяын энэ удиртгал хэсэг дээр манай ажлын группийнхэн нэг 6 саналыг хүлээн авч, засвар хийж байгаа юм байна. Тэгэхээр бид ингээд дор дор нь ингээд зарчмын юмнуудыг танилцуулна гэхэд хэцүү юм. Нэг зүйл хэлэлцээд дараа нь

8.

урьд талынхаа зүйлийн засвар хийснийг нэг эргэж хянаад
ингээд явбал болох болов уу гэж бодож байна. Энийг манай
техникийн группийнхэн, үнэхээр томъёоллыг нийлүүлж амжих-
гүй байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч Ө.Оюунчимэг

Ж.Уртнасан -Уучлаарай.Энэ засвар биш,найруулгын чанартай редакцийн юмыг,саналыг нэгтгэж.Хийгээд оруулаад явчих гэж үү. За 2 дугаар микрофон.

132 дугаар тойргийн депутат С.Чулуунбаатар:

-Тэгэхлээр депутатын хороонд ажиллах 21 депутат бол депутатынхаа эрхийг эдэлж энэ хэлэлцүүлгэнд орох хэрэгтэй.Харин депутатын хороонд хэд хэдэн ажлын хэсэг бий.Тэд үүргээ мэдэж байна.Тийм учраас тэр улсууд энэ хооронд юмаа хийгээд л бай.Харин та зөвхөн миний дээр хэлсэн зарчмын зөрөөтэй асуудлаар санал хурааж шийдэж өгөөд л бай.Бусад асуудлыг эргүүлж,жишээлбэл Мандах депутатын саналыг би зөвшөөрөхгүй.Нэг асуудал ингээд л ярьдаг,хэдэн минутын дараагаар нөгөө ажлын хэсэг чинь ийм найруулгаар оруулж ирлээ - гээд л ороод ирдэг,дахиад л маргалдаад унадаг,энэ бол дуусахгүй ээ.Тийм болох учраас хэргээ депутатын хороондоо үнэхээр итгэл өгсөн юм бол депутатын хороо эцэслэн редакци хийгээд л хоёрдугаар хэлэлцүүлгэнд авчирна.Харин зарчмын асуудлаар та бол санал хурааж шийдэж өгч байгаа ээ.

Ж.Уртнасан -3 дугаар микрофон.

52 дугаар тойргийн депутат:

Ч. Пүрэвдорж -Уучлаарай би түрүүн товчхон хэлсэн.Одоо ингээ.Би яагаад тэр энхийг эрхэмлэгч гэдэг үгийг хэлж байгаа юм бэ гэхлээр даяар олноо зарлан тунхаглаж байгаа учраас тийм учраас нөгөө олонтойгоо яаж харьцах вэ гэдэг юмаа л оруулмаар санагдаад байгаа юм.Муу байж болно оо.

Ж.Уртнасан -Пүрэвдорж оо санал тасалсан.Өөрийнхөө найруулгын томъёоллыг бичээд өгчихгүй юу.Манай ажлын группт өгөөрэй.4 дүгээр микрофон:

341 дүгээр тойргийн депутат Мөнгөн -За би нэгдүгээр бүлэгт дараахь найруулгын чанартай санал байна.

Ж.Уртнасан -Оршилоо тасалчихсан шүү дээ.За 2 дугаар микрофон.

Б.Чимид -Хурлын даргын үүрэг бол одоо ийм байна.Олон хүн томъёолол хэллээ.Тэр депутатаас энэ төсөлд байгаа өгүүл-бэртээ өөрийн чинь хэлсэн санал зарчмын зөрөөтэй гэж үзэж байна уу үгүй юу гэдгийг асуугаад үзэж байна аа гэвэл саналаа хураалгая.Үзэхгүй байна аа гэвэл депутатын хороо тэргүүгээрээ үзэх ийм л хоёр асуудал байна.Ер нь цаашдаа ингэж явахаас арга байхгүй ээ.

Би одоо ухаандаа нэг хүн шашин гэлээ,нэг хүн ардчилсан гэдгийг хасъя гэлээ.Энэ санал чинь зарчмын зөрөөтэй гэж үзэж байгаа юмуу,эсвэл харж үзээч ээ гэж байгаа юмуу,найруулга дээр харж үзээч гэж байгаа юмуу гэдэг энэ хоёрыг асуугаад зарчмын зөрөөтэй гэвэл бидний гарыг өргүүл.Ийм л юм шүү дээ. Дэгэндээ бид баталчихсан шүү дээ.Дэгээ баталчихаад байна уу хайлаа байна.

Ж.Уртнасан -Санал тасалсан шүү дээ.Горимын санал хэлэх гэж байна уу та.Депутатуудын хорооны санал.5 дугаар микрофон.

326 дугаар тойргийн депутат Ж.Гомбожав:

-Ингээд зарчмын хэд хэдэн саналыг шийдэж өгөхгүй бол болохгүй нь ээ.Найруулгын юмыг манай хороо хийнэ.Тухайлбал,иргэний гэдэг үгийг хүмүүнлэг болгоё гэсэн санал хэд хэд гарлаа.Тэгэхлээр энэ бол зарчмын байх аа гэж бодож байна.Иргэний гэдгээрээ байх уу,хүмүүнлэг гэдгээрээ байх уу. Ард түмний нэрийн өмнөөс гэх юмуу аль эсвэл Их хурлын нэрийн өмнөөс гэх юм уу,үүнийг тохирч өгөх хэрэгтэй. Гэх мэтчилэн-гээр хэд хэдэн зарчмын юм байна аа.Үүнийг тохирчихоод тэгээд цаашаа явбал болж байна.

Ж.Уртнасан -За ойлголоо.Юуны өмнө депутат Буяндалайгийн саналыг бид зарчмын гэж үзэх үү.Энэ удиртгал хэсгийг тэр чигээр нь хасъя гэсэн санал оруулаад байгаа юм.Санал хураалт явуулъя.Санал хураалтанд бэлтгэе.Шууд шийдээд явчихъя гэж үү. За 6 дугаар микрофон.Горимын санал.

428 дугаар тойргийн депутат Ганболд -Тэгэхлээр энэ асуудлыг нэгмөсөн шийдээд явчихаж болно оо.Редакцийн саналыг

оруулаад зарчмын хувьд нийт депутатууд энэ дээр зөвшөөрсөн санал өгч байна уу гэсэн ганцхан санал асуулт хураахлаар бусад зарчмын бус гэдэг чинь энүүгээр шийдэгдчихнэ шүү дээ. Зарчмын хувьд үндсэнд нь зөвшөөрч л байгаа бол дийлэнх олонхийн санал гараад ирнэ. Дийлэнх олонхийн санал гарахгүй л байгаа бол тэгээд л хүн болгон дээр зарчмын хувьд тэр гэсэн саналаа хэлэлцээд явчихаж болно шүү дээ. Ганцхан санал хураалтаар эхлээд үзэжчихэж болох байхгүй юу. Тэгээд редакцийн хувьд засварлах эрх болбол тэр хороонд байж байгаа. Бид зарчмын хувьд өөрчлөх, редакц хийх эрхийг өгсөн. Дэгээрээ. Ингээд тэр удиртгал хэсгийг редакцийн засвар оруулаад зарчмын хувьд дэмжиж байна гэсэн санал дээр томъёоллоо хэлээд л хураалгачих. Тэгээд тэрнээсээ доош процентоор бид нарын зөвшөөрсөн юугаар авч чадахгүй бол дахиж хэлэлцүүлэх асуудал гарна. Дээш гараад явчихвал шийдэгдлээ гэж үндсэнд нь шийдэх ёстой. Тэгээд цаашдаа зүйл зүйлээр явж болно.

Ж. Уртнасан - За баярлалаа. Эрхэм депутатуудыг санал хураалтанд бэлтгэхийг хүсч байна. Хуулийн төслийн удиртгал хэсгийг зарчмын хувьд зөвшөөрч байна гэсэн санал хураалт явуулъя. Томъёолол, анхаараарай. Томъёоллоо сонссон уу. Дахин хэлье. Хуулийн төслийн удиртгал хэсгийг зарим найруулгын чанартай засвар хийгээд зарчмын хувьд зөвшөөрье. За санал хураалт явуулж байна.

За баярлалаа. Хуулийн төслийн удиртгал хэсэг. Хуулийн нэгдүгээр бүлэг. Монгол улсын бүрэн эрхт байдал нэгдүгээр зүйл. Зарчмын санал байна уу. Дэгээрээ. I дүгээр микрофон. Нэгдүгээр зүйл дээр одоо энэ зогсож байгаа хүмүүсүүдийн саналыг сонсоод саналыг тасалчихаж болмоор байна.

138 дугаар тойргийн депутат Болдбаатар - Нэгдүгээр бүлгийн нэгдүгээр зүйл дээр жижигхэн санал байна. Энд I-ийн 2-т ингэж заасан байна. Хууль дээдлэх ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний нэгдэл гэж. Энэ дээр төрийн

үйл ажиллагааны үндсэн нэг зарчим нь бол ард түмний амар түвшин, энэ бол аюулгүй байдал, хүний эрхийн талаас, сайн сайхан гэдэг нь эдийн засгийн талаас амьдралыг хангах ийм зарчим байх ёстой гэж бодож байна. Энэ жижиг зарчмыг ямар нэгэн найрлагатайгаар нэмээд оруулчихвал болно оо. Мөн үүн дээр ардчилсан ёс, шударга ёс гэдэг хоёр ёсын нэгийг хасах саналтай байна.

Ж. Уртнасан -2 дугаар микрофон.

14 дүгээр тойргийн депутат Лхагвасүрэн -Энэ чинь тэгш байдал гээд орчихсон байна. Энэ бол зарчмын асуудал учраас үүнийг хасах нь зүйтэй гэсэн санал байна. Яагаад гэвэл төрийн эзгээс хүн бүрийг, байгалийн өмнө тэгш байлгаж чадахгүй, хүн бүрийг эд хөрөнгө бүх юмаар нь тэгш байлгаж чадахгүй учраас энэ тэгш байдал гэдгийг нь хасъя гэсэн санал хэлмээр байна. Төрийн бодлогын гэдэг үгийг төрийн дараа нэмж өгөх нь зүйтэй байна.

Ж. Уртнасан -3 дугаар микрофон.

89 дүгээр тойргийн депутат Пүрэвгял -Энхийг эрхэмлэсэн гэсэн санааг урагш нь оруулъя гэж ярьж байсан. Энд бүгд найрамдах гэдгийн оронд энхийг эрхэмлэсэн улс мөн гэж. Тэртэй тэргүй бүгд найрамдах гэдэг үг Монгол улсын урд талд орж байгаа учраас. I-ийн хоёр дээр эв нэгдлийг хангаж гээд, хүн ардынхаа аж амьдралыг хэлбэрэлтгүй дээшлүүлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн энэ хоёрыг оруулахад болох юмаа.


Ж. Уртнасан -4 дүгээр микрофон.

351 дүгээр тойргийн депутат Мөнгөн -Энд зарчмын чанартай ч гэдэг юмуу, бүгд найрамдах Монгол улсын бүрэн эрхт байдал гэж ингэж орох байх аа. За тэрнээс гадна БНМУ-ын засаг хууль бол монгол улсын үндсэн хууль мөн гэсэн ийм зарчмын санал орох болов уу гэж бодож байна. Мөн I дүгээр зүйл дээр бүгд

найрамдах улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт улс мөн гэж бүгд найрамдах гэдэг нь урд талд нь оруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. БНМУ бол тусгаар тогтносон бүрэн эрхтэй улс мөн гэж найруулж орох байх аа гэж бодож байна.

I дүгээр зүйлийн 2 дугаар хэсэг дээр хууль дээдлэх ардчилсан гээд таслал тавиад ёс гэдгийг хасаад, мөн шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэстэн гээд таслал тавиад ястны эв нэгдэл, зан заншлыг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж оруулах нь зүйтэй гэж бодож байна. Би яагаад тэгэж байна вэ гэвэл монголчууд бол олон жижиг ястнаас бүрдсэн, би ч гэсэн жижиг ястны төлөөлөгч, ийм учраас энд ястны гэдэг үгийг зайлшгүй оруулах шаардлагатай гэж би бодож байна. Томъёолоо бичиж өгч болно.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛДСЭН



/Д. БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

264 дүгээр тойргийн депутат Б.Банди: Нэгдүгээр зүйлийн тухайд миний саналыг түрүүн хүн хэлчихлээ. Гэхдээ бас тодотгочихъё гэж бодож байна. Нэгийн 2 дугаар зүйл дээр байгаа тэгш байдал гэдгийг хасах нь зарчмын ач холбогдолтой гэж үзэж байна. Нэгдүгээрт нь энэ тэгш байдлыг бий болгох тухай асуудал хэрэгжихгүй юм. Улам ч одоо тэгш биш байдал цаашдаа гарах байх. Нэг.

Нөгөө талаар хууль дээдлэх гэдэг агуулган дотроо хууль дээдлэх ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө гэсэн урд талын 4 санаан дотор энэ тэгш байдал гэдэг болбол үндсэндээ багтаад орчихож байгаа юм. Тийм учраас тэгш байдал гэдгийг хасуулах санал оруулж байна. Нэг.

Хоёрдугаарт нь горимын шинж чанартай нэг асуудал байна. Хурлыг шуурхайлах үүднээс. Бид нэрэн дээр бол их олон хоног маргаж цаг хугацаа алдлаа. Цаана нь маргаж болох нэлээд хэдэн асуудал бий. Тухайлбал сүлдний асуудал байж байна. Сүлд болбол гарцаагүй өөрчлөгдөхөөр болчихлоо. Тийм учраас ажлын групп томилж энэ сүлдэн дээр эртнээс депутатын групп томилж ажиллуулах шаардлагатай гэж ингэж үзэж байна, бид нар гэнэтхэн сүлдэн дээр очихдоор зэрэг тэр бэлэн төсөл чинь хаана байна вэ гэж маргаад, хүлээгээд бэлэн төсөл дээр ярилцмаар байна. Тэгэхгүй бол цаг алдах гээд байна. Бид нар бол цагаан шувууг тэртэй тэргүй хүлээж авахгүй нь тодорхой болоод ерөнхий хэлэлцүүлгийн үед тодорхой болсон. Нэг.

Нөгөө талаар энэ бол америкийн цэргийн сүлд юм байна. Ийм учраас одоо яаралтай депутатын групп томилж, урлагийн ажилтнууд, мэргэжлийн хүмүүсүүдийг оролцуулаад сүлдийг бэлдмээр байна. Ямар ч байсан морь оролцсон, тэгээд юу байх юм бүү мэд тэр сүлдийг эртнээс бэлдээд яг хэлэлцэх үед бэлэн оруулж ирээчээ. Тэгэхгүй бол цаг алдах гээд байна шүү. Тэртэй, тэргүй тэр нэр нь өөрчлөгдчихөж байна, БНМАУ гээд наад зах нь ингээд өөрчлөх нь гэж горимын шинж чанартай энэ асуудлыг санал хураалгаж ажлын групп томилж оруулж өгнө үү гэж хурлын удирдлагад

хүсч байна.

280 дугаар тойргийн депутат Ш.Цэндбаяр: Энэ нэгдүгээр зүйлийн 2 дугаар хэсэг, хоёрын эхэнд шинэ санаа оруулъя. За энэ нь улсынхаа тусгаар тогтнолыг хамгаалах гэдэг уг орхигдсон байна. Үүний дараа хүн ардаа боловсруулан хөгжүүлэх явдлыг хангах, гэдэг ийм хоёр санааг нэмье. За хууль дээдлэх гэдгийг өөр үгээр солимоор байна. Энэ бол их сул сонсогдож байна. Энэний оронд бол хуулийн өмнө иргэн бүрийн тэгш байдлыг хангах гэдэг ийм санаа оруулах нь зүйтэй. Ингээд тэр тэгш байдал гэдэг дараагийн үгийг хасах хэрэгтэй гэсэн ийм саналтай байна.

320 дугаар тойргийн депутат Ч.Хишигдалай: Энэ нэгдүгээр зүйлийн 2 дээр түрүүний улсууд, хүмүүсийн хэлсэнтэй холбогдуулаад хэлэхэд тэр шударга ёс гэдгийг нь үлдээгээд, тэгш байдал гэдгийг нь хассан байхад эүгээр болов уу гэж бодож байна. Нөгөөтэйгүүр тэр үндэсний эв нэгдлийг гэдгийг нь хэвээр нь үлдээсэн нь дээр болов уу. Энэ одоо үндэстэн, ястан аль алийг нь багтаасан асуудал болж таарах болов уу гэж бодож байна. Дараа нь нэг нэмэлт хийх санал байна. Энэ үндэсний эв нэгдлийг хангах гэсний дараа энхийг эрхэмлэх, бусад улсын дотоод хэрэгт үл оролцох нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж оруулах саналтай байна.

34 дүгээр тойргийн депутат Р.Рааш: Би нэгдүгээр зүйл гэдэг дээр түрүү хүн хэлчихшиг боллоо. БН гэдгийг дээш нь аваачсан нь дээр болов уу гэж бодож байна. Хоёр дээр тэр ардчилсан ёс, шударга ёс гээд нэг олон ёснууд, хоёр ёс ч байна энийг шударга ёс, ардчилал гээд ар тийш нь оруулчихвал арай дээр юм шиг санагдах юм. Түүнээс гадна ерөөсөө энэ хоёрдугаар хэсэг дээр гуравдугаар зүйлийг шууд нэгдүгээр зүйл рүү авчихвал дээр юм биш үү гэж. Энэ ижил утгатай зүйлүүд яваад байна уу гэж бодох юм. Тэгээд зүйл болбол нэгээр хасагдаад шууд гурвыг нэгрүү авчирaad цувуулаад биччихвэл болмоор юмуу гэж бодож байна.

3.

149 дүгээр тойргийн депутат Т.Анигар: Түрүүний нэгдүгээр зүйлийн нэгийг давтагдсан учраас би ярихаа больё. Энэ хоёрдугаар дээр субъект нь мэдэгдэхгүй хууль дээдлэх эрх чөлөө гээд байна. Энэ дээр бол би ингэж найруулмаар санагдах юм. Хууль дээдлэх ардчилсан шударга ёсыг эрхэмлэн хүний эрх гэдэг юмыг энэ дээр субъект нь жу болхонов, эрх чөлөө, тэгш байдал гээд ийм юмнууд байх юм. Ийм л найруулга хиймээр байна. Өөр санал алга.

Уртнасан: За саналыг таслая. Санал хураалт явуулъя. Саналыг таслая.

Санал хураалтанд 364 депутат оролцлоо. 353 нь буюу 97 хувь нь саналыг таслаж байна. 9 хүн татгалзаж, 2 хүн түдгэлзлээ. Татгалзсан 2 хувь, түдгэлзсэн 1 хувь байна.

Бага Хурлын даргаа саяын нэгдүгээр зүйл дээр хуулийг дээдлэх гэсэн энэ үгийг хэрхэх тухай, тэгш эрх гэсэн тэгш байдал гэдгийг 3 депутат хасах нь зүйтэй гэсэн санал оруулж байна. Энэ томъёолол бол хэрхэн яаж орсон, ямар үндэслэлтэйг товч тайлбарлаж өгнө үү.

За танхимын уур амьсталыг мэдэрлээ. Баярлалаа. Тайлбар хэрэггүй юм байна. Ийм учраас 2 дугаар зүйл. За уучлаарай.

Нэгдүгээр зүйлийн 2 дугаар заалт дээр байгаа тэгш байдал гэдэг үгийг хасая гэсэн зарчмын чанартай санал 3 гарлаа. Энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Тайлбар сонсох уу? Энэ хуулийн төслийг оруулж ирсэн Бага Хурлын нөхдийн саналыг сонсох уу?

Чимид:

Хоёр. Би тайлбар хийх хүсэлгүй л байна л даа. Өглөө дэгэд их тодорхой өөрчлөлт орсон. Тэрийгээ эзэмшихгүй бол болохгүй болов уу даа.

Олонхийн саналаар шууд явъя гэдгээр үү.

Энэ ингээд гүйгээд явчихвал хоёрдугаар хэлэлцүүлэг чинь гацчихна. Энэ олон улс юм хэлчихлээ. Энэ хэлж байгаа юман дот-

роо жишээлбэл Чимид гэдэг хүн тэр үгийг хасъя, тийм үгийг нэмье гэж хэлэхдээ энэ асуудлаа төслөөс өөр зарчмын асуудлаа гэж үзэж байна уу, үгүй юу гэдгийг хурлын дарга хураалгаад олонхийн саналаар зарчмын асуудал мөн гэж тэр хүний саналыг зөвшөөрч байгаа бол тэрэн дээр тайлбар өгмөөр байна. Тийм юм дэгэнд хийсэн шүү дээ. 50 хувийн. Тэгэхлээр тэр хүн үгээ, найруулга дээрээ хороо харчихна бие дээ гэвэл орхиж яваад хороо нь эргэж илтгэх ёстой. Тэнд тойргийн дугаар, овог нэр, тавьсан санал, авсан, аваагүй, аваагүй бол аваагүйн үндэслэл гэсэн хүснэгт бөглөж байгаа юм. Тэгэхлээр энд баахан үг хэлчихдэг, тэгээд ажлын группэд суугаад хийхлээр зэрэг минийхийг хаячихжээ. Ийм санал ороогүй байхад та нар нэмчихжээ, ингэж аппарат шургуулдагаа гээд ингээд унадаг. Энэ бол та нар зарим нь хэлж байсан үг байх. Ийм учраас бид одоо хурлын даргын үүрэг үндсэндээ ганцхан байгаад байна шүү дээ. Хүний хэлж байгаа юмыг за энийг Чулуунбаатар гэдэг депутатын хэлсэн үг та энийгээ зарчмын санал гэж, зарчмын зөрүүтэй санал гэж хураалгах уу, үгүй үү гэж асуугаад тэгье гэвэл депутатуудынхаа саналыг хураагаад тэгээд хэлэлцүүлэгт оруулах ёстой байхгүй юу. Энэ чинь хэлэлцүүлэг биш, зүгээр санал сонсолт болчихоод байна шүү дээ. Тэгэхээр нэгдүгээр хэлэлцүүлгийн дараа дахиад хоёр, дахиад гурав гарч ирчихгээд байна. Өөрөөр хэлбэл бид явах замаа сайн хармаар байна.

За баярлалаа. 6 дугаар микрофон.

428 дугаар тойргийн депутат Д. Ганболд: Чимид гуай бид таныг эсэргүүцэх гээд байгаа юм биш. Энэ асуудал бол хэрэв зарчмын хувьд зөрүүтэй санал гэж үзэж байгаа бол тэртэй тэргүй ердийн олонхоор шийднэ, хэрэв нэг л асуудал дэвшүүлээд бусад депутатууд бүгдээрээ зарчмын хувьд энэ бол зарчмын санал байна гэж үзэх юм бол одоо тэнд гарах тоо бол 50-иас доош гарах ёстой шүү дээ. Тэгэхлээр бишээ 50-иас. Бид нар чинь дэгдээ бол зарчмын хувьд зөрүүтэй санал гэж үзэх юм бол ердийн олонхоор, тэр нь цаашдаа хоёрдахь процедура бол дийлэнх олонхоор шийднэ гэж нэмэлт оруулсан шүү дээ. Тийм учраас энд саяны хүмүүсийн тавьсан саналуудыг зарчмын хувьд зөрүүтэй санал гэж үзэх юмуу, үгүй

5.

юмуу гэдгийг нэгмөсөн хурааж болно. Тэгэхлээр депутатууд одоо саналаа өгнө. Зарчмын хувьд зөрүүтэй санал нэг л гарсан байхад тэр хүн хангалттай. Кнопкоо тэрэн дээр дарах ёстой. Тэгээд зарчмын хувьд зөрүүтэй санал хэд байна гэдгийг өнөөдөр тэр хүмүүс өөрснөө саналаа тавих ёстой байхгүй юу. Би зарчмын хувьд энэ зөрүүтэй санал гэж байна гэж үзэх юм бол тэр хүмүүс босоод саналаа хэлэлцүүлж болно. Тэрнээс өмнө бол шууд энийг зарчмын хувьд зөрүүтэй санал гараагүй гэдгийг депутатууд ердийн олонхоороо өнөөдөр шийдчих, ганцхан асуултаар шийдчих бололцоотой байгаа байхгүй юу. Энийг бол анхаарахгүй байна л даа. Шууд эхлээд санал хураагаад үзье. Ердийн олонхоор зарчмын хувьд зөрүүтэй санал гараагүй гэж үзвэл тэгээд тэр бусад гарсан саналууд чинь бүгд редакцийн гээд автоматаар шийдэгдэж болно шүү дээ. Энийг чинь логикийн хувьд депутатууд бүгд ойлгож байгаа.

Уртнасан:

Ойлгож байна. Ердийн олонхийн саналаар шийдье гэсэн зарчмын гол санаа байх шиг байна.

153 дугаар тойргийн депутат Д. Чойжамц: Тэгэхлээр түрүүн депутат Зориг, Дожоодорж, Барсболд, ^{Батжаргал} нар санал хэлсэн. Ийм юм ярьсан шүү дээ. Бүлэг бүрээр нь аваад боловсруулаад тэгээд тэрийгээ хэлэлцүүлбэ гэсэн ийм санал гарсан байгаа. Энэ бол шуурхай төдийгүй, чанартай боловсруулах ач холбогдолтой гэж бодож байна. Ийм учраас зарим хүмүүсийн гаргасан санал ч байна, тэр сүлдийн талаар, далбааны талаар, урьдчилан бүлгүүдийг гаргаад, боловсруулаад санал хийгээд, тэгээд тэрийгээ хэлэлцүүлбэл арай чанартай, шуурхай болох юм биш үү. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь хажуугийн саналыг заавал эхний ээлжинд хэлэлцэнэ гэсэн ийм дэг бидний дунд ам ярианд яваад байгаа. Энэ цаашдаа бидэнд бэрхшээл учруулна. Тэгэхлээр энийг ямар журамтай, яаж хэлэлцэх юм бэ. Хурлын дарга анхааралтай сонссонгүй, ойлгов уу, үгүй юу.

Уртнасан: Зоригийн саналтай нэг байна. Бүлэг хуваагаад үзье гэдэг л ойлголт авлаа. Баярлалаа.

261 дүгээр тойргийн депутат Д.Цүрэв: Хурлын дарга таны анхааралд бүр нэг зүйлийг толилуулмаар байна. Тэгэхээр удиртгал хэсэг дээр иргэний гэдэг энэ үгийг зарчмын асуудлаа гэж ингэж хэлсэн. Та тэгэхээр энэ иргэний гэдэг энэ үгийг энд байлгах уу, үгүй юу гэдэг дээр санал хураахгүй бол хоёрдугаар эцсийн хэлэлцүүлэг дээр очоод энэ санал гаргасан депутат миний энэ оруулсан санал хаачиваа гэж нэхнэ. Тэгэхээр ахиад бид нэгдүгээр хэлэлцүүлгийгээ хоёрдугаар хэлэлцүүлэг дээрээ хийх гээд байна. Энийг шийдэж өгөхгүй бол депутатын хороо ямар ч зарчмын асуудлаар оруулж чадахгүй болно шүү дээ. Энийг одоо хурлын удирдлага үнэхээр анхааралдаа авахгүй юу. Нөгөө талаар эндээс санал хэлж байхад та нөхдүүд анхаарахгүй өнгөрч байна. Ийм учраас дараа нь энийгээ эргэж авдаггүй учраас энэ чинь ахисан, унжсан ийм юм болж байгааг эрхбич эрхэм дарга нар минь энийг анхаарч явахгүй бол хурал сунжраад байна шүү дээ.

142 дугаар тойргийн депутат Л.Цүрэвдорж: Би горимын ганцхан санал хэлье. Энийг зүйлээр нь зүйлчилж хэлэлцмээргүй байна. Зүйл дотроо жишээлбэл нэгдүгээр зүйлийн нэгдүгээр хэсэг байна шүү дээ. Тэрнийгээ хэлэлцүүлж дуусаад явахгүй бол болохгүй байна.

Уртнасан даргаа та сонсов уу. Нэгдүгээр зүйлийнхээ сая нэгдүгээр зүйлдээ хоёр хэсэг өгүүлбэрээ хоёулангаар нь сонсчихоор чинь болохоо болиод байна шүү дээ. Ерөөсөө ганцхан нэгдүгээр хэсгээрээ хэлэлцүүлгээ дуусгаад тэрнийгээ хэлэлцүүлгээ дуусгаад яваад байхгүй бол болохгүй байна. Нэгдүгээр зүйл чинь хоёр заалттай байгаа шүү дээ. Эхлээд нэгдүгээр зүйлийнхээ нэгдүгээр заалтыг хэлэлцээд дуусаад, дараа нь хоёрдугаар хэсэг рүүгээ гэж энэ дээр орж байгаа өгүүлбэр тус бүрээр бараг хэлэлцмээр байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Мунга

ЭНХТУНА

Бичээч В.Ожун

Г.Хашбаатар /29I дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр бид ингэмээр байна.Хүн бүхэн нэг өгүүлбэр уншаад тайлбар тавиад байвал барагдахгүй.Бид түрүүчийн депутатууд, түрүүчийн өдрүүдийн хуралдаан дээр санал гаргасан.Бага Хурлаас чинь энийг хэлэлцэхэд нэг өгүүлбэр бүр дээр олон санал гарсан байгаа.Эцсийн хэлэлцүүлгээр аль нэгийг нь тодотгож авсан байгаа.Ийм учраас энэ утга санаагаа, энийг боловсруулсан Бага Хурлын гишүүд эхэлж тайлбарлаж санаагаа өгөөчээ.Ухаандаа тэгш байдал гэдгийг яах гэж оруулсан юм бэ? Тэгш эрх гэж оруулаагүйн учир энэ гэсэн тайлбарыг нь сонсвол дараагийн улсууд үг хэлэх нь цөөрнө.Ийм учраас эхлэж Бага Хурал энийгээ барьж байж, субъектээ одоо тайлбарлаж өгөөч.Тэгвэл одоо саналууд цөөрнө шүү.

Ж.Уртнасан -Зүйл бүрийн өмнө Бага Хурлынхнаар тайлбар өгүүлж болно.Тэгэхдээ бас бодох л асуудал.Хэрэв, жишээ нь тэгш байдал гэдгийг гурван депутатын санаалаар хасах асуудал зарчмын гэж үзээд санал хураагаад хасна гэвэл Бага Хурлын гишүүд яагаад тэгш байдал гэдгийг энд байлгах ёстой юм бэ гэдэг талаар тайлбар сонсож байна.

Б.Чимид /396 дугаар тойргийн депутат/ -Болилоо.Та тэгээд л хураалгаад байвал болно.Жишээ нь бид оршлыг алгасаад явсан шүү дээ.Тэргүүн оршил хэсгийг.Тэгэхээр депутат Бямбаа оршлын төр ёс, түүх гэсний дараа шашин гэдгийг оруулна гээд явчихлаа.За ингээд энд онцын юм байхгүй юм байна гээд бид ингээд Гомбожав даргад өгчихлөө.Гомбожав даргад өгөөд нэгдүгээр хэлэлцүүлэг дууссаны дараа ороод ирлээ.Ороод ирэхээр Бямбаа гуай босоод ирнэ.Миний дараа алга байна гээд, ингээд дахиад нэгдүгээр хэлэлцүүлэг чинь давтагдах байхгүй юу.Тийм учраас энэ шашин гэдэг асуудлаа та зарчмын гэж үзэж байгаа юм уу, харж үзээрэй гэж хэлж байгаа юм уу? Энийг асууна.Энийг асуухаар өглөө баталсан дэг байна.Саналын зөрүүтэй зарчмын гэж дэвшүүлж байгаа асуудлыг хуралдаанд оролц-

сон депутатуудын ердийн олонхийн саналаар . "саналын зөрүүтэй, зарчмын гэж шийдвэрлэсэн тохиолдолд" гэж байгаа юм. Энэний шийдвэрийг бид гаргана. Бямбаа гуай зарчмын гэж зүтгэж байвч бидний 50-иас дээш хувь нь зөвшөөрөхгүй байвал тэгээд өнгөрөөд явчихна. Энэ ойлгогдож байна уу? Тэгэхгүй бол гурван хэлэлцүүлэг болно шүү сүүлдээ.

Ж.Гомбожав /Депутатуудын хорооны дарга/ - Их Хурлын даргаа та дөрвөн орлогчоо сайн ажиллуулахгүй бол болохгүй нь. Тэр зарчмын гэж байгаа юман дээр нэг нэгээр нь өгүүлбэр бичүүл. Тэгэхгүй бол та амжихгүй шүү дээ.

Ж.Уртнасан -Одоо би энд зарлах гэж байна. Дөнгөж сая гар дээрээ авлаа.

Ж.Гомбожав -Тэгээд Чимид даргынх шиг үнэхээр хаях гэхийг нь тогтоож өгөхгүй бол бид нэг хэсгийг авна, нэг хэсгийг хаячихна шүү. Тэгээд сүүлдээ эргээд задарна.

Ж.Уртнасан -Уучлаарай депутатуудаа. Бид энийг нэг ойлголтод хүрч байна. Дэгэндээ орж байна. Горимтой болж байх шиг байна. Энэ удиртгал хэсэг дээр манай ажлын групп 6 саналыг бид та бүгдтэй зөвшиж санал хураалцаж, дийлэнх олонхийн саналаар шийдэх ийм тохиролцоонд хүрэх шаардлагатай болж байна.

Нэгдүгээрт, энэ төр ёс, түүх гэсний дараа шашин гэж нэмэх гэсэн. Санал хураагаад явчихъя. За томъёоллыг өгч байна.

Болохгүй. Тэр чинь хоёрдугаар хэлэлцүүлэг дээр та босож ирээд би шашин гэдэг уг нэмье гэсэн байхгүй байна гэвэл... Хэрэггүй юу. За баярлалаа.

Оршил хэсэгт дэлхийн улс түмэнтэй энх тайвныг эрхэмлэн гэж төр ёсны гэсний өмнө оруулах гэсэн ийм санал ирсэн байна. Дахиад хэлье. Дэлхийн улс түмэнтэй энх тайвныг эрхэмлэн гэж

3.

төр ёсны гэсний өмнө оруулъя гэж.Энийг зарчмын гэж үзэж оруулах уу?санал хураалт явуулъя.За санал хураалт явуулж байна.

Энэ саналын эзэн Цэндбаяр.Хэрэв ингэхэд хүрвэл бид бас тайлбар сонсоно шүү дээ, хасах нзмэхдээ очвол.Санал хураалт явуулъя.

Ц.Цэндбаяр/ 280-р тойргийн депутат/ -Тэгэхээр Пүрэвдорж депутат эхлээд санал гаргасан.Би энэн дээр үг нэмсэн.Энийг бол бид үнэхээр зарчмын санал гэж үзэж байна.Яагаад вэ гэхээр монгол орон гадаад бодлого ямар байх вэ гэдгийг энэ удиртгалаасаа! гарах ёстой.Тэгээд дараагаар нь задраад нөгөө бүлгүүд явна.Энэ бол маш зарчмын санал гэж үзэж байна.

Ж.Уртнасан -За энэ хоёр депутат, гуравдугаар микрофон Пүрэвдорж та хоёрын санал бол ойролцоо байна.

-Энхтайван энэ тэр гээд ч яахав, энхийг эрхэмлэх л гэдэг үг нэмчих хэрэгтэй юм.

Ж.Уртнасан -Энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах гэж тиймээ.Энэ томъёоллыг зарчмын гэж үзэж байна.Санал хураалт явуулъя.

За олонхийн санал авч чадсангүй.Тэгэхээр Бага Хурлынхан тайлбар тавих хэрэггүй юу.

За цаашаа явъя.Дөрөвдүгээрт, хүний эрх гэсэн хэсэгт эв нэгдэл, зан заншил гэж нэмж оруулъя.Депутат Найдан... Тавдугаар микрофон.Найруулгын чанартай гэж үзэх үү?

Найдан. -Найруулгын чанартай гэж үзэж байна.

Ж.Уртнасан -За баярлалаа.Тавдугаарт нь ийм юм байна. Тэр дарлал мөлжлөггүй гэж нэмэх гэсэн ийм нэг томъёолол байна.Тэр найруулгын чанартай юу? За баярлалаа.

Аг зөвшөөр

-Тэгэхээр

тэр зан заншил гээд байна.Зан заншлаасаа тэр чинь хоршоо уг юм байгаа юм.Зан үйл гэвэл хоёр утга агуулгаад аятайхан болно.

Ж.Уртнасан -За найруулгын чанартай засвар юм.Зарчмын гэж үзэхгүй.

За иргэний гэсэн үгийг хасаж, хүнлэг гэж шинээр оруулах. Хүмүүнлэг, иргэний гэсэн үгийг хасаж, хүмүүнлэг гэсэн үгийг шинээр оруулах.

Цүрэвжав /102 дугаар тойргийн депутат/ -Дарлал мөлжлөггүй хүмүүнлэг гэдэг би нийтээр нь хэлсэн юм.Би энийг зарчмын асуудал гэж тооцож байгаа юм шүү.

Ж.Уртнасан -За томъёоллыг сонслоо.Дарлал мөлжлөггүй хүмүүнлэг гэсэн ийм санал оруулж байна.За санал хураалт явуулъя.За ердийн олонхийн саналыг авч чадахгүй байна.

Дараа нь даяар олноо гэснийг хасах, даян дэлхийд гэж өөрчлөн найруулах гэсэн ийм **санал** байна.Энийг найруулгын чанартай гэж үзэх үү? За.

Эв нэгдэл, шударга ариун хөдөлмөр гэж нэмэх гэж байна. За энийг бас найруулгын чанартай гэж үзлээ.

Уучлаарай депутатуудаа.Очирбат гуайн хэлсэн нэг санал бий.Энэ монголын ард түмэн бид гэдгийн оронд монголын ард түмний нэрийн өмнөөс БНМУ-ын Ардын Их Хурал гэсэн ийм томъёолол нэмье гэж байгаа юм.Өөрөөр хэлбэл бид ард түмнийг шууд төлөөлөхгүй, ард түмнийг төлөөлсөн Ардын Их Хурал гэсэн

5.

томъёоллоор оръё гэж. Энэ Очирбат гуай нэмэлт тайлбар хийх үү. БНМУ-ын гэж байгаа, одоо шинэ томъёоллоороо ярина. Зарчмын санал уу? За санал хураалт явуулъя. За санал хураалт явуулж байна. Томъёоллыг бид түрүүн хэлсэн.

За энэ санал явахгүй байна. Зөвшөөрсөн 117 буюу 32 хувь, татгалзсан 227 буюу 63 хувь, түдгэлзсэн 17 буюу 5 хувь.

Уучлаарай эрхэм депутатууд ямар асуудлыг хэлэлцэх гэж байгааг...

С. Батмөнх /2 дугаар тойргийн депутат/ -Эх орондоо хүмүүнлэг ардчилсан гэж би бичгээр санал өгсөн юмаа. Түрүүн тэр дарлал мөлжлөггүй гэдэг тодотгол хийгээд түрүүн хураалгалаа. Тийм учраас энэ зарчмын юм гэж санаж байгаа юм. Яагаад гэвэл иргэний гэдгийн оронд эх орондоо хүмүүнлэг ардчилсан нийгмийн цогцлон хөгжүүлэх зорилгоор гэж би бичгээр санал өгсөн. Энэ саналыг эргэж хурааж өгөхгүй юу гэж хүсч байна.

Ж. Уртнасан -За саяын депутат Батмөнхийн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт явуулаад шийдчихье. Зарим нь хураая гэж байна. Зарим нь хэрэггүй гэж байна. Санал хураалт явуулчихъя. Уучлаарай депутатуудаа. За томъёоллыг сая хэлсэн. Батмөнх хэллээ, хүмүүнлэг гэдэг энэ үгийг нэмж оруулах.

За редакцийн засварт, зөвшөөрсөн 197 хүн буюу 55 хувь, татгалзсан 146 хүн буюу 41 хувь, түдгэлзсэн 12 хүн 4 хувь байна.

Энэ бас айхтар сүрхий санаа гарч ирж байна. Бид бас энэ юм хэлэлцэхэд анхаармаар юм. Саяын дэгэн дээр байгаагаар бол энэ саналыг оруулах уу? Иргэний гэдгийн оронд хүмүүнлэг гэдгийг оруулах уу үгүй юу гэдгээр санал хураалт явуулаад, олонхийн саналаар оруулъя гэдэг санал авлаа. Хэлэлцье гэж. Зарчмын гэж үзэж хэлэлцье гэсэн санал авлаа.

Одоо дийлэнх олонхийн саналыг дахин хэлэлцээд дийлэнх олонхийн санал авбал энд тэр тусад нь.

За томъёоллыг иргэний гэдэг үгийг хасаж хүмүүнлэг гэдэг зарчмын үг оруулна. Тайлбар хэлэх гэж байна уу? За шууд санал хураалт явуулъя. Зарчмын санал гэж үзсэн боловч дийлэнх олонхийн санал авахгүй байна. 183 хүн буюу 57 хувь нь зөвшөөрч, татгалзсан 122 хүн буюу 38 хувь, түдгэлзсэн 18 хүн буюу 5 хувь байна. Эрхэм депутат Билэгсайхан юу хэлэх гээд байна.

Билэгсайхан / 184-р тойргийн депутат/ -Би бичгээр саналаа өгсөн. Тэгээд тэрийг, ухаандаа эхний найрлага дээр ингэж байгаа юм л даа. Монголын ард түмэн бид гэдгийг монголчууд бид гэж хураая гэж.

Ж. Уртнасан -Ажлын групп рүү шилжсэн саналууд бий шүү. Тэр найруулгын чанартай.

Ж. Чунагсүрэн /215-р тойргийн депутат/ -Даргаа тэр иргэний гэдэг чинь их зарчмын томъёолол юм шүү. Тэрийг хасчихлаа. Тэр буруу шүү.

Ж. Уртнасан -Хасаагүй, та нар анхааралтай суугаарай. За анхаараарай депутатуудаа. Бид сая зарчмын саналуудаа ялгаж авлаа. Оруулах эсэхээ шийдчихлээ. Ийм учраас манай ажлын групп ажилдаа ороход бэлэн болох шиг боллоо. Удиртгал хэсгийг зарчмын хувьд нэгдүгээр хэлэлцүүлгийг дуусгая гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна.

Эрхэм депутат Батжаргалаа таны санал хаана яваа юм болоо?

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Алтанцэцэг

Д. АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

49-р Кассет 2-н
Баянцүл (Хийгч нөвчлөр)
1991.11.21
Кассет IY-50
I9.35-20.33

Ардын Их Хурлын хоёрдахь удаагийн хуралдааны явц байдлын талаар энэ хуралдааны эхэн үед зохион байгуулагдсан ардчилсан бүлгийнхний зүгээс өнөөдрийн хэвлэлийн бага хурлыг явуулж энэ бүлгийнхний санаа бодлыг илэрхийлж, хангалттай ярилцахаар бид цуглараад байна.

Эхлээд би ардчилсан эвсэл бүлгийнхний тухай маш товчхон мэдээ өгье. Ардчилсан эвсэл бүлэг хуралдааны дэгийн дагуу зохион байгуулагдсан. Олон намын төлөөлөгчдийг, гишүүд, депутатуудыг багтаасан бүлэг байгаа юм. Энэ бүлэгт МОН, МСДН, МҮДН, МАХН-ын хэсэг гишүүд цаашид залуучууд ардчиллын төлөө бүлгийнхөн нам бус хэсэг депутатуудыг багтаасан байгаа юм.

Эхний үед энэ ардчилсан эвсэл бүлгийн бүрэлдэхүүнд 100 орчим депутатууд бүртгүүлжээ. Олон нам бүлгийн төлөөлөгчдийг багтаасан ардчилсан эвсэл депутатуудын бүлэг ямар нэгэн хатуу байр сууринаас асуудалд ханддаг биш, олон ургальч үзлийн байр сууринаас асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, тэгэхдээ бидний хэлэлцэж байгаа Их цаазын төслийг зохих засвар оруулж батлуулах, зарчмын маргаантай асуудлаар эвшилцэж, зүй зохистой шийдвэр гаргаж ажиллахыг эрмэлзээн ийм зорилго тавьсан бүлэг байгаа юм.

Ардын Их Хурлын II дахь удаагийн хуралдаан эхлээд 10 хоног хуралдаж ирлээ. Энэ урт удаан хугацаанд маш их зарим үедээ идэвхтэй ширүүн маргалдсан боловч одоохондоо том үр дүнд хүрээгүй байна.

Өнөөх болтол депутат бид нар улсынхаа нэрийн талаар ярилцаж зохих шийдвэрээ гаргаж чадаагүй байна. Миний бодоход юуны түрүүнд МАХН-ын зарим гишүүд, депутатууд хуучинсаг байр сууриас хандаж, улсын нэрийг заавал ард улс гэж болгохоор зүтгэж байгаа юм байна. Үүнээс болж хурлын үйл ажиллагаа ихээхэн хүнд байдалд орж байна.

Ард гэдэг бол монгол сайхан үг. Тэгэхдээ ард улс гэдэг томъёолол бол түүхэн тодорхой хугацаа, түүхэн тодорхой үеийг илэрхийлсэн үзэл суртлын ерөөсгөл талыг тусгасан цаг үеэ өнгөрөөсөн ийм томъёолол гэж би хувьдаа үзэж байна.

Ингээд шинэчлэл, ардчилал, зах зээл гэсэн ийм дэвшилтэт лоозонг дэвшүүлж байгаа боловч, үнэн хэрэг дээрээ нэг бодоход улсын нэр гэхэд бага юм шиг, нөгөө талаас дээр дурдсан энэ зарчмын асуудлыг шийдвэрлэж, үнэхээр ардчилал, зах зээл рүү улс орноо хөгжүүлж гэхэд бол хуучинсаг байр сууринаас баримталж байгаа нэрийг хэрэглэхэд маш хэцүү болоод байгаа юм.

Энэ бол зүгээр нэрийн асуудал биш. Цаана нь үзэл суртлын үзэл санааны хүчтэй байр суурь байгаа гэдгийг ярьж болно. Тэгэхдээ энэ хэвлэлийн бага хурал дээр бид хуралдааны явц байдлын талаар зарим дүгнэлтийг хийх байх.

Энэ бага хуралд оролцож байгаа ардчилсан эвсэл бүлгийнхний нам, бүлгийн депутатууд гишүүд энд сууж байгаа учраас нөхөд бас нэмэрлэж өөрийнхөө байр суурины талаар ярих байхаа.

Одоо Бага Хурлын орлогч дарга, доктор Зардыхан үг хэлнэ.

К.Зардыхан:

Манай ардчилсан жигүүрийг ахлаж байгаа академич Барсболд та бүхэнд бидний зорилгыг ярилаа. Бид энэ хэвлэлийн бага хурал хийж байгаа явдал бол бид Ардын Их Хурлын хуралдаан ямар нэгэн мухардалд орчихоод, ямар нэгэн асуудлыг огт шийдвэрлэж чадахгүй болоод, бид ямар нэгэн том хагаралдаан гараад ингэж хэлж байгаа юм бишээ.

Бидний асуудлыг шийдвэрлэх зам бол нээлттэй байна. Тэгэхдээ хурлын явц дунд гарч байгаа зарим нэгэн асуудлыг хэвлэл мэдээллийн нөхдүүд хүндэт сэтгүүлч та бүхэнд бид хэлэх нь зүйтэй гэж үзсэн учраас өнөөдөр энд бид хуран цуглаж байна.

Бид манай ардчилсан жигүүр, ардчилсан бүлгийнхэн түүнд орж байгаа депутатууд, ер нь депутатуудын олонхи нь энэ Их цааз буюу Үндсэн хуулийг батлахын төлөө байгаа. Ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталж чадвал одоогийн сонгогдсон бидний энэ 427 депутатын бахархлын хэрэг болох байсан, болох юм гэж бид үзэж байгаа. Энэ зорилгоор бид Үндсэн хуулийг батлуулахын төлөө байна. Батлахын төлөө байна. Тэгэхдээ энэ Үндсэн хууль бол Ардчилсан үндсэн хууль байхын төлөө.

Бид нар энд хэвлэлийн бага хурал хийхдээ ямар нэгэн депутатыг зэмлэх гээгүй байна. Ийм үндэс ч өнөөдөр бидэнд алга. Гэхдээ Үндсэн хуулийг хэлэлцэж эхэлсэн 10-аад хоногийн үйл явцыг бид дүгнэж үзвэл үндсэндээ өнөөдөр Ардын Их Хурлын хуралдаан дотор 2 чиглэлийн үзэл суртлын, үзэл баримтлалын тэмцэл явагдаж байна. Нэг хэсэг нь үнэндээ энэ ардчилсан Үндсэн хуулийг батлуулахын төлөө 1990 онд тайван замаар манай залуучуудын идэвх санаачилгаар ардчилсан хүчнүүдийн идэвх санаачилгаар олж авсан энэ ардчиллыг гүнзгийрүүлэхийн төлөө түүнийг хуудийн эрх үндсийг батжуулахын төлөө байна.

Нэг хэсэг нь Үндсэн хууль батлахыг үнэндээ хүсч байх шиг байна. Тэгэхдээ өөрсдийн тухайлбал хүнд суртлын үеийн үзэл суртал, баримтлалыг ардчилсан шинэ Үндсэн хуульд шингээж үлдээхийг оролдож байна. Ийм хоёр чиглэлийн хооронд өнөөдөр үнэндээ тэмцэл явагдаж байна.

Өнөөдөр би энэ дээр ямар нэгэн хүчин, ямар нэгэн депутатыг зэмлэх аргагүй гэдгийг онцолж хэлсэн. Гэхдээ бид энэ дээр нэг зүйлийг та бүхэнд би хэлэхийг өөрийн ёс суртахууны үүрэг гэж бодож байна. Юу вэ гэвэл өнөөдөр хуучны үзэл суртал, энэ хуучин үзэл суртлын зохион байгуулалт бол МАХН-ын дотор үүрлэж байна. МАХН-ыг бид бүхэлд нь зэмлэх гээгүй. Зэмлэх ч ёсгүй. МАХН-ын дотор ардчилсан үзэлтэй хүмүүс, ардчиллыг дэмждэг хүмүүс, ийм жирийн гишүүд, ийм намын ажилтан олон бий. Тэгэхдээ өнөөдрийн МАХН-ын удирдлагын доторх зарим хэсэг, түүнчлэн намын аппаратын хүмүүс, өөрсдийнхөө үзэл санааг

депутатуудаар дамжуулж, ардчилсан үндсэн хуульд тулгахыг оролдож байна. Би та бүхэнд нэг баримт бичиг үзүүлье. МАХН-ын гишүүн танд толилуулах лавлагаа гэдэг энэ бичгийг МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчид, депутатуудад тараасан. Энэ бичгийн гарчиг нь бол лавлагаа. Гэхдээ энэ дээр үндсэндээ Үндсэн хуулийн зарчмын гол асуудал дээр зайлшгүй хөтөлбөргүй баримтлах намын чиг шугам гэж гарт нь бариулсан байна. Ийм учраас үнэндээ орон нутгаас ирсэн, ч байдаг юм уу, мөн хотоос сонгогдсон зарим депутатууд Үндсэн хуулийн асуудалд хандахдаа үнэндээ хоёр зүйлийн бэрхшээлд орж байна.

Депутатын хувьд тэр хүн бол өөрийнхөө үзэл санааг шууд илэрхийлэх хэрэгтэй байдаг. Гэтэл намын бичиг нь өвөрт байдаг. Энэ хоёрын дунд өнөөдөр депутатууд сэтгэл санааны хувьд өөрийн зөрчилд орж байна.

Энэ бол асуудал шийдвэрлэхэд асар их нөлөө үзүүлж байна. Бид эхний хоёр асуудлыг л ярьж байна. Хоёр асуудал гэдэг бол Үндсэн хуулийн нэр, улсын нэрийн асуудал. Энэ дээр нэгдүгээрт заагаад өгсөн, улсын нэрийн тухай гээд улсын нэрийг БНМАУ хэвээр нь нэрлэх, Их цааз гэдгийг Үндсэн хууль гэж хэвээр нь нэрлэх. БНМАУ-ын газар түүнийг баялаг улсын онцгой өмч байна гэж томъёолж оруулах гэх мэтчилэнгийн зөвлөлгөөг бичээд өгсөн байна.

Энэ бол би үнэндээ депутатуудыг огт зэмлэмээргүй байна. Энэ депутатуудад миний хайр хүрч байна. Үнэндээ зөрчилд орж, бэрхшээлд орж байна, энэ депутатууд. Ийм учраас бид өнөөдөр энд юу хэлэх гэж бодож байна вэ гэвэл эцсийн эцэст өнөөдөр бидэнд ямар нэгэн намын, ямар нэгэн улсын төрийн хүчний, ямар нэгэн улс төрийн бүлгийн шаардлага биш, Их Хурал, парламент бол өөрөө депутатууд бие дааж асуудал шийдвэрлэх бололцоотой, ийм зорилгоор Ардын Их Хурлын хуралдаанаа хийж байна.

Энэ нь депутатуудын бүтээлч үйл ажиллагаанд саад болохгүйгээр ажиллах ийм нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Ингэж бүрдүүлэхгүй бол магадгүй цаашдын ажилд энэ Үндсэн хуулийг батлах ажил хүндэрч болзошгүй.

Эцэст нь хэлэхэд магадгүй МАХН-ын зарим удирдах хүмүүс ч байдаг юм уу? МАХН-ын доторх хуучны үзэл баримтлагч хүмүүс МАХН-ын дотор хатуу байр суурь баримтлагчид, магадгүй маргааш телевизээр гараад ч юм уу, өнөөдөр радиогоор биднийг зэмлэж болно. Би үүнийг үгүйсгэхгүй байна. Өөрөөр хэлбэл ардчилсан бүлгийнхэн асуудал зүй ёсоор явах байсан юмыг саатуулж байна ч гэх юм уу? Эд нар саад болж байна ч гэдэг юм уу, эд нар хурал хаях гэж байна гэдэг юм уу? Ийм байдлаар хөдөлмөрчдөд буруу суртал хийж болзошгүй. Ийм буруу суртлаас бид урьдчилсан сөргийлэх хэрэгтэй. Үүнийг л би хэлж, Монголын хөдөлмөрчид энэ асуудалд ухаантай хандах байх. Депутатууд ухаантай хандах байх, бид эцсийн эцэст энэ ардчилсан үндсэн хуулийг батлах байхаа гэдэгт найдаж байгаагаа та бүхэнд товчхон илэрхийлье.

Баярлалаа.

Барсболд: Оролцож байгаа нам бүлгийнхнийг би танилцуулъя, төлөөлөгчдийг нь. Баярцогт-Залуучууд ардчиллын төлөө бүлгийг төлөөлж байна.

Депутат Сайран -тус эвслийн нарийн бичгийн дарга, МОАН.

Депутат Зориг -Бүгд найрамдах нам, хоёр нам.

Депутат Бат-Уул -МОАН, Депутат Хатанбаатар -МСДН, депутат Дашням -МУДН, депутат генерал Пүрэвдорж нам буснуудын бүлэг.

Р.Хатанбаатар /МСДН/-Бид бол 70 зүйлтэй Монгол улсын Их цаазыг батлахаар II хоног хэлэлцэж байна. Өнөөдрийн байдлаар нэг ч зүйлийг хэлэлцэж амжаагүй байна. Одоогоор бид зөвхөн Улсын нэр, Их цаазын нэрийн тухай ярьж байгаа боловч үнэн хэрэг дээрээ шинэ хуучны хурц тэмцэл явагдаж байна гэж би үүнийг хэлнэ.

Улс орны байдал маш хүнд байгааг далимдуулан хуучинсаг хүчин, ардчиллын ололтыг үгүй хийхийг хүсч байна.

Хэрвээ бид цаашид энэ байдлаараа байх юм бол үнэн хэрэг дээрээ Ардын Их Хурлын энэ удаагийн хуралдаан ямар нэгэн үр дүнд хүрэх найдвар тун бага байна. Гэхдээ бол манай улсын хувьд ингэж хүнд байдалд ороод, хүнд байдлаас гарч байсан ийм туршлага бий. Тухайлбал бид нар 1990 оны 3 дугаар сард улс төрийн хүчнүүд ярилцан, зөвшилцөн шийдвэрт хүрч чадсан.

Ингээд би юу хэлэх гэж байна вэ гэхээр МСДН-ын Ардын Их хурал дахь бүлгийн нэрийн өмнөөс цаашид Ардын Их Хурлын хуралдааныг хэвийн байдлаар явуулж, шинэ үндсэн хуулиа батлахын тулд энэ өнөөдөрх улс төрийн хүчнүүдийн зөвлөлгөөн, дугуй ширээний ярилцлагыг Монгол улсын Ерөнхийлөгчийн оролцоотойгоор хийх санал тавьж байна.

Хэрвээ бид ингэж улс төрийн шийдвэрт хүрч чадахгүй бол үнэн хэрэг дээрээ Ардын Их Хурлын өнөөгийн бүрэлдэхүүн, одоо энэ хуралдаж байгаа байдлаараа ямар нэгэн шийдвэр гаргах чадваргүй болжээ. Ийм учраас бид зөвхөн улс төрийн шийдвэрийн хүчинд л ийм мухардмал байдлаас гарна гэж бодож байна.

Дүгнэлт: Монгол оронд хөлд орж торниж байгаа ардчиллын хамгийн нэг хүчирхэг шугамуудын нэг нь үндэсний сэргэн мандал, монголчуудын олон зууны туршид хуримтлуулж ирсэн шилдэг өв санг, уламжлан явахыг манай залуучууд ч баяртай байгаа, монголын нийгмийн ойг тойг хадгалж ирсэн, өвгөд өтгөс маань ч баяртай байгаа.

Монгол орон бол залуучуудын орон гэдгийг та бүхэн мэднэ. Шинэ засаг хуульд тийм нэрийг одоогоор Их Хурлын хүрсэн үр дүн бол ганцхан энд л байгаа. Шинэ засаг хуульд монголын уламжлалт соёлыг хадгалсан олон сайхан санаа бий. Гэвч энэ өнгөрсөн хугацаанд энэ санаа нь Шинэ засаг хуулийн /Их засаг/ төсөлд орсончлон, энэ хуулийг боловсруулсан хүмүүсийн бодсончлон, депутат болгоны ой ухаанд хүрэхгүй байгаад бид бас харамсалтай байгаа.

Ардын Их Хурлын цаашдын явц бол Ардын Их Хурлын танхимд хуран цугласан 427 депутатуудын ой ухаан, тэдний нийгмийн төлөө тавьж байгаа сэтгэл, итгэл дээр тогтоно гэж бид нар бодож байгаа. Гэвч энэ байдал депутатууд, бүрэн байдлаар энэ хариуцлагаа, энэ ухамсраа түүнийхээ хэмжээнд ажиллахгүй байгаагаас Хурлын явц удаашралтай байна гэж бид нар бодож байгаа. Хурлыг цаашид амжилттай болгох, Монголын нийгмийн өөрчлөлтийг нийгмийн системтэй бүрэн цогц энэ өөрчлөлтийг хуульчлан бататгаж өгөх, Их засаг хуулиа батлах явдал бол нийгмийн амьдралын өөрчлөлтийг харуулаад зогсохгүй, Монгол нийгмийн өнөөдрийн оюуны төвшнийг харуулах ёстой гэж бид нар бодож байна. Ийм учраас манай намын бүлэг, Их Хурлыг цаашид амжилттай явуулахын төлөө бүхий л хүчин чармайлтаа гаргаж байгаа, үүний нэг бид нарын тавьж байгаа тодорхой санал бол Их Хурлын дотор байгаа оюуны чадавхийг аль болохоор бүрэн дүүрэн дайчлах, үүний тулд нам хоорондын зөвшилцөөн, зөвлөлгөөн явуулах, уужим тайван Монгол ухаан зарах, ингэснээр зөрчилтэй байгаа зөрөлдөөнтэй байгаа олон асуудлуудыг шийдэж, нийгмийн өнөөдрийн шаардлагад нийцсэн, ард түмнийхээ хүсэл эрмэлзлэлд нийцсэн тийм хуулийг баталж чадна гэж бодож байгаа.

С.Зориг: /БН нам/

Ардчилсан хүчний эвсэлд бол намайг хоёр намыг төлөөлөх эрх олгосон. Чөлөөт хөдөлмөрийн нам албан ёсоор бүртгүүлсэн, тэгээд бүртгүүлээгүй байгаа Бүгд найрамдах нам. Энэ нь зөрчил гарч байгаа хамгийн гол шалтгаан бол нийгэмд бий болсон хүчний харьцаа тэр нь жилийн өмнө бий болсон Их Хурлын дотоод хүчний харьцаа хоёрын хоорондын зөрчил байгаа.

Энэ нь хуучин нэлээд бат бөх нягтралтай байсан МАХН, өөр тулгуурлах хүчгүй болсон учраас хамгийн сүүлийн хариугаа авах, үлдсэн цорын ганц хэрэгсэл болох, Их Хуралд байгаа олонхио ашиглах ийм замд орсон. Энэ бол их муйхар зам. Яагаад гэхээр асуудлыг нотолгоотой, цаад талын үр дагаврыг бодож, янз бүрийн үзэл бодолтой хүмүүс хийдвэрлэх чадвартай гэдгийг улсын Бага Хурал харуулсан.

Гэтэл түүнийг хүртэл 100 хувь үгүйсгээд, өөрийнхөө намд байгаа, тэнд сууж байгаа тэр 60 хувь эзэлж байгаа гишүүдээ хүртэл бүгдийг нь үгүйсгээд ийм муйхраар зүтгэж байгаа нь зөвхөн явцуу үзэл суртлыг урдаа барьж явж байгаагийн шууд баталгаа гэж үзэж болно.

Энэ дээр МАХН-ын хуучинсаг үзэлтэй хүмүүсүүд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Ардчилсан хүчнүүд анхнаасаа явахдаа аль болохоор зөвшилцлийн замаар явахыг оролдсон. МАХН-ыг дорнод европын орнууд шиг үйл ажиллагааг нь зогсоо, коммунистуудыг хуучин хүн хэлмэгдүүлсэн дэглэм, хүнийг тагнан мөрдөх үйл ажиллагаа, хүний эрх зөрчсөнтэй нь холбоотой, дорнод европын орнууд шиг ажилд битгий ав, үйл ажиллагааг битгий явуул гэсэн ийм туйлшралыг бид хийгээгүй.

Гэтэл ийм уян хатан байр суурьтай хандаж байхад МАХН-ын хуучинсаг үзэлтнүүд ийм маягийн байр суурь баримталж байгаа нь өөрийн эрхгүй болж өгөхгүй бол тэмцлийн өөр хэлбэрийг сонгох тийм хэлбэрт ч хүргэж магадгүй. Тэдний баримталж байгаа байр суурь бол зөвхөн биднийх бол үнэн, тэднийх үнэн гэдэг нь зөвхөн тэд нарын үзэл суртал, хоцрогдсон үеэ өнгөрөөсөн үзэл суртал үнэн гэсэн ийм байр суурийг баримталж байгаа.

Бид нар бол аль болохоор боломжийн хувилбарыг олон удаа ярилаа. Хэд хэдэн удаа янз бүрийн хувилбараар буулт хийж үзлээ. Гэтэл ер нь тэр хүнтэй нотолгооны журмаар үг хэлээ ололцох журмаар байж чаддаггүй тийм хүмүүс их олон байдаг юм шиг байна, МАХН-ын хуучинсаг үзэлтнүүдийн дотор.

Тийм учраас энэ чуулган, өөрийнхөө зорилтыг биелүүлж чадахгүй бол яах аргагүй парламентын хямрал, үндсэн хуулийн хямрал гаргах асуулд хүргэнэ. Түүний хамгийн тод жишээ нь гэвэл МАХН-ын бүлэг маань өөрөө дотроо нэгдсэн санал гаргах чадвараа алдсантай холбоотой. Албан ёсны удирдлагадаа захирагдахгүй, харин цаана нь зогсож байгаа, ар талаас нь хүүхэлдэйн театр удирддаг хүмүүс шиг уяагаар тэгж татаж удирддаг, нууц удирдаг-

дагчидтай болсон юм шиг байна.

Э.Бат-Үүл: /МОАН/

Саяны Ардын Их Хурлын завсарлагаанаас өмнөх хуралдаан дээр МОАН-ын бүлэг хуралдаад Ардын Их Хурлын энэ удаагийн хуралдааныг мухардмал байдалд орлоо гэж дүгнэсэн. Тэгэхээр яагаад ийм дүгнэлт хийж байгаа юм бэ гэхээр хоёр үндсэн шалтгаан бий.

Нэгдүгээрт, ер нь ардын Их Хурлын чуулган хуралдахаас өмнө улс оронд бий болсон эдийн засгийн хүндрэлтэй байдал дээр дөрөөлж, хуучны бүх үзэл санаа руу эргэж буцах гэсэн хүчний үйл ажиллагаа, явуулга маш хүчтэй болсон юм. Бид бол сэрэмжилж байсан. Энэ үйл ажиллагаа, явууллагыг Ардын Их Хурал, төрийн эрх барих дээд байгууллага, Ардын Их Хуралд оруулж ирэх вий гэж бид их болгоомжилж байсан. Гэтэл тэр эрүүл саруул бус үзэл санааг Ардын Их Хуралд оруулж ирсэн.

Үүнийг нь МАХН-ын хуучинсаг хүчин маш их идэвхтэй дэмжсэн. Тэгэхээр нэгэнт Ардын Их Хурлын чуулганд аргагүй олонхи болж байгаа, бараг үнэмлэхүй олонхи болж байгаа энэ нам нь болчимгүй байр суурь болоод, ^{баримталснаас} хуралдаан туйлын эвгүй байдалд орж эхэлсэн. Бид аль болох зохицох, аль болох бие биендээ байж болох хувилбарыг хайх гэсэн янз бүрийн оролдлого явуулсан. Харамсалтай нь яг энэ асуудлыг магадгүй эцсийн байдлаар санал хурааж шийдэхийн өмнөхөн МАХН-ын дарга Даш-Ёндон бие даасан депутатуудын бүлгийн дарга Дашбалбар нар БНМАУ гэдэг нэр дээр хатуу байнаа гэсэн ийм зүйлийг илэрхийлсэн.

Тэгэхээр үнэндээ энэ МАХН-ын удирдлагын байр суурь бол биднийг зайлшгүй үүнийг мухардмал байдалд оруулахуйцаар МАХН томъёолж ирлээ гэж ойлголт бидэнд төрүүлсэн. Өөрөөр хэлбэл өнөөдөр хуралдааны цаашдын явц, ер нь энэ Үндсэн хуулийг авч гарах асуудал бол би дахин хэлэхэд депутатуудын маш олон хэсгийг удирдаж байгаа МАХН-ын үйл ажиллагаанаас шууд нөлөөлнө гэж хэлмээр байна.

Тэгэхдээ бид ийм мухардмал байдалд орлоо гэдгээс тэр болгон ку кугүй сэтгэл алдрахгүй байна. Яагаад вэ гэхээр ер нь өнгөрсөн тэмцлийн туршлагад бол монголчууд бид нар мухардмал байдлаас яаж ийгээд, эв зүйгээ олоод гарч болж чаддаг гэдгээ нотолж чадсан, энэ удаад ч бас тэгж чадах болов уу? Тэгэхдээ дахин хэлэхэд МАХН-ын хуучинсаг хэсэг өнөөдөр Ардын Их Хуралд зонхилох хүч болж байгаа хуучинсаг хэсэг эрүүл саруул ухаантайгаар хандаж чадвал ийм байдал бий болж чадна гэж бодож байна.

Надад хуралдааны эхний үеэс ажиглагдсан хоёр зүйлийг хэлье гэж бодож байна. Хурал бол олон ургальч үзлийн үүднээс үндэслэлтэй хэлэлцэж, маргаж ингэж асуудлыг шийдэх ёстой.

Нөгөө талаар танин мэдэхүйн процесс байх ёстой. Тийм ч учраас манай хуралдаан 20-иод хоног хуралдах хугацаатай юм. Эхний үеэс эхлээд манай Их Хурлын зарим депутатууд энэ танин мэдэхүйн процесс, ярилцаж, харилцаж шийдэх, парламентын ердийн ^{БОЛОН} улсын практик болсон, ерөөсөө тийм байх ёстой энэ аргын асуудлыг зарим нь нэлээн эсэргүүцсэн, ямар ч тайлбар сонсохгүй, бид бол шийдчихээд ирсэн, шууд л ингээд саналаа өгөөд ингээд явах ёстой гэж. Депутатууд мэдээж хэрэг, толгойгоо дааж өөрийн гэсэн бодолтой Их Хуралдаа ирсэн гэдэг нь мэдээж. Их цаазын ^{ТӨСЛИЙГ} олон сарын турш хэлэлцсэн. Гэхдээ хэлэлцэж, учрыг нь олох нь хурлын хэвийн үзэгдэл юм. Гэтэл үүнээс болгоомжлоод байгаа бол миний хувьд, хувьдаа бодоход бол бид зарим улсууд ингээд байсан л даа, бид ухуулганд оч орчихож мэднэ, ерөөсөө хэлэлцэхгүй, бидний ухуулж хэрэггүй гээд. Ухуулаад ирвэл үнэн юм танигдаад, үнэн юмыг зарим хэсэг депутат ингээд байгаа чинь, үнэнээс зарим талаараа айж ч байгаа юм шиг, их гэнэн гэдэг юмуу тийм юмнэлээн ажиглагдаж байсан.

Тийм учраас нэлээн иймэрхүү хурцдуу болж магадгүй юм. Тийм учраас манай бүлэг зохион байгууламжсан. Энд нэгийг би хэлье гэж бодож байна. Ер нь зарим нь хэллээ. Хуралдааны эцсийн үр дүн МАХН-аас шалтгаална.

Яагаад вэ гэхээр 80 хувь нь энэ намын гишүүн байгаа. Хуралдааны эцсийн улс төрийн хариуцлагыг ч МАХН хүлээх ёстой. Яагаад вэ гэхээр 80 хувь нь юм чинь, цөөнх нь ямар ч байдал гаргалаа гэсэн. Ямар ч байдал гарахгүй, бид бол ерөөсөө хурлыг амжилттай болгох, уйгагүй хуралдах ийм л үзэлтэй байгаа.

Ийм учраас нэгэнт 80 гаруй хувь болсон энэ намын үүрэг роль их юм. Тийм учраас миний хувьд МАХН-ын гишүүн депутатуудын улс төрийн хараа, монгол ухаанд найдаж байна. Тийм учраас Их Хурал амжилттай болж, бэрхшээлээ даван туулж, өмнөө тавьсан үндсэн зориултуудаа шийдвэрлэж чадах байхаа гэж бодож байна.

Одоогийн энэ байдал цаашаа үгдэрвэл, парламентын хямралд орох осол бол байна. Үүнээс сэргийлэх хэрэгтэй. Тийм учраас өнөөдрийн бидний хэвлэлийн бага хурлын нэг зорилго бол олон түмэнд зөв мэдээлэл өгч, бас парламентаа хүнд байдалд оруулахгүй, сэргийлэх ийм л зорилготой юм.

С.Баяр /МАХН/

Тэгэхээр би МОАН-ын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч чадахгүй байгаа юм л даа. Ардын Их Хурлын II хуралдаан мухардалд орсон гэдгийг би хүлээн зөвшөөрч чадахгүй. Бид парламентын чуулганаа хийж байна, жирийн үзэгдэл, асуудлыг шийдэх, үгүйн зааг дээр тулаад байх явдал бол.

Тэгэхээр бидэнд сонголт байхгүй. Зөвшилцөл хийх үү, сөргөлдөөнд байх уу гэдэг сонголт бидэнд байхгүй л дээ. Яагаад гэвэл бид сөргөлдөөнд орох юм бол тэр нь улмаар туйлшрал болно. Туйлшралаас гарах ганц үр дагавар бий. Тэр нь бол хямрал, сүйрэл. Зөвшилцлийн замаар явах юм бол бид үндэсний болон улсын эв нэгдэлд хүрнэ. Миний ойлгож байгаагаар бол манай улсын хөгжлийн гол суурь бол эв нэгдэл.

Доктор Зардыхан МАХН-ын тэргүүлэгчдээс тараасан лавламж бичгийн талаар ярьж байна л даа. Аливаа нам, парламентад сууж байгаа гишүүддээ ямар ч бичиг баримт тарааж болноо.

Бусад нам ч тараасан байх. Тэгэх ч ёстой гэж ойлгож байгаа. Миний сэтгэлийг зовоож байгаа ганц зүйл юу вэ гэхээр тэр лавлагаанд оруулсан удирдамж гэх юм уу, зөвлөмж гэх юм уу? Энэ зүйл нь миний намын/ би МАХН-ын гишүүн/ тунхагласан мөрийн хөтөлбөртөө тунхагласан ардчилал, зах зээл, олон ургальч үзэл, өмчийн олон хэлбэрийн төлөө байна гэсэн энэ зүйлтэйгээ харшилж байгаа учраас би сэтгэл дундуур байгаа юм.

Ардчилсан намын дүгнэлт хэрэв зээ үнэн болоод бид мухардалд хүрэх юм бол энэ нэн осолтой. Үүнээс гарах үр дагаврыг төсөөлж хэлэхэд тун бэрх. Мухардалд оруулсан хариуцлагыг бид бүгдээрээ хүлээн. Ардын Их Хурлын 426 депутат бүгдээрээ хүлээнэ. Гэхдээ Ардын Их Хурлын 80 гаруй хувийг бүрдүүлж байгаа, Засгийн газрын 80 гаруй хувийг бүрдүүлж байгаа, Улсын Бага Хурлын 60 хувийг бүрдүүлж байгаа МАХН, дахин давтаж хэлбэ, миний нам хариуцлагын гол ачааг үүрэх нь гарцаагүй. Гэхдээ би итгэж байна. Би өөдрөг үзэлтэй байгаа. Эрх ашгийн тухай бид ярьдаг. Эрх ашиг гэж бий, хувь хүний эрх ашиг гэж бий, хэсэг бүлгийн эрх ашиг гэж бий, нэг намын эрх ашиг бий, бид Ардын Их Хурлын депутатуудын хамт олны нийт үндэснийхээ эрх ашгийн төлөө явна. Ардын Их Хурлын депутатууд, түүний дотор миний намын гишүүдийн эрүүл сэтгэл, зөн бэлгэ, мэдэрэмж, монголоо гэсэн сэтгэл ялна гэдэг би итгэлтэй байгаа.

Барсболд: Асуух юм байвал асууж болно.

С.Баярцогт: Би Залуучууд ардчиллын төлөө бүлгийг төлөөлж байгаа. Энэ бүлэг маань залуу депутатууд нийлж Их цаазын ардчилсан зарчмууд гол гол зарчмуудыг хэвээр нь авч үлдэх, хадгалахын төлөө энэ Үндсэн зарчим дээр байгуулагдсан бүлэг, ерөөс үндсэн хууль гэдэг маань " ", тухайн улсын дараагийн бүхэл үеийг тодорхойлсон гол хууль байдаг учраас энэ бол залуучууд бидний цаашдын аж амьдралыг голч тодорхойлох ёстой гэдэг байр суурин дээр байгаа учраас ийм эвсэл байгуулсан.

Одоогийн мухардалд орсон энэ бүх зүйлүүдийг би хоёр үндсэн шалтгаанаар тайлбарлаж ойлгож байгаа. Үнэхээр энэ төсөл маань магадгүй энэ хүмүүсийн сэтгэл санааны тэр хараат байдлыг бид өөрчлөгдсөн гэдэгт их найдаж байсан байна. Би хувьдаа тэгж найдаж байсан. Гэтэл үгүй байж. Энэ хүмүүсийн намаас, ямар нэгэн колонийн тэр хараат сэтгэлгээнээсээ арилж чадаагүй, энэ байдал маань нэгдүгээрт, асуудлыг ийм мухардмал байдалд оруулж байна. Нөгөөтэйгүүр, парламент гэдэг маань үзэл бодлоороо нэгдсэн намуудын хоорондох тэмцэл байх ёстой, ингээд одоогоор манайд байгаа намууд маань өөрөөр хэлбэл зонхилж байгаа нам маань өөрийн гэсэн үзэл бодолтой, тийм намын байр сууринаас ажиллаж чадахгүй байгаа явдал Ардын Их Хурал дахь энэ замбараагүй байдал, мухардмал байдлыг бий болгож байна гэж үзэж байна.

Тэгээд залуучууд, ардчиллын төлөө бүлэг маань энэ мухардмал байдлаас Монгол хүн, монголчууд уужим ухаалаг сэтгэлгээгээрээ зохицолд хүрч, шийдвэрлэж чадна гэж найдаж байна. Хэрвээ энэ ардчилсан үндсэн хуулийг энэ чуулганаар баталж чаддаггүй юмаа гэхэд дараа дараагийн сонгуульд ардчиллын төлөө гэсэн залуучууд маань ялж дийлсэн тэр цагт, зайлшгүй батална гэдэг өөдрөг сэтгэлийн үүднээс найдаж байгаагаа илэрхийлж байна.

Барсболд:

Залуучууд ардчиллын төлөө бүлгийг төлөөлж байгаа депутат Баярцогт сая уг хэллээ.

Ингээд депутатуудаас уг хэлэх асуудал үндсэндээ дуусч байх шиг байна. Асуулт, хариулт явуулбал яасан юм бэ? Асуух юм байвал асууж болох юм. Бид хариулахад бэлэн.

Энэ Их Хурлыг сурвалжлах үүрэгтэй "Үнэн" сониноос сууж байгаа сурвалжлагч байна.

Би бол өөрийнхөө ер нь ажигласан хэлбэрээр бичиж байгаа. Тухайлбал Бага Хурлаас оруулсан Их цаазын төсөлд бол

би талтай байдаг. Үүнийг бүрэн дэмжиж байдаг. Сэтгүүлчийнхээ хувьд бол ийм юм байгаа юм. Харин энэ хэвлэлийн бага хурлыг бол эвгүй байдалтай хийж байна гэж бодож байна. Жишээ нь, энэ бол сүржигнэсэн байдалтай, хэтэрхий улс төржсөн, энэ үйл ажиллагааг хагалж бутаргах гэсэн, МАХН-ын нэр хүндийг энэ далимд унагах гэсэн ийм хэнээрхлийн маягтай ийм хэвлэлийн бага хурал байна гэж ингэж бодож байна.

Нөгөө талаар тэр бичигний тухай ярьж байна. Ийм бичгийг бол аль ч ... ер нь тэгээд ийм ардчилал байдаг юм уу? Тэр хурал ч гэсэн ардчиллынхаа журмаар л явагдаж байгаа шүү дээ. Баярлалаа, болъё.

"Үг" сонины сурвалжлагч Өлзийсайхан: Би нэг, хоёр асуудал тавья гэж бодож байна. Тэгэхээр энэ Их Хурлын ажиллагаанд оролцож сууж байна. Тэгэхээр энд бие даасан депутатуудын бүлэг гэж байгаа. Энэ бүлгийн зорилго ямархуу байгаа юм бэ? Энэ бүрэлдэхүүнд ямар хүмүүс байгаа юм бэ? Энэ бүлгийн үйл ажиллагаа, их хурлын ажиллагаанд яаж нөлөөлж байна вэ? гэсэн нэг ийм асуулт байна.

Хоёрдугаар асуулт нь, Их Хурлын депутатуудынхдийлэнх олонхи нь МАХН-ын хэт хуучныг баримтлагч, нэг үгээр хэлбэл, большевик, цтанлинч тийм үзэл сурталтай ийм депутатууд эерчилд орж, буулт хийж, манай улсын Үндсэн тулгуур хуулийг батлах ямар ч чадваргүй гэдэг нь харагдаж байна. Тэгэхээр дараагийн асуулт юу вэ гэхээр Үндсэн хуулийн, одоогийн хүчин төгөлдөр байгаа Үндсэн хуульдаа нэмэлт өөрчлөлт, шинэ сонгууль хийх асуудал тавигдаж болзошгүй юу гэсэн ийм асуулт байгаа юм, үүнийг Барсболд гуайд хандаж тавьж байгаа асуулт юм.

Р. Барсболд: Эхний асуултын талаар надаас асуух биш яг энэ бие даасан гэдэг бүлгийнхнээс асуувал зүгээр байсан байх л даа.

Хоёрдахь асуудал бол сонгууль ер нь тэртэй, тэргүй явагдана шүү дээ.

Шинээр сонгох болно, сонгууль ч явагдана, тогтолцоонд энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа төслийн дагуу энэ төсөл батлагдана байх гэж бид их найдаж байгаа. Энэ найдвар алдагдаагүй. Тийм мухардмал байдалд орчихлоо, одоо яахын аргагүй гэсэн ийм үгнээс жишээ нь сонгуулийн талын асуудлыг өнөөдөр бид би хувьдаа авч ярилцаж байгаа биш шүү дээ. Сонгууль болох нь болно. Ийм л байна.

"Үнэн" сонины сурвалжлагчийн хэлсэн зүйлд би саналаа хэлбэ гэж бодож байна. Би аль ч намын гишүүн биш учраас аль нэгэн нам байр сууриа хэлж байна гэж бодохгүй байх. Тийм учраас манай хэвлэлийн бага хурлыг шүүмжилж байх шиг байна.

Ардчилсан эвсэл бүлэг, хэдийгээр бүлэг, Үндсэн хуулийн зарчмын гол асуудлаар санал бүрэн нийлсэн, янз бүрийн намын гишүүд, нам бусчуудын бусад депутатуудаас бүрэлдсэн бүлэг боловч, бидний анхны тохиролцсон нийт депутатуудад мэдээлсэн, энэ мэдээллээр бол намууд хэдийгээр намуудын гишүүн депутатууд энэ бүлэгт нэгдсэн ч гэсэн намууд өөр өөрийнхөө нам орон нутгийн бүлгүүдтэй манай энэ бүлэгт оролцож байгаа улсууд харьяалагдаж, тэндээ бие даасан бодлогоо явуулна. Манай бүлгийн юунд тэгж орж явахгүй, ийм учраас намуудын төлөөлөгч, янз бүрийн байр сууриа хэлэх байхаа гэж бодож байна.

Хэвлэлийн бага хурлын хувьд бол бид энэ улс төрийн хэнээр-хэл буй болгоё гэж ингэж зорилго тавиагүй, ерөөсөө манай ардчилсан эвслийн бүлэг маань эвсэлдүүлэх, зөвшилцүүлэх ийм зорилготой бүлэг. Энэ чиглэлээрээ Их Хурлын хуралдааны явцад хэд хэдэн зөвшилцүүлэх, эвсэлдүүлэх ийм саналыг Их хуралд оруулсан. Харамсалтай нь зарим нь хүлээж аваагүй, зарим нь явц дунд хэлэлцэж шийдвэрлэх байхаа гэж бодож байна. Эрхэм сэтгүүлчдийг уур унтуугүй, бидэнтэй илэн далангүй сайхан ярилцахыг уриалж байна.

Би "Үг" сонины сурвалжлагчийн тавьсан асуултанд хариулья. Над дээр бас нэг асуулт бичгээр ирсэн байна.

Э.Бат-Үүлл/МОНХ:

Тэгэхээр "ҮГ" сонины түргүүний сурвалжлагч асуулаа л даа. Хуучин Үндсэн хуульдаа өөрчлөлт хийгээд, шинэ сонгууль явуулах замаар асуудлыг шийдэж болох уу гэж асуусан гэж би ойлгосон.

Тэгэхээр одоо Ардын Их Хурлын хуралдаанаар Үндсэн хууль бид нар хэлэлцэж байна.Энэ Үндсэн хууль бол МОНХ анх гарч ирснээс хойш 2 жил гаруй хугацаанд явуулсан улс төрийн тэмцлийн гол агуулга байсан.Энэ Үндсэн хууль.Тэгэхээр хэрвээ энэ асуудлыг Ардын Их Хурлын хуралдаан маш эрүүл саруул бу-саар хэлэлцэж, тэгээд ямар нэгэн тийм болчимгүй үр дагаварт хүргэх юм бол ,энэ зүгээр нэг Үндсэн хуулийн асуудал биш, монголын нийгмийн хамгийн аюултай хямралын ийм байдлыг бий болгоно.Улс төр, эдийн засаг, бүх хүрээнд.Энэ нийгмийн оюун санааны хүрээнд ч гэсэн аюултай хямралт байдлыг бий болгоно.

Тэгэхээр тийм уршигтай байдалд хүргэхээсээ өмнө нэгэнт өнөөдрийн энэ Ардын Их Хурлын депутатууд, энэ шинэ Үндсэн хуулийн үзэл санааг ойлгохгүй, нэн ялангуяа бид шинэ нийгэм байгуулах гэж байгаа тэр нийгмийн гэрээний агуулгыг ойлгохгүйгээр, хуучин үзэл баримтлалаараа бүхэнд хандаж, ингэс-нээрээ их уршигтай байдал бий болгоход хүрэх юм бол бид ийм эвгүй зүйл хийж байхаар, Үндсэн хуулийнхаа нэмэлтийн хуульд ч юм уу, Үндсэн хуучин хуулиндаа өөрчлөлт хийж, зохих өөрчлөлт хийж, тэгээд яаралтай ... /"а" тал дуусав/ ...ингэж бид үзсэн юм.

Энд хоёр дахь асуулт нь ингэж байгаа юм.Ардын Их Хурлын чуулган дээр яг ямар асуудлаар, тухайлбал улсын нэрийн асуудлаар ямар нэрийг тухайлбал Монгол улс нэрийг яагаад зөвшөөрөхгүй байгаа тухай жаахан тодруулж хэлж өгнө үү? гэсэн байна, ҮГ сонины сурвалжлагч,

Тэгэхээр уучлаарай, нэн ялангуяа хуучны байр суурь баримталж, өөрөөр хэлбэл БНМАУ гэсэн тэр нэрийн төлөө байж байгаа депутатуудынх нь өөрсдийнх нь хүсэлтээр би үүнийг тодорхой тайлбарлаж чадахгүй байна гэж хэлмээр байна. Тэдний өөрсдийнх нь хүсэлтээр, үүнийг би тодорхой тайлбарлаж чадахгүй ээ. Шаардлагатай үед бол тодорхой тайлбарлах байхаа.

Их Хурал дээр байгаа аливаа бүлгүүд бол бүлэг байгуулагдсанаа ямар хүмүүс бүлэгт орж байгаагаа бүх депутатуудад тодорхой болгосон. Харин бие даасан депутатуудын бүлэгт хэн орж байгаа, яаж энэ бүлэг ажиллаж байгаа нь бидэнд мэдэгдэхгүй байгаа учраас энэ талаар хариулахад миний хувьд төвөгтэй.

Нөгөө талаар үнэн сонины сурвалжлагчийн энд үзүүлж байгаа аягийг би асуулт гэж ойлгож байна. Харамсалтай нь Их Хурлын танхим ч иймэрхүү байдлаар асуудалд хандаж байгаа хүмүүс цөөнгүй байгаа. Их Хурлын ажиллагаанд саадтай байгаа юм. Депутат бид нар өнөөдөр ардчилсан эрхийнхээ дагуу, хэвлэлийн хурлаа хийж байна. Үүнийг бол хэнээрхэл гэж дүгнэж болохгүй. Тэр тусмаа ийм дүгнэлтэнд хэвлэлийн хурлыг мэдэх ёстой сэтгүүлч хүн тэгж хэлсэн нь тун тоогүй байна. Сэтгүүлч хүн ийм соёлгүй байдаг нь депутат бидний сэтгэл төдийгүй, энд сууж байгаа сэтгүүлч та бүхэнд ч сонин санагдаж байгаа байхаа.

"ҮНЭН" сонины сурвалжлагч:

Тэгэхээр энэ хэвлэлийн бага хурал хурлыг цаашид үргэлжлүүлэхэд үр дүн өгөх үү, үгүй юу гэдэг асуулт байна шүү дээ. Би үүнийг асуух гэсэн юм. Тэгээд хэлүүлэхгүй болохоор чинь тал талаас хашгичаад байна шүү дээ. Асуултыг тайлбартай тавьдаг ч бас сэтгүүл зүйн учир бол бий шүү дээ.

Р. Барсболд: Энэ Бага Хурал Ардын Их Хурлын хуралдааныг цаашид үргэлжлүүлэхэд ямар нэгэн саад учруулахгүй гэж би хувьдаа үзэж байна. Найдвар огт алдраагүй, цаашид ажиллах бололцоо байгаа, энд байгаа нам, бүлгийнхнийг төлөөлсөн

депутатуудад янз бүрийн санаа бодол байгаа юм байна билээ. Зарим нэгийг нь бид сонссон, би хувьдаа сонссон. Ингээд цаашид ажиллах боломж бий гэж би хувьдаа үзэж байна. Энэ хэвлэлийн бага хурлыг хийх эрх хэнд ч байгаа шүү дээ, депутатуудад байгаа. Энэ эвсэл бол 100 орчим депутатуудыг бас ямар нэгэн тал, байдлаар төлөөлж байгаа юм билээ л дээ. Энэ бол явцуу нэгэн бүлгийнхэн биш, энэ бүлэгт оролцож байгаа нам, бүлгийнхнийг аваад үзэх юм бол ер нь нэлээн олон өргөн үзэл санаатай, янз бүрийн санаатай, өөр хоорондоо ч бас зарим асуудлаар ялгаатай бид ч гэсэн өөрсдийнхөө эвслийн хуралдааныг ярилцаагыг явуулахдаа бас л ярилцаж байж, нэлээн зарим талаар маргалдаж байж, гэхдээ бие биеийгээ ойлголцохыг л боддог юм. Зөвшилцөх арга боломж бий гэж үзэж байна.

Р. Хатанбаатар: Энэ дээр би ганц зүйл хэлье. Бидэнтэй адилхан шинэ хуучны зааг дээр байгаа шилжилтийн үед байгаа хуучин социалист гэгдэж байсан зүүн европын хэд хэдэн оронд парламентын хямрал болж, урьдах асуудлаа шийдэж чадахгүйгээр парламент нь тарж, дахин сонгууль явуулж, ингэж улс орны өмнө тулгарсан асуудлыг шийдэж байгаа. Тэгэхээр бидний өнөөдрийн гол зорилго бол зүүн европын энэ орнуудын тэр гашуун туршлагыг монгол оронд давтахгүй юмсан, ямар нэгэн байдлаар энэ Ардын Их Хурлын хуралдааныг хэвийн байдлаар явуулах юмсан, зөвшилдөөнд хүрэх юмсан гэдэг бодлынхоо үүднээс хийж байгаа хурал.

Иймээс ч би намын бүлгээс түрүүн тавьсан саналаа дахин энэ дээр тодруулан хэлье. Улс төрийн хүчнүүдийн зөвшилдөөн л өнөөдөр хойшлуулшгүй чухал зүйл болоод байна.

Хэвлэлийн бага хурал Их Хурлыг цааш нь амжилттай үргэлжлүүлж, тавьсан зорилтоо шийдвэрлэхэд тус болох уу гэж байна. Бид тус л болох зорилготойгоор хэвлэлийн бага хурал хийж байгаа юм. Тэгэхээр энэ нэгдүгээрт, хэвлэлийн бага хурал

маань энд оролцож байгаа депутатууд, хоёрдугаарт энэ хэвлэлийн бага хуралд оролцож сурвалжилж байгаа сэтгүүлч та бүхний, та бидний хамтын хурал юм. Тэгэхээр би энэ хэвлэлийн бага хурлын зорилго, дотор нь яригдсан зүйлийг эрхэм сэтгүүлчид, сурвалжлагчид та нар цааш нь үнэн байдлаар нь зөв мэдээлж Их Хурлыг амжилттай болгоход энэ хэвлэлийн бага хурал тус болох ёстой, тус болоосой гэсэн бидний зорилготой санал нэг байж, та бүхний тус ч гэсэн Их Хурлыг амжилттай болгоход бас их хэрэгтэй.

Р.Барсболд: Асуулт байна уу?

МОНГОЛЫН РАДИОГИЙН СУРВАЛЖЛАГЧ:

Надад хэдэн асуулт байнаа.

МОАН мухардмал байдалд орлоо гэсэн ийм дүгнэлтийг хийсэн байна. Түрүүн Зардыхан гуайн хэлснээс ч, зарим улсуудын хэлснээс мухардмал байдалд ороогүй ч юм шиг. Энэ эвслүүд цөмөөрөө нэг тиймэрхүү уг хэлж байна уу? ганцхан Бага Хурлын Ардчилсан нам тэгж хэлж байна уу?

Хоёрдугаарт, депутат Зоригоос асууя. Нэлээн хэдэн буулт хийлээ гэсэн, ямар ямар буулт хийсэн бэ?

Гуравдугаарт, өөр сонгох байдалд хүрч магадгүй гэсэн тэр нь юу юм болоо?

К.Зардыхан: Эхний асуулт Их Хуралд бүхэлдээ мухардмал байдалд орсон гэдэг дүгнэлт нийт бүлгийн дүгнэлт үү? эсвэл МОАН-ын дүгнэлт үү? гэж байна.

Энэ бол нийт бүлгийн дүгнэлт биш.

Э.Бат-Бүл: Уг нь би бол түрүүн мухардмал байдалд орлоо гэдгээ тайлбарласан. Би нэг л зүйлийг хэлмээр байна. Яг асуудлыг шийдвэрлэх үе шатан дээр өөрөөр хэлбэл нэлээн их хэмжээний хугацааны дараа асуудлаа яг шийдэх гэж Ардын Их

зааланд орж ирсний дараа Даш-Ёндон дарга БНМАУ гэдэг нэр дээрээ хатуу зогсоно гэсэн ийм мэдэгдэл хийсэн. Энэ бол МАХН-ын бүлгийн байр суурь гэж. Бид бол уг нь бодохдоо ядагдаа бидэнтэй жишээ нь асуудлыг зөвлөж, ярилцахгүй, санал бодлоо солилцохгүй ийм шууд ирцээр тавьж байгаа юм бол энэ бол ерөөсөө хуралдааныг гарцгүй байдалд оруулах гэсэн, мэдээжийн энэ чинь их хариуцлагатай, том намын удирдагч хүн ингэж асуудал тавьж байна шүү дээ. Тэгэхээр үүнээс ийм байдалд гарцаагүй оржээ гэдэг шууд бидэнд дүгнэлт хийх нь хангалттай болсон л доо.

Тэгэхээр би дахиад хэлье. МАХН-ын бүлгийн байр суурь ямар байхаас мухардалд орох уу, уггүй юу гэдэг асуудал шийдэгдэнэ гэж бид үзэж байгаа юм.

С.Зориг:

Ямар буулт хийсэн бэ гэсэн асуултыг тавьж байна. Тэнд ерөнхийлөгч дээр зөвлөлдье гэж санал гаргаад, тэнд бүх намын бүлгүүд, депутатын бүлгийн дарга нар цуглараад зөвшилцөөд, Монгол улсын Үндсэн хууль гэсэн аль аль талаасаа буулт хийсэн ийм хувилбарыг тохирсон. Тэгээд ороход үүнийг батлаагүй. Шууд эсэргүүцсэн. МАХН-ын хуучинсаг үзэлтэй депутатууд эсэргүүцэж, өндөр төвшинд Ерөнхийлөгч өөрөө санаачилга гаргаад, бүх депутатуудын бүлгийн дарга нар зөвшсөн байхад, үүнийг түрүүчийн хэлдгээр тэр нууц удирдагчид нь зохион байгуулаад үүнийг унагаасан.

Мөн Монгол улс, БНМАУ гэдгийн дундын хэлбэрийг сонгох асуудлыг ярьсан боловч бас хүлээж аваагүй. Шалтгааныг нь ерөөсөө олохгүй байсан. Яагаад гэхээр жаахан юм боддог, юманд хариуцлагатай ханддаг улс бол аливаа асуудлыг шийдэхдээ түүний нотолгоогийг нь эх үүсвэр болгож авч үзэх хэрэгтэй.

Гэтэл МАХН-ын тэргүүлэгчдээс тараас^{ад} энэ удирдамжийг өнөөдөр би хараад шалтгааныг нь оллоо. Тэнд бол зөвхөн манай нам ийм

байр суурьтай, заавал орох ёстой, бусад намуудынх бол үүнтэй эсрэг байр сууриуд байна гэдгийг бичээд, ямар ч үндэслэл нотолгоог депутатуудад хүргэж өгөөгүй байна. Гэтэл бид нар чуулган эхэлсний дараа бол парламентын бүлгэмээс, мөн ЧХН, МСДН, БН нам, МоАН, МУЦН бол тайлбартай, нотолгоотой ийм ийм заалтууд нь ийм учраас өөрчлөх шаардлагатай гэдэг материал ирүүлсэн. Энэ нь нэг нь агуулгын талаасаа хандаж байгаа, нөгөө дэх нь зөвхөн явцуу суртлын талаас тулгаж байгаа хоёрын ялгаа бол гарч ирж байна. Тийм учраас энэ мухардмал байдалд орохоос өөр аргагүй юм байна л даа.


Өөр замын асуудал ярьж байна. Өөр замын асуудлыг бол саяны чуулган завсарлахаас өмнө гол гол намууд илэрхийлсэн, МСДН, улс төрийн дугуй ширээний ярилцлагад шууд орож асуудал, МоАН бол Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулинд өөрчлөлт оруулах, манай ЧХН, бүгд найрамдах нам хоёрын эвслээс бол Ерөнхийлөгчтэй шууд ярилцлагад орж, дараагийн сонгуулийг товлох асуудал, дараагийн сонгууль болтол энэ улсыг удирдах ямар хэлбэр байж болох вэ гэдэг хоёр асуудлаар яриа хэлэлцээ хийх ийм саналыг дэвшүүлсэн.

Үүнээс гадна Үндсэн хуулинд заагдсан намуудын тухай хуулинд заагдсан улс төрийн тэмцлийн аргууд бий. Үндсэн хуулийн хүрээнд хэрэгжүүлж болохоор. Энэ аргуудыг бас хэрэглэх бололцоо бий.

Р. Барсболд: Өөр асуулт байна уу?

21 цагаас хуралдаан үргэлжлэх ёстой юм байна. Цаг бага үлдлээ. Ингээд бид явж дараагийнхаа ажилд бэлтгэвэл яасан юм бэ? Та нарт баярлалаа. Цаашид бас уулзах байх.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Д. ЧУЛУУНЦЭЦЭГ

Л. Батжаргал /296-р тойргийн депутат/ -Монголын ард түмэн гэсэн үгээ бид нэгэнт хассан учраас БНМАУ-ын иргэн бид гэж тунхаглая.

Ж. Уртнасан -Анхааралтай суул даа.

Б. Буягмөнх /177-р тойргийн депутат/ -Бага Хурлынхнаас асуух хоёр зүйл байна. Нэгдүгээрт удиртгал хэсгийг ямар учраас оруулсан юм бэ? Энэ нь ерөнхий хураангуй зүйл байгаа шүү, ямар зориулалттай юм бэ гэдгийн учрыг олохгүй байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт I-р зүйлийн I-д Монгол улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт Бүгд Найрамдах Улс мөн гэсэн байгаа юм. Бүгд Найрамдах гэдгийг ямар учраас оруулсан юм бэ? Улс гэж хэлж болсонгүй юу.

Ж. Уртнасан -Бага Хурлын эрхэм дарга тайван байгаар ай, Бид хэлэлцүүлгээ явуулж байна.

Р. Гончигдорж -Товчхон хэлбэр, Монгол улсын Их цаазын урьдчилсан удиртгал хэсэг бол бид Монгол улсынхаа Үндсэн хуулийг батлахдаа монголын ард түмэн бид юуг эрхэмлэж, хүндэтгэж, мөн юугаа уламжлаж, хүндэтгэж, дээдлэх вэ гэдгээ илэрхийлэн хэлээд, дараа нь бид Үндсэн хуулиа шинэ Үндсэн хуультай улс орон боллоо гэдгээ даяар олондоо хэлж байгаа ийм л агуулгыг илэрхийлж байгаа юм.

Хоёрдугаар зүйлд БНУ гэдэг нь төрийн удирдлагын хэлбэр Бүгд Найрамдах юм гэдгийг би хэлж байгаа юм.

Бид ард түмэн гэж тодорхой хэлж байна шүү дээ. Ардын тухай тайлбарыг бид олон удаа ярьцгаалаа шүү дээ. Тэр нь үе, үед хэдэн бүлгээр багтаж яригдаж байгаа шүү дээ.

Э.Бат-Үүл/52-р тойргийн депутат/ -Би товчхон ярья.

Дараа нь Үндсэн хуулийг олон улсын хэмжээнд уншиж танилцахад би ийм зүйлийг гайхаад байгаа юм. Хэдэн улсын Үндсэн хуулийг харахад иргэний нийгэм гэдэг нь философчдийн шинжлэх ухааны бүтээлд хэрэглэж байсан нэр томъёо, өөрөөр хэлбэл энэ нь шинжлэх ухааны нэр томъёо гэж.

Бид Иргэний нийгэм гэдэг шинжлэх ухааны томъёог бид үүндээ оруулчихлаа л даа. Үндсэн хууль гэсэн өөрийн гэрээний бичигт оруулчихлаа шүү дээ. Гэтэл үнэхээр Иргэний нийгэм үү, үгүй юу гэдгийг Үндсэн хууль өөрөө хэлж өгдөг. Хүний эрх, эрх чөлөө, ардчилал, төрийн тогтолцоо энэ бүх зүйлийг цогцолбор нь өөрөө иргэний нийгмийн асуудлыг тавьж өгдөг. Түүнээс би өнөөдөр яг иргэний нийгэм гэвэл чухам ~~алий~~ **гэсэн** хатуу Америк ч гэсэн иргэний нийгэм хөгжүүлж байгаа, мөн Англид, Япон ч тэгж байгаа шүү дээ, энэ чинь өөр, өөр юм байгаа шүү дээ. Тэхээр шинжлэх ухааны нэр томъёог энд оруулчихвал сүүлд биднийг гайхаад байх болно, яагаад ингэж чихдэг юм гэнэ. Би тэр талаар асуух гэсэн юм.

Р.Гончигдорж -Үүн дээр тодорхой байгаа шүү дээ. Эх орнодоо иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэх зорилгоор гэж. Тэхээр бид өнөөдөр байгаа нийгмээ иргэний нийгэм гэж хэлэхгүй байна. Үүнийг иргэний нийгэм болгон цогцлон хөгжүүлэх гэдгээ эрхэм депутат Бат-Үүл өөрөө тайлбар хийлээ. Үнэхээр энд гарсан хүний, иргэний эрх чөлөө, төр, иргэн хоёрын хоорондын харилцан үүрэг эрхүүд, энэ бүхэн тэр утгаар нь ойлгогдох утгаар үүнийг бүрэн хэрэгжүүлэх, ийм цогцлох зорилгоор гэж байгаа шүү дээ. Тийм учраас тантай саналнэг байна. Үүнийгээ энд даяар олондоо зарлан тунхаглахдаа гэсэн зорилгыг бид тавьж байна гэдгийг хэллээ гэсэн үг юм.

Ж.Уртнасан -За баярлалаа, иргэний нийгэм гэдгийн хувьд Ерөнхийлөгчийн илтгэл дээр тодорхой байгаа. Депутатууд, саяны асуусан хүмүүс түүнийг сайн хараарай!

3.

Бид анхныхаа баярлууштай шийдлийг Үндсэн хуулийн удиртгал хэсгийг батлах, нэгдүгээр хэлэлцүүлгээр, ийм санал оруулж байна. Нэгдүгээр хэлэлцүүлгээр зөвшөөрөх.

Удиртгал хэсгийг зөвшөөрчихөөд санал хураалт явууллаа.

За баярлалаа, удиртгал хэсэгт санал өгсөн 380 депутатуудын 379 хүн буюу 98 хувь нь зөвшөөрч байна. 3 хувь буюу 1 хүн татгалзаж, 3 хувь буюу 1 хүн түдгэлзлээ.

Эрхэм депутатууд аа! та бид өнөөдөр нэлээд их ачаалалттай, бас их хүнд өдрийг өнгөрөөл өө.

Нэгдүгээр зүйл дээр 7 хэсэгт үг, үсгийн редакц хийх зүйл ирсэн байна. Үүнийг товчхон сонсоод, зарчмын гэж үзэх үү, үгүй юу гэсэн санал хураалт явуулаад, хэрэв зарчмын гэж үзвэл оруулаад таслая. Тэгээд I-р зүйлээрээ бид өнөөдрийнхээ хуралдааныг завсарлая. Бидэнд өчигдөр, өнөөдөр хөдөлмөрчдөөс ирсэн мэдээлэл, захидлыг уншаагүй ажил үлдэж байна. Мөн гадаа өлсөглөн зарласан хүмүүс, өндөр настны тухай мэдээлэл хийх хэрэгтэй байна. Тийм учраас I-р зүйлийн энэ хэсгийг би уншиж сонсоё. Анхааралтай байна уу?

Тэгш байдал гэсэн үгийг хасья гэсэн байна. Энэ дээр гурван депутатын санал байгаа юм. Тэгш байдал гэдэг нь зарчмын асуудал мөн үү. Тэгш байдал гэдэг үг нь зарчмын асуудал гэж үзэх үү, санал хураалт явж байна.

Үүнийг зарчмын гэж үзэхгүй байна. Цаашаа явъя. Уучлаарай, депутатууд аа! санал хураалтыг дахин явуулахгүй бол 280 буюу дөнгөж 66 хувь нь оролцсон байна. Анхааралтай байхыг хүсэж байна. Томъёолол тэгш байдал гэсэн үгийг хасна. Уучлаарай, тэгш байдал гэдгийг хасья гэсэн санал зарчмын асуудал мөн үү гэдгээр санал хураая. Зарчмын асуудал мөн гэвэл зөвшөөрснийг, биш гэвэл татгалзсныг, ойлгохгүй бол түдгэлзснийг дараад явчихна шүү дээ.

Олонхийн саналыг авч чадахгүй байна. Депутатууд аа! анхааралтай байгаарай, бид шуугихгүй байвал хурдтай явж болно шүү.

4.

Сүлдэн дээр ажлын хэсэг томъёо гэсэн санал орж ирж байна. Энэ зарчмын санал мөн үү.

Ж.Гомбожав -Даргаа, сүлдэн дээр манай хороо ажлын хэсэг байгуулая гэж бид ярьж байгаа шүү дээ.

Ж.Уртнасан -Үүнийг бид зарчмын санал гэж үзвэл цаашаа явчихна. Томъёолол сүлдэн дээр ажлын хэсэг томилох гэдэг нь зарчмын асуудал мөн үү.

81 хувь буюу 167 хүн зөвшөөрч байна.Уучлаарай, бид ядарч байна гэж хэлэхэд хаашаа юм, жаахан санаа үймэрч байх шиг байна. Санал өгөх депутатуудын цөөнх өглөө. Анхаарлаа төвлөрүүлэхийг хүсч байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

У.Салрисуу

Ц.БАЯРМАА

Бичээч С.ТУУЛ

Арлын Их Хурлын 39 дүгээр тойргийн депутат Д.Ламжав:—
Дарга аа, нэгдүгээр зүйлээ дуусгаж сайхан болгож авчихаад
өөр юм ярья.

Ж.Уртнасан:—Нэгдүгээр зүйлийг зарчмын хувьд зөвшөөрч яая
гэдгээрээ санал хураалт явуулъя гэж байна уу?

Та бол гурван санал хэлж байна уу? Их засаг Үндсэн хууль
мөн гэдэг, улсын тусгаар тогтнолыг хамгаалах гэсэн үг, энэ
гурав дээр тогтоё.

За уучлаарай дөрвөн зүйлийг та бүхэнд танилцуулъя. Нэгдүгээр
зүйл дээр энэ Их засаг хууль бол Монголын манай Үндсэн хууль
мөн гэсэн ийм томъёолол байна. Энүүгээр санал хураалт явуулах
хэрэг байна уу? Зарчмын асуудал мөн үү?

—Автор хэлэхгүй юу?

Ж.Уртнасан:—Их засаг Монголын Үндсэн хууль мөн гэсэн нэмэлт
хийе гэж байна. Энэнийг зарчмын гэж үзэх үү? Санал хураалт
явуулчихъя. Нэгдүгээр зүйл дээр хүмүүс санал гаргаад байхгүй юу.
Депутатууд, Тэрийг бид зарчмын гэж үзвэл энд олонхийн саналаар
редакцийн группт шилжүүлбэ л дээ. Депутатууд ойлгосон болов уу?
Бас л энэ хүмүүс дутуу хураалгачих болов уу гэж санаа зовж
байна. Их засаг Үндсэн хууль мөн гэсэн ийм томъёоллыг нэмье
гэсэн.

Арлын Их Хурлын 132 дугаар тойргийн депутат
С.Чулдунбаатар:

—Би эндүүрээд саналаа буруу хураалгачихлаа. Дарга аа уучлаарай.
Тэгээд дахиж хураалгахгүй бол сая сайн ойлгосонгүй ээ. Энэ
хавиар нэлээд хэдэн улс бас тэгсэн бололтой байна.

Ж.Уртнасан:—Их засаг хуулийг Монголын Үндсэн хууль мөн
гэсэн томъёолол нэмж оруулъя гэсэн. 192 хүн буюу 52 хувь нь

2.

зөвшөөрч байна.Татгалзсан 162.44 хувь.Түдгэлзсэн 14 хүн буюу 4 хуви байна.

За санал хураалт явуулъя. За орохгүй байна.

Гуравдугаар саналыг сонсоорой.Энхийг эрхэмлэн бусад улсын дотоод хэрэгт үл оролцох гэсэн үг нэмье гэж байна.Энэ зарчмын асуудал мөн үү?

Энхийг эрхэмлэн бусдын дотоод хэрэгт үл оролцох гэдэг энэ томъёолол зарчмын асуудал мөн үү гэдгээр санал хураалт явуулах гэж байна.Гэхдээ манай хуулийн зөвлөхүүд 10-ын нэг дээр байгаа шүү гэдгийг сануулж байна.За тэгвэл би заалын уур амьсгалыг мэдэрлээ.Орхиж байна.

Шударга ёс, ардчилсан ёс гэдгийг хасах гэж байна. Найруулгын за баярлалаа.

Үндэстэн,ард,ястан гэх гэсэн нэг ийм томъёолол байна. За санал хураалт явуулъя.Томъёоллыг сонсоорой.Үндэстэн,ард ястан гэх.Зарчмын гэж үзвэл оруулна.

За зарчмын гэж үзэхгүй байна.

Сүүлчийн томъёолол байна.Монголын ард түмний эрх ашгийг эрхэмлэх, хуулийг чанд сахих гэдгийг ардчилсан ёс гэдгийн өмнө оруулах.Энэнийг зарчмын асуудал гэж үзэх үү?

За найруулгын.

Одоо ингээд нэгдүгээр зүйлийн санал хураалт явуулъя. Нэгдүгээр зүйл дээр санал хураалт явуулчихъя. Хоёрхон хүний үгийг сонсоё.

Ардын Их Хурлын 12 дугаар тойргийн депутат
Г.Очирбат:
-Тэтгэхлээр зэрэг саян нэгдүгээр зүйлийн эхэнд болбол

Монголын ард түмний эрх ашгийг эрхэмлэх гэдэг уг заавал баймаар байгаа юм. Энэ дотор бид нар юуг тодорхойлж байна гэхлээр манай төрийн үндсэн үйл ажиллагааны үндсэн зарчим нь юу юм бэ гэж. Тэгэхлээр ард түмнийхээ эрх ашгийг эрхэмлэх гэдэг ийм зорилгогүй төр байна гэж байх ёсгүй. Гэтэл сая хурлын дарга маань энэнийг зүгээр уншаад, энэ зарчмын санал мөн үү биш үү гэдгийг ч асуулгасангүй. Зүгээр одоо яачихлаа шүү дээ. Энэн дээр хэний ч буруу биш, би энэнтэй холбогдуулан, нэгдүгээрт, энэнийг та бүхэн тунгааж бодож үзээчээ. Яагаад гэвэл манай төр бол ард түмнээ эрхэмлэж байх ийм төр өө гэсэн ийм санаа энэн дотор баймаар байгаа юм. Тэр санаа энэн дотор ерөөсөө байхгүй. Нэгдүгээрт энэ байна. Тэр эхэнд нь Монголын ард түмний эрх ашгийг эрхэмлэх гэж би бол бичсэн. Яах вэ найруулгаар өөр маягаар дээдлэх барих гэж хэлдэг юм уу, дараа нь тэр хууль дээдлэх гэсэн үг байж байгаа юм аа. Тийм учраас эрхэмлэх гэдэг үг болмоор юм шиг байгаа юм.

Нэгэнт босч ирснээс зүгээр нэг горимын санал хэлье. Яагаад гэвэл энэ улсууд бас нэлээн удаан хугацаанд бодоод нэлээн зарчмын нэг үг ч байлаа гэсэн, хоёр үг ч байлаа гэсэн зарчмын саналууд хэлээд байна. Бид нар бол өнөөдөр үймж шуугиад одоо их орой болчихсон, ингээд түргэн зуур нэг юм хэлэхлээр энэ хэрэгтэй, үгүй гэдгийг тунгааж чадахгүйгээр бид нар одоо гар өргөөд байна аа. Энэ бол Үндсэн хууль. Зүгээр ямар нэгэн хурлын тогтоол биш. Тэгэхлээр энэ улсууд зарчмын гэсэн саналаа бичээд манай хуулийн төсөл дээр ажиллах хороо, ажлын группт өгчихье. Тэр нөхдүүд тэндээ хоорондоо зөвлөж ярьж байгаад үгүй энэ нээрээ зарчмын юм байна уу, энүүгээр өр нь санал хураалгаж тайлбартай ярих уу гэж ингэж жаахан шийтмээр байна. Тэгэхгүй бол энэ аргаар явах юм бол энэ дараа нь толгой сөргэлэн үедээ уншаад хоёрдугаар хэлэлцүүлэг дээр нэлээн яриа хөөрөө болчихож мэдэх болов уу гэж бодож байна.

Ардын Их Хурлын 86 дугаар тойргийн депутат Д. Харжаубай:-- Тэгэхээр энд бол ийм байгаа юм л даа. Үндэсний гэсэн байгаа юм л даа. Энэнийг үндэстний гэж хэлэхэд яагаад буруу байдаг

юм бэ? Үндэстэн гэж хэлэхэд.Одоо түрүүнээс нааш бол бүх юм тодорхой шүү дээ.Би цаашаа тайлбарлаад ярих хэрэггүй байх. Үндэстний.Энүүгээр нэг санал хураачихвал ямар вэ?

Ж.Уртнасан:--Бага Хурлынхны тайлбар сонсох нь зүйтэй байх.

Р.Гэнчигдорж:--Энэ талаар уучлал хүсье.рЭнд "т" үсэг хаясан байна.

Ж.Уртнасан:--Энэ техникийн алдаа байсныг залруулж байна.

Одоо бидэнд цаг их бага үлцэж байна.Бид өчигдөр,өнөөдөр хоёр мэдээлэл сонсоогүй, гадаа бас, энэ танхимын уур амьсгалаас гадна гадаа болж байгаа уур амьсгалыг бид бас мэдэрч зайлшгүй хариу өгөх шаардлагатай юмнууд байна.Одоо орлогч дарга Батбаяр хөдөлмөрчдийн санал мэдээллийг сонсоно.

Бас л дутуу орхих шахлаа.Уучлаарай.Энэнийг уншихын өмнө нэгдүгээр зүйлийг саян хэлсэн энэ редакцийн засвар хийгээд одоо ингээд хоёрдугаар хэлэлцүүлэгт бэлэн болгоё.Нэгдүгээр зүйлээ баталъя.

Дахиад анхааруулъя.Нэгдүгээр зүйлийг сая та бид зарчмын гэсэн асуудлуудаас аваад ингэчихлээ.Одоо, тэр Очирбат гуайн саналыг манай зөвлөхүүд хэлсэн.Энэ бол зарчмын асуудал биш ээ. Манай хуулийн зорилго гэсэн.Манай хуулийн зөвлөхүүдтэй Очирбат гуай та нэг зөвлөхгүй юу.

Анхаараарай.Санал хураахад бэлэн болсон байх.Нэгдүгээр зүйлийг баталъя.За баярлалаа.97 хувь нь зөвшөөрч байна. Татгалзсан 9 хүн 3 хувь.Түдгэлзсэн байхгүй байна.335 депутат саналаа өгчээ.Баярлалаа.

Н.Батбаяр:--Эрхэм хүндэт депутатууд аа.Цаг орой болсон, та бүхнийг ядарсныг харгалзан энэ зүйлийг аль болох хурдан

5.

бөгөөд тоймтой уншъя.


Ардын Их Хурлын хуралдааны нэр дээр байгууллага, хамт олон, хувь хүнээс бичгээр 43, цахилгаанаар 5, утсаар 29, хүлээн авах байраар 12 хүн II-р сарын 20-ны өдөр ирж санал хүсэлтээ илэрхийлжээ. Налайхын районы 10 дугаар хорооны иргэн Осоржамаа - Ардын Их Хурлын хуралдааны ажилд амжилт хүсье. Төрцөө итгэж бүхнээ зориулж явдаг иргэний хувьд итгэлийг дааж цаашид ч хүлээж чадах төрийн сүлд, далбаа байгаасай гэж хандив оруулахад бэлэн байна.

Өнөөдөр нийт ард түмнийг хамарсан зөрчил байхгүй, харин сэхээтэн, цөөнх хэсгийн дотор зөрчил байна гэдгийг Их Хуралдаа анхаарч үзэхийг хүсье. Шинжлэх ухааны академийн химийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Баатарсүрэн - секторын 15 ажилтнаа төлөөлж, -хуралдаан найм дахь өдрөө хуралдаад үр дүн гарахгүй байна. Хуралдаанаар далимдуулж төрийн эргэлт хийх гэсэн хүч депутатуудын дотор байна гэж бид үзэж байна. Эдийн засгийн бэрхшээлийг ардчилалтай холбож үзэх хүч депутатуудын дотор байна. Улс төрийн хурцалмал байдал үүсэхэд бэлэн байна гэдгийг депутатууд ойлгох хэрэгтэй. Хэрэв зөрчил үүсвэл хуучинсаг үзэлтэй депутатууд хариуцлагыг хүлээнэ шүү гэдгийг мэдэгцэж байна.

Бид депутат Балдоржийн гаргасан саналыг дэмжиж байна гэжээ. Ажилчны районы 2 дугаар хорооны иргэн Мандал - эрхэм депутатууд минь битгий маргаач, та нарыг маргаад байхад ард түмэн бид чинь туйлдаж, бухимдаж, үймж байна гэдгийг ойлгоочээ. Их цааз хуулиа л хэлэлцэж батлаач. Ард түмний нэр барьж тулгаж яриад байгаа депутатуудаар үг хэлүүлэхгүй байсан ч болох юм.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ

НИЙДСЭН



Бичээч Л.Хорлоо

П.ТӨМӨРБААТАР

— (санхүүгээр) районы 30 дугаар хорооны өндөр настан Доржсүрэн, Батмөнх нарын 3 хун үр дүнгүй их ярьж байна, депутатууд өндөр үнэтэй байранд байрлаж, хамгийн сайхан хоол идэж, их зардал гаргаж байна.

Найрамдлын районы III хорооны иргэн Батжаргал, Депутатууд хурлын ажиллагаанд маш хариуцлагагүй хандаж, оролцож байгаад хүмүүс их бухимдаж, хөдөлгөөнд орох үйл ажиллагаа явуулах шинжтэй байгааг анхаарах.

Октябрийн районы 5 -р хорооны иргэн Доржсүрэн: —Депутатууд та бүхэн Монгол улсын түүхэнд анх удаагаа ардчилсан үндсэн хууль батлах гэж байгаа хариуцлагатай үед ардчилсан байр сууринаас хандаж, маргаан үүсгэж байгаа хэдэн зүйл дээрээ харилцан тогтолцохыг хүсье.

Октябрийн районы 33 дугаар хорооны иргэн Өнөрбилэг: —Улсын нэрийг Монгол улс, Бүгд найрамдах Монгол улс гэдгийн аль нэгээр өөрчлөн нэрлэх, төрийн бэлгэдэл сүлдийг өөрчлөх шаардлагатай, ард түмний хүсээд байгаа морийг сүлдэнд үлдээгээд өөрчлөх, ШУА-ын химийн хүрээлэнгийн ажилтан Баатарсүрэн: — Төрийн сүлдийг өөрчлөх, улсын нэрийг Монгол улс гэж нэрлэх, Парламентын I танхимтай байлгах. Монгол улсын Их сургуулийн багш Батсүрэн: — Соёмбыг авч үлдэж хэрэглэх хэрэгтэй. Улсын нэрийг Монгол улс, Үндсэн хуулийг Их засаг, их хууль гэдгийн аль нэгээр нэрлэх.

Нэг ийм захиа байна. Нэлээн ёсорхуу захиа байна. Та бүхний амар амгалан айлтгая. I-рт Чингисийн гал голомт гэдгээ бүү мартаачээ. Эвт шаазгай буга барина гэдэг юм. Эв хүчээ нэгтгээчээ, Их засаг хуулиа батлаачээ, Монгол улсын нэр 785 жилийн түүхтэй юм шүү. Төрийн сүлдэнд цагаан шонхор шувуут Чингисээс сонгосон цагаан шонхор шувуут цэлмэг тэнгэртээ мандуулъя. Төрийн далбааг өнгөрсөн үеийнхээс өөрчилъе.

Газар, нутаг өмчлөх эрхийг хот, суурин газруудад олгох нь зүйтэй. Эцэст нь хэлэхэд 1924 оноос хойшхи хугацаанд цайнаас салгаж, саруулаас теерүүлсэн, марксист хэмээсэн үзэл санаа, социализм хэмээсэн хоосон мөрөөцлөөр явж, туулж өнгөрсөн хэлмэгчдүүдээсээ салцгаая гэжээ.

ИРГЭН

Сүхбаатарын дүүргийн 6 дугаар хорооны ахмад багш Цогзолмаа, Дамдин нараас: -Мөн МОН-ын УБ-хотын зөвлөлдөх төвөөс их хурлын чуулганд нэг зүйлийг хүссэн байна. АИХ-ын II хуралдааны чуулганд: -Өнөөдөр монголын бүх ард түмэн түүний дотор ардчиллын төлөө чадах, ядахаараа тэмцэж ирсэн бид эрхэм депутат та бүгдийг монгол улсын ирээдүйн төлөө оюуц бодол, зүрх сэтгэлээ зориулж байгааг хараад, ардчиллын үр шимийг улам бүр мэдэрч байна. Депутат нөхөд өө, монголын нийгмийн харьцааг өөрчлөн хувьсгах тулгуур хуулийг батлах үйл хэрэгтээ хүн бүр өөр өөрийн мартагдашгүй хувь нэмрийг оруулах болтугай гэж хүсэн ерөөе. Хүний эрх чөлөөг дийлсэн ардчилсан монгол улс хөгжин бадартугай. МОН-ын УБ хотын чуулган гэжээ. 1991-ХI-19.

Сүхбаатарын районы 4 дүгээр хорооны өндөр настан 85 настай, Шамба гуай: -Эрхэм депутатуудын амрыг эрж, хурлын ажиллагаанд сайныг ерөөе. Эрхэм депутатууд аа та нар монголчууд өлсөж, зовж, байна гэж битгий яриач ээ, монгол хүн өлсөж үхдэг дээрээ хүрээгүй байна. Бүү муу ёрлоод бай. Монгол улсынхаа их хуулийг гаргаж чадахгүй бол та нар тарцгаа. Тэр ардчилсан сонгууль гэдгийг дахин явуулж ирээдүйг харсан шинэлэг үзэлтэй депутатуудаа сонгож, байж энэ хуулийг чинь хэлэлцвэл яасан юм бэ, би өдий наслахдаа олон сайн, муу юм үзсэн. Жижигхэн ч гэсэн хэлмэгдэж явлаа, одоо боллоо гэжээ.

За Говь хөдөлгөөнөөс ийм цахилгаан ирсэн байна. Монгол телевиз эрхлэн толилуулсан, II-р сарын 17-ны оройн мэргэдүүд ажаамуу, нэвтрүүлгийг үзэж гүнээ талархаж байна. Монгол хүний ирээдүй сэргэн мандалтын эхлэлийн түүхэн хариуцлагатай энэ

үед ийм нэвтрүүлэг хийсэн эрдэмтэн Бацраа гуай, Дулам зохиолч Бадарч сэтгүүлч, Баавар, зураач Чингисболд нарт гялайснаа уламжилъя. Энэ саналыг бүрэн цэмжиж байгаагаа илэрхийлье. Говь хөдөлгөөн гэжээ.

Нөгөө дэх нэг зүйл нь бол энэ талбай дээр болж байгаа өлсгөлөнтэй холбоотой зүйл. Өлсгөлөндөө Буцжав, Авирмэд гуайгаас гадна, Батцэнгэл гэдэг залуу нэмэгдээд, ингээд 3 хүн өлсөж байна, урьдчилсан байдлаар нэлээн олон депутатууд очиж, эндээс ч хүмүүс очиж ярилцсан, өчигдөр орой уг нь энэ тухай радиогоор телевизээр мэдээлэл дамжуулаад ингээд бууя, гэж тохиролцоонд хүрсэн байсан. Гэвч Отгонбаяр, хүмүүс одоо бид нарыг айлгаж сүрдүүлээд байна, гээд өчигдөр орой буух гэж байснаа болчихож, Тэгээд өнөөдөр 2,3 удаа манай хүмүүс Лоохууз гуай, тэргүүтэй комисс очиж уулзаж, ярилаа, тэд нарын тавьж байгаа шаардлага бол, үндсэн 2 шаардлагыг тавьж байгаа юм байна. I-рт АИХ-ын чуулганд ирүүлсэн баримтыг бүрэн эхээр нь АИХ-ын чуулган дээр уншиж сонсгооч зэ, I-рт, 2-рт Отгонбаяр, Ганзориг гэж 2-ыг урьдчилсан байдлаар тусгаарлаач ээ гэсэн ийм 2 шаардлага тавиад, энэ 2 шаардлагыг хүлээж авсан тохиолдолд өлсгөлөнгөө зогсооно, тэгээд, дараа нь хурлын үндсэн асуулт хэлэлцсэний дараа бид нарын асуудлыг анхаарч үзнэ гэдэгт итгэж байна гэсэн ийм асуулт тавиад байж байна. Тэгээд байдал ямар байгааг мэдэж байгаа, тэгээд их хурлын удирдлагын хэмжээнд яриад, ямар ч байсан энэ асуудлыг уншиж сонсгоё. Тэр хүнийг Отгонбаяр, болон Ганзориг нарын хэрхэх асуудлыг Улсын прокурор, дээд шүүхийн удирдлагатай хууль зүйн үүднээс нь ярилцаж, шийдэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгээд энгийн уншиъя.

-Нэлээн олон хуудас юм байна. Би их хурдан уншиъя.
БНМАУ-ын АИХ-ын чуулганд шаардах бичиг. УБ хот 1991-XI-12.
Хүний эрхүүдийг хаан хориглох, хорих, цөлөх, алах мэт харгислалын аргуудаар 70 гаруй жил тогтсон дэлхийн социалист систем гэж түүхийн хөгжлийн зүй тогтолд хэлбэр биш ү болохоо харуулан мөхөж, ардчилал, дэлхий даяар ялан мандсан Монгол улсад ч хамааран ардчиллын бодит хэрэгжилтийн анхны алхам болох

олон намын намт төрийн тогтолцооны үндэс тавигдаад 2 жил орчим болж байна. Энэ хугацаанд шинэ Үндсэн хуулийн төсөл боловсрогдож ардчилал, хүний эрхийг баталгаатай болгоход чиглэсэн хууль тогтоомжууд цөөнгүй гарч, ард олны зүй ёсны талархлыг хүлээсэн билээ. Гэвч ЗХУ-ын коммунист намын шууд удирдлагаар ажлаа явуулж ирсэн найрамдал нэртэй оросын колоничлох бодлогыг хамгаалсаар ирсэн монгол ардын хувьсгалт намын Цэдэнбалч шугамыг хамгаалагч хүчнүүдээс зонхилон бүрдсэн хуучин төрийн машин хүчин суларсан боловч хуучин нийгмийн дахин сэргээхийн төлөө ил далд аргуудаар улайран д тэмцсээр байна. Энэ аюултай хүчний нэг хэсэг нь тус улсын хуулийн салбарт амь бөхтэй бөхчин хуулийн бие даах, үл алагчлах хэмээх үндсэн 2 зарчмыг хөлдөө гишгэсэн Цэдэнбалч тогтолцооны чигийг тууштай баримталсаар байна. Энэ нь манайд ардчилал төгс ялахад бул хар чулуу мэт саад төдийгүй, хуучин дэглэмийг сэргээхэд бодит хүчин болох аюултай байна. Эрдэнэт хотод аж төрж байсан Авирмэд, Буджав, Уранчимэг бид нарыг зохимол хэргээр алах ял олон жил янз бүрийн дэглэмтэй шоронд хорих, ял зааж ардчилсан шударга хуульчид, түмний тууштай тэмцлийн хүчээр үнэн мөнийг олж, гэм буруугүй болохоор тогтоолгосныг монголын ард түмэн сайн мэдэх биз ээ. Рэтэл тэр хэргийг зохиож Отгонбаярыг алагчлан хэрэг тулгасан болж эрх дурээр нь байлгасаар Отгонбаярыг шууд ба шууд бус хамгаалан гэм зэмгүй биднийг алах хүртэл хошироох гэж улайрч байсан хуульчид Будрагчаа, Чимид, Чойном, Дэмбэрэлцэрэн нар хүн бүхэн хуулийн өмнө нэгэн адил зарчим ёсоор хуулийн хариуцлага хүлээх ёстой атлаа юу ч болоогүй юм шиг едий хүрснээр барахгүй, нэлээд нь гавьяа байгуулсан юм шиг төр, засгийн хууль, төр засаг, хуулийн дээд байгууллагуудад багтан хуулийг ардчилахад сөрөг хүчин болсоор байна. Төмөр-Очирын хүн амины хэргийг одоо болтол тодруулахгүй дарсаар тэр үед хариуцаж байсан, ажлын онцлогоор энэ хэргийн талаар тодорхой санал илэрхийлэх, мөн, НАХЯ гэгчийн ялт ажиллагааны талаар хариуцлага хүлээх ёстой генерал Жамсранжав, Цийрэгээн нар тухайн төрийн дээд байгууллагад идэвхтэй үүрэг гүйцэтгэсээр байгаа нь мөн дээрхийн адил аюултай хүчин болж байна. Тойрон хүрээлэгчдийн хэргийг бие даасан, алагчилцаггүй шүүхээр шүүн шийдвэрлэх нь хуучин төрийн машины аюулд ажиллагааг зогсоох чухал алхам болохыг билээ. Гэтэл Чимид тэргүүтэй дээрх

хүчин хууль шүүхийн бүх механизмдын жолоог гартаа атган, уул хэргийг алагчлан шүүсэн болж өнгөрөөхийн төлөө бүхнийг хийж байна. Хуулийн завхралын аюулыг арьс, махаараа амссан бид доорх шаардлагыг тавьж байна. 1. Зохиомол хэргээр биднийг үлэмж хохироосон Отгонбаярын хэргийг ардчилсан хүчнүүдийн жинхэнэ төлөөлөгчөөс бүрдсэн, бие даасан алагчилдаггүй, өөр шүүхээр шийдвэрлүүлэх, хэрэгтэн Отгонбаярыг хориход байлгах, 2. Будрагчаа, Чимид, Чойном нарыг хуулийн хариуцлагад татах. 3. Хууль завхруулагч Чимид, Дэмбэрэлцэрэн нарыг одоогийн албан тушаалаас нь ямар ч болзол тавилгүй шууд огцруулах. 4. Шамсранжав, Цийрэгзэн нарыг төрийн дээд байгууллагын хариуцлагатай ажлаас зайлуулах. Хуралдааны явцаас карахад Цэдэнбалч, зарим депутат ардчилсан хөдөлгөөний нэрт удирдагч, Зориг, Бат-Үүл нарын нэрийг гутаах замаар ардчиллын эрчийг сулруулах гэсэн МАХН-ын хорт бодлогыг цухалзуулж байгаад УБХ-ыг бүхэлд нь буруутгах оролдлогууд, цухалзаж байгаад үлэмж зөвүүцэн эсэргүүцэж, ингэхийн оронд хэрэгтэн Отгонбаяр саарал ордныхноор ганц худгийг дүүргэсэн хэн хэний хэлснийг, ЗХУ-д гарч баларсан төрийн эргэлтийг манайд хэн хэн ямар хүчин давахтааар завдаж байсан, МАХН гэмт хэрэгтэн мөн болохыг илчлэх талаар алхам хийх нь ардчиллын ашиг сонирхолд илүү нийцнэ гэдгийг тэмдэглэн ардчиллын ялалтын төлөө эх орныхоо тусгаар тогтнол, хөгжил дэвшил, ард түмний чинээлэг амьдралын ашиг сонирхлын төлөө ухаан, хүчээ дайчлан, бие биеэ харилцан хүндэтгэх, тэгш эрх эдлэх зарчмыг хатуу барин дахин хуралдахыг Монголын ард түмний төлөөлөгчид эрхэм депутат та бүхэнд уриалж байна. Бидний шаардлагыг чуулж буй депутатуудад уншин сонгохын дээр бидний шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх, тухайд тухай хариуг 1991 оны II-р сарын 15-ны 10 цагт АИХ-ын хуралд хүлээн авах байранд бидэнд тодорхой хариу өгөхийг мэдэгдье. Хэрэв хариу өгөхгүй буюу чуулганд оролцож буй депутатуудад сонордуулахгүй бол бид Сүхбаатарын талбайд өлсгөлөн эхлэх болно. Хуулбарыг Монголын хүний эрхийн холбоо *Эмисси интернэши* МОНГОЛЫН бүлэгт илгээв. Авирмэд, Буджав, Уранчимэг, Дамбий гэжээ.

За дараа нь бас нэг хавсаргасан зүйлээр УБХ-ын нарийн бичгийн дарга Чимид жинхэнэ нүгэлтэн буюу зүсээ хувиргасан

жүжигчин байсан нь үнэн юмаа, гэсэн 3 хуудас зүйл байна. Энийг унших уу, За тэгвэл уншъя.

Монголын хууль зүйд ихээхэн балаг тарьж, хэлмэгдлийг бий болгох үндсийг Чимид 1982 оноос эхлэн Улсын дээд шүүхийн даргаар ажилласан тэр үеэс эхэлсэн юм. Хар тогтоол гэж ЗИ6 дугаар тогтоолын үндсэн материалыг бэлтгэгч нь Чимид юм. Чимид энэ тогтоолыг хэрэгжүүлэхийн тулд тэр үед шударгаар ажиллаж байсан шудар олон хуульч, шүүгчдийг хяжан хавчих, ажлаас нь халах, ял шийтгэлд гүтгэн унагаж, цуст нүгэлд хутгасан юм, тухайлбал I-рт, гавьяат хуульч Лувсаншарав, Санжмятав, ахмад шүүгч Намхай, Гомбосүрэн, Рүдэв, прокурор Сүхбаатар, Чимэддулам, Доржбадам, Лочин, Цэндсүрэн, Баянжаргал зэрэг олон арван хуульчдыг хэлмэгдүүлж цаашид, ажиллах замыг нь хааж, харанхуй нүхэнд унагаж байсныг баримт нотолно. 2-т нь Чимид нь ЗИ6 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх нэрээр шүүн таслах ажиллагааг харгислан хэрцгийлжүүлж байсан юм. Тухайлбал хууль зүйн нотлох баримт хангалттай нотлогдоогүй байхад нь заавал шийтгээ гэж үүрэг өгч, хорих газар руу хүмүүсийг бөөн бөөнөөр илгээж байсан юм. Зөвхөн 2-хон бүлэглэл, эмч нарын байлагийн хэрэг, гэхэд асар олон хүн хилсээр шийтгэгдэж, хохирч байсан юм. Чимид улсын дээд шүүхийн дарга байх үедээ 3 жилийн жилээс дээш ял шийтгүүлэх зүйл хэрэгтэнг заавал чанга дэглэмтэй колони д шийтгэж бай гэдэг үүргийг доод шатныхаа шүүхэд үүрэг болгон гүйцэтгэлийг өөрөө аздаг байсны үр дүнд Чимидийг улсын дээд шүүхийн дарга байх хугацаанд монгол улсын ялтны тоо 10 мянга хүрч, бөөнөөр хорих ялгэрийн тоо эрс өссөн юм. Үүний нэг давхар нотолгоо нь эрдэнэт хотын агент Дугархорлоогийн амь насны хэрэгт хилсээр холбогдсон Авирмэд, Буджав, Уранчимэг, Чимэдбальдирмаа нарыг бид нарыг УП-ын орлогч байсан Отгонбаяраар толгойлуулсан хэсэг хуульчид зохиомлоор хэрэг бүрдүүлсэн улсын дээд шүүхийн гишүүн Чойном, удаа дараалан уншиж танилцаад, энэ хэрэг бүрдэлт дутуу байна, иймд мөрдөн байцаагаад байцаалтанд буцаах саналыг тухайн үед улсын дээд шүүхийг толгойлж байсан Чимидэд оруулахад би хариуцна, заавал тасла гэдэг үүргийг Чойномд өгч, Авирмэд, Буджав, Мянмар бид 3 хүнийг цаазаар хороолгох ялаар шийтгүүлж, Уранчимэг, Чимэдбальдирмаа гэдэг 2 эмэгтэй 4-15 жилээр чанга

дэглэмтэй эмэгтэйчүүдийн колонид ял шийтгүүлж, Авирмэд, Буджав, бид 2-ыг цаазаар хороох нь зүйтэй гэсэн саналыг АИХ-д Чимид оруулж байсанг сэтгүүлч зохиолч Барамсай улаан нулимс гэдэг нийтлэлд хурлын протокол бүрэн эхээрээ **нийтэлснийг** та бүхэн санаж байгаа байх аа. Энэ саналыг хууль цаазны эрдэмтэн Чимид мэдлэг, чадвар дутсандаа оруулаагүй нь ойлгомжтой. Улсын дээд шүүхийн гишүүн Чойномд би хариуд нь чи заавал тасал, би хариуцна гэж үүрэг өгч байснаа биелүүлэх зорилгоор бид 2-ыг амь насаар золиосхийж байсан ялт хэрэгтэнг хариуцлагад татагдахын оронд төр, засгийн өндөр албан тушаалд авиран гарч бусдын гараар дахин нүгэл үйлдүүлсээр байгаа нь хуульчдын үйл ажиллагааг цэвэр ариун байлгахад асар их саад тотгор болж нийгмийн эрүүл саруул, байдлыг алдагдуулж байна. Үүний ганц, нэг жишээг авч үзье . 1991 оны засагийн газрын 20 дугаар тогтоол зөрчсөн хүмүүсийн нэрс 15, Чимид гэж бичигдсэн нь бодит баримтаар нотлогдож байгаа **биш үү**. Энэ баримтыг тодруулбал банкнаас ирсэн нэрсийн жагсаалтанд Чимидийн нэр одоо улсын прокурорын I-р орлогч Одонхуугийн эхнэрийн нэртэй хамт ирснийг прокурор Одонхуу, Чимидийн нэрийг эхнэрийнхээ нэрийнхээ нэрийн хамт хасч, шалгалтын хүмүүсийг та нар улсын нууцыг задруулж болохгүй гээд, шударгаар явагдаж ёстой байсан шалгалтыг Одонхуу зогсоож байжээ. Чимид өөрийнхөө нүгэлийг нуун хаацайлж, зусардан бялдуулчилсан хүмүүсийг ямарч ^{үд}үндэслэлгүй, өндөр албан тушаалд тавих ба Америк, Япон, Хятад, зэрэг улс орноор үр ашиггүй хэсүүлэн, шан харамж хүртээн нийгмийн хөрөнгийг үрэгдүүлж байна. Чимидийн зөвхөн гэмт хэргийн шинж бүхий баримтууд нь одоо бидэнд мэдэгдэж байгаагаар иймэрхүү байна. Иймд Чимид тэргүүтэй Отгонбаяртангууд нууц, далд аргыг хэрэглэн одоогийн хэлмэгдлийг үргэлжлүүлж байгаа үйл ажиллагаанд бодит дүгнэвт хийж, энэ хүний ажлын хариуцлагы нь хувьд ч ёс суртахууны хувьд ч ард түмэн шүүн тунгаах цаг нь болсон гэж үзэж байна. Хуульчдын хэлмэгдэл зогсоогдохгүй, эвдэгдсэн, хохирсон хүний эрх сэргээгдэхгүй, хуулийн байгууллагын ажилтны үйл ажиллагаань шударга ёс, шударга зарчим хэрэгжихгүй, ар өврийн хаалгаар ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд мултран гарч байна. Элдвийн хорт ажиллагаа Чимидийн сүүдэрт нуугдан үлдсээр байна. Иймд Чимидийг засаг

төрийн нэр хүндтэй, сүр хүчтэй энэ албан тушаалаас нь сонгууль хүлээлгэлгүй, одоогийн энэ журалдаанаар өнөө маргаашийг хүлээлгүй, яаралтай зайлуулахыг нийгмийн шударга ёсны өмнөөс хэлмэгдэн хохирсон буюу одоо хохирч зовж, зүдэрч яваа ард түмний өмнөөс шаардаж байна. Та бүхний сайн мэдэх Отгонбаяр гэгчийн дуулиант хэрэг шударгаар шийдэгдэж чадахгүй 2 жил болж, одоо энэ хэрэг шүүхээс бүрдэл дутуу нэрээр буцах болж байна. Энэ хэрэгт хилсээр цаазлагдах хүртэл хохирч явсан Авирмэд, миний амь нас руу зэвсэглэн дайрах Буджавт эд материалын хохирлыг үзүүлээд байгаа нь ямар ч эргэлзээгүй Отгонбаяртангуудын үйл ажиллагаа юм. Отгонбаяртангууд бүрэн 2 жил хэрэг шалгуулсан нэрээр юуг л хийе гэснээ хийж, гэмт хэргээсээ мултрах арга замаа хайж нүхээ ухсаар, хорлоё гэснээ хорлж, гүтгээ гэсэн хүнээ гүтгэсээр өдий хүрэхэд Отгонбаяртангуудын гарт урьд хэлмэгдсэн Авирмэд, Буджав болон бусад шударга хуульч, сэхээтэн, сэтгүүлчид, сэтгэл санаа эд материалын хохирлыг удаа дараа хүртсээр өдий боллоо. Иймд:

1. Отгонбаярыг, түүний гар хөл бологч төлөөлөгч Ганзоригын хамт нийгмээс тусгаарлан шалгах,
2. Чимидийн нүгэлт үйл ажиллагаа, ард түмэнд ил тодоор илрэхгүй байгаагийн гол голцоо нь одоогийн хуулийн байгууллагыг толгойлж байгаа хүмүүс Чимидийн гар хөл дуулгавартай зарцууд байгаад оршино.

Иймд Улсын прокурор Бахдал, Улсын дээд шүүхийн дарга Дэмбэрэлцэрэн, тэдгээрийн орлогчид, Оцонхүү нарыг Улсын бага хурлын нарийн бичигийн дарга Чимидийн хамтаар огцруулах, мөн тус байгууллагын нийт бүрэлдэхүүний 60, 70 %-ийг өөрчлөн шинэчлэх, сонгон шалгаруулах зарчмыг баримтлан шударга мэдлэг чадвартай хуульчдаар шинэчлэхийг шаардаж байна. Шударга шаардлага, шаардлага тавьсан Мөнхнасан овогтой Авирмэд, Чүлтэм овогтой Уранчимэг, Батцэрэн овогтой Буджав болон бусад хэлмэгдэгсэд гэсэн байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

Ардын Их Хурлын орлогч дарга Н.Батбаяр:

-БНМАУ-ын Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан, БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат нар танаа гэсэн зүйлийг БНМАУ-ын Ерөнхий прокурор Г.Бахдал, Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч М.Одонхүү, Ерөнхий прокурорын орлогч Алтанхуяг нар 1991 оны 11 дүгээр сарын 20-нд ирснийг уншъя.

Бид БНМАУ-ын Прокурорын байгууллагын удирдлагад томилогдон нэг жил гаруй хугацаанд энэ өндөр, хүнд албыг чадан ядан хашигдаа захиран тушаах дэглэмийн үед прокурорын байгууллагын үйл ажиллагаанд бий болсон гажуудлыг арилган дэлхийн соёлт улс орнуудын төрийн тогтолцооны нийтлэг жишигт дөхүүлэх алхам хийх боломжийг аль болохоор дүүрэн ашиглаж эх орондоо иргэний ардчилсан нийгмийг цогцлон байгуулах үйлсийн эхлэлийг тавихад өчүүхэн ч атугай хувь нэмэр оруулсан гэдэг чин эрмэлзэлд хөтлөгдөн зүсэн зүйлийн шахалт дарамтыг үл хайхран гагцхүү хуулийг эрхэмлэн дээдлэх зарчмыг удирдлага болгон ажилласан билээ.

Гэтэл сүүлийн үед үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх, тэр ч байтугай хэсэг бүлгийн буюу хувь хүний атгаг сонирхлын үүднээс урвуугаар ашиглаж хууль зүйн болоод бодит үндэслэлгүй шаардлага тулгах, шүүмжлэх нэрийдлээр гүтгэн гүжирдэх, худал цуурхал тарааж нэр алдрыг гутаахыг оролдох зэргээр шахалт дарамт үзүүлэх явдал улам эрээ цэвэргүй шинж төрхтэй болон даамжирч эхлэв.

Хамгийн сүүлчийн баримт дурдахад энэ сарын 19-ний өдөр Сүхбаатарын талбайд суулт хийсэн этгээдүүд Улсын прокурорын газрын удирдлагыг огцруулах шаардлага тавихдаа Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч М.Одонхүүг ор үндэсгүй гүтгэн гүжирдсэн зүйл самбарт бичиж олон нийтэд сурталчлан байгааг монголын радио мөн өдрийн үдээс хойш улс даяар

хэд хэдэн удаа олзуурхан мэдээлэв. Иймд Улсын прокурорын газрын удирдлагын эсрэг үйлдэж буй гүтгэлэг явуулгуудыг БНМАУ-ын Ардын Их Хурлаас нэн даруй шалгаж төрийн албан тушаалтны хувьд бидний нэр төрийг сэргээж өгөхийг хүсэхийн хамт хуулийн байгууллагын ажилтан үүргээ гагцхүү хуульд захирагдан хэрэгжүүлэх эрхийг нь хамгаалах хууль зүйн болоод нийгмийн бодит баталгаагүй энэ нөхцөлд Улсын прокурорын байгууллагыг удирдах хариуцлагатай ажилд цаашид гүйцэтгэх боломжгүй байгааг Ардын Их Хурлын II хуралдаанд уламжлан шийдвэрлүүлж өгнө үү. Ерөнхий прокурор Г.Бахдал, нэгдүгээр орлогч М.Одонхуу, орлогч Алтанхуяг.

М. Уртнасан: -Та бид хөдөлмөрдөөс ирсэн мэдээлэл, Ерөнхийлөгч болон Их Хурлын даргын нэр дээр ирсэн зарим гомдол, мэдээллийн чанартай зүйлүүдийг сонсож байгаа юм. Нэгэнт манай депутатуудын нэр төр, манай хурлаас байгуулсан байгууллагатай холбогдолтой зарим гомдол байгаа учраас бид хуулийн зөвлөхүүдтэйгээ зөвлөж депутатын комисс байгуулж энэ асуудлыг шалгаж үзэх нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа. Бид хуулийн зөвлөхүүд, хуульчидтайгаа ярилцаж байж энэ комиссыг байгуулж, та бүхэнд маргааш мэдээлнэ.

Зарлалын чанартай хоёр зүйл байна. Өчигдрийн эмгэнэлт явдлыг бид санаж байгаа. Бид хамгийн хурдан хугацаанд эмнэлгийн тусламж үзэх боломж байна уу, үгүй юу гэдэг асуудал баталгаагүй байсныг та бид харсан. Тийм учраас өнөөдөр бид зориуд эмнэлгийн нөхдүүдтэй уулзаж манай депутат эмч нар ажлыг зохион байгууллаа. Ордны 254 дүгээр өрөөнд нэлээд сайн тоногдогдсон эмнэлгийн групп эмч нар байгаа. Энэ танхимын зүүн хойд талын "Е" өрөөнд бас эмч байрлаж байгаа. Зүүн хойд талын "К-3" гэсэн өрөөнд. Зүүн урьд талын I дүгээр давхарт аптека байгаа. Цусны даралт ихтэй хүмүүс, ер нь даралт ихтэй хүмүүс даралтаа үзүүлбэл 2307, 2763 гэсэн утсаар эмч дуудаж даралтаа үзүүлж болно. Даралтын эмийг, өөрийнхөө эмийг рецепээ өгөөд захиалж болно. Энэ утасны дугаарыг хэлье. 2307, 2763. Галуур утас хэрэв буудлаас ярих бол

29041.

Хоёрдугаарт, депутатуудын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэн эндээ түр үлдэхийг зарлаж байна.

Б.Чимид: -Тэгэхээр наад комисс чинь ямар комисс гарах гэж байна вэ? Чимидийн асуудлыг шалгах комисс юмуу, эсвэл тэр улсуудын тавьсан асуудлыг шалгах комисс юмуу? Чимидийн асуудал байгаа гэж үзэж байгаа юмуу? Би та нарын сөрөг тавьж байгаа асуудал биш шүү. Тэгэхээр Авирмэд нар асуудал тавьжээ. Тэр тавих хүний эрх нь юм. Тавьж бололгүй яах вэ? Тэгэхээр шалгах асуудал чинь юу байх юм бэ? Миний хүсэлтээр шалгаж байгаа юмуу? Тэр улсын хүсэлтээр шалгаж байгаа юмуу?

Надтай холбоотой асуудал гээд нэг юм ярилаа шүү дээ. Хуулийн зөвлөхүүдтэй тохироод комисс гаргахаар боллоо гэсэн. Тэгэхээр тэр чинь одоо Чимидийн асуудлыг шалгах комисс гарч байгаа бол прокурор нь бол еер хэрэг. Минийхийг уншаад орхино гэдэг бол бас болохгүй л дээ. Миний талаар ярьсныг. Тэгэхээр энэ асуудал бол их том том гэмт хэргийн юм хэлж байгаа юм байна. Тэгэхээр цаад хүмүүс ойлгож байдаг байгаа. Зарим нь тодорхой хүний нэлээн том алба хааж байсан хүний сонинд бичсэн юмнаас авсан байна. Би тэр хүний нэр дурдаад яах юм. Ер нь онц биш. Би одоогоор тэдэнтэй зарга хийж байгаа юм алга. Их олон яригдсан асуудал. Бичигдсэн ч асуудал. Энэ ингээд шалгана гэвэл миний зүгээс хэлэх юм байх ёстой. Хэлэх юм байх ёстой нь бол би юу бодоод байгаа вэ гэхээр, гэмт хэрэг хийчихжээ гээд хэлээд байх юм байхгүй гэж бодож байгаа юм. Ажлын дутагдал байсан байж болно, байлгүй яах вэ дутагдал бол.

Тэгэхээр энэ чинь цөмөөрөө прокурор хүний мөрдсөн хэрэг байна шүү. Дээд шүүхийн тодорхой хүн тасалсан, тодорхой коллеги нь хянасан, тодорхой хүн Их Хуралд илтгэсэн, Их Хурлын Тэргүүлэгчид би өөрөө байгаагүй үед шийдсэн, миний оролцсон зүйл бий. Ингээд ирэхээр энэ хүмүүс

чинь өөрөө шалгаад ирэхээр нэг материал гараад ирнэ. Үндэсгүй байна гэдэг юмуу, гэмт хэрэг биш байна гэдэг юмуу? Гэмт хэрэг гээд гараад ирвэл наад улсууд чинь эргээд өөрсдөө уначих вий. Би энийг хүсэхгүй байгаа юм. Юу гэдэг юм, нэгийгээ үгүйсгэсэн тийм бодлого надад байхгүй. Ийм учраас сайн бодох ёстой юм. Өөрөөр хэлбэл, бичсэн хүмүүсийн тухай асуудал гарна. Гэмт хэрэг гэсэн үгийг бичсэн байна. Энийг тэр улсууд бичээгүй байж магадгүй шүү. Тийм учраас тэр өлсөж байгаа улстай та нарын хариуцах уг юмуу, үгүй юу гэдгийг мэдэж байж үзэхгүй бол нэг ацан шалаанд орно. Биш гээд гараад ирнэ. Тэгэхээр юу болох вэ гэхээр нөгөө улс чинь Эрүүгийн хуульд заасан гүтгэсэн хэрэгт орчих гээд унавал яах юм бэ? Гомдлоор үүсгэдэг хэрэг биш, надаас шалтгаалахгүй болчихно шүү дээ. Би бол асуудлаа тоймлож байгаа учраас тэр улсыг намайг сүрхий гүтгэчихлээ, гүтгэлгийн чанартай зүйл энд олон байна. Тийм учраас би бол гүтгэлэг гэж үзэх үндэстэй болоод байна. Энийг ойлгож байна уу.

Тэгтэл тэр улс чинь өөрөө өөрийнхөө юманд уначихвал би бас дахиад нэг юманд орно. Яагаад вэ гэхээр, одоо унагаасан, шийтгүүлэх гэж оролдсон юу гэдэг юм. Энийг ч би авч үзээд байна, би. Тийм учраас хэрвээ би дуулсан, би энд больё гэхихээд би улсуудаас асууж байж больё гээд буцаж ирээд байгаа юм шиг байна лээ. Тийм мэдээ үнэн бол энэ хэдэн хүн хүний түлхээсээр өөрснөө золиос гэж хэлэх нь ч юу юм бэ? Хуулийн өмнө юмтай тулгарах вий гэж. Хэрэв тэд нарт ингэж хэлбэл, би хэлбэл, түрэмгийлсэн хандлагатай юм болж сонсогдоно. Ийм учраас их нарийн хандаж үзээрэй. Шалгалтын томъёогоо бол Буджав нарын тавьсан асуудлыг шалгах гэж эхлээд хэлэх байх. Тэгээд намайг шалгахдаа хүрвэл депутатын бүрэн эрхийн асуудал болно гэдгийг хэлчихмээр байна.

д. Уртнасан: —Уучлаарай, Чимид дарга аа. Бид тэр талаас нь биш, та арай буруу ойлгох шиг боллоо. Тэгэхээр бид Буджав, Авирмэд нарын гомдол талаас нь биш БНМАУ-ын Ерөнхий прокурор Г.Бахдал, Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч М.Одон-

хүү, Ерөнхий прокурорын орлогч Алтанхуяг нарын манай Их Хурлаас байгуулсан байгууллага, энэ Ардын Их Хурлаас нэн даруй шалгаж, гүтгэлэг явуулгыг барагдуулж, төрийн албан тушаалтны нэр хүндийг сэргээж өгнө үү гэсэн энэ хүсэлтийг л бид эрхийнхээ дагуу мөргөжлийн хүмүүсийг явуулж учир зүйт нь олъё гэсэн санал тавьж байгаа юм. Түүнээс бий бид энэ асуудлыг ингэж өндөр хэмжээнд ярихгүй ээ.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг